

АГУУЛГА

- П.Оюунчимэг
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахад цаашид анхаарах зарим асуудал 9

- Ж.Бямбаа
Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалтууд Монгол Улсын байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжиж байгаа нь 14

- Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2006 оны 1 дүгээр сарын 18-нд зохион байгуулсан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглох нь” сэдэвт зөвөлгөөнд тавигдсан илтгэлүүд.
 - Ж.Дашдорж
Эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал 24

 - Х.Алтанзүрх
Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэхэд прокурорын байгууллагын үүрэг оролцоо 32

 - Б.Галдаа
Цагдаагийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд илэрч буй эрүү шүүлт, хүнлэг бус арга, ажиллагааны тухай 36

- Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэлийн, нэгдүгээр бүлэг: /2006/ Эрүү шүүлт ба хүний эрх 44

- НҮБ-ын Эрүү шүүлтийн асуудлаарх Тусгай илтгэгч Манфрэд Новакийн Монгол улсад ажилласан тухай илтгэл 80

CONTENT

- P.Oyunchimeg
International Convention Against Torture and its implementation 9

- J.Byambaa
Implementation of provisions of the International Convention Against Torture in Criminal Procedure Code of Mongolia 14

- **Reports from conference organized by NHRCM, Prohibition of the torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment**
 - J.Dashdorj
Implementation and condition of laws related to torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment 24

 - Kh.Altanzurkh
Intervienience from Procecutors office, in prevention from torture 32

 - B. Galdaa
Torture and other cruel, inhuman or degrading treatment, founded in activities of the Police organizations 36

- **Report on human rights and freedoms in Mongolia by NHRCM, 2006, /Torture and human rights/** 44

- **Report by the Special Rapporteur on torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment, Manfred Nowak Mission to Mongolia** 80

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ, ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ЦААШИД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

П.Оюунчимэг
ХЭҮК-ын Ажлын Албаны дарга,
магистр

Монгол Улсын Их Хурал 2000 оны 11 дүгээр сарын 2-нд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын 1984 оны Конвенцид нэгдэн орсныг соёрхон баталснаас хойш 5 жилийн хугацаа нэгэнт өнгөрчээ.

Энэ Конвенци бол хүний хувийн эрх, ялангуяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хамгаалах арга механизмыг тогтоож, эрүүдэн шүүх гэж чухам юуг хэлэх, хэрэв эрүүдэн шүүгдвэл түүний эрх зүйн үр хөврөл ямар байх, эрүүдэн шүүлтэнд өртөгсөдийн эрхийг хэрхэн хамгаалах, үндэсний хууль тогтоомжинд энэ үйлдлийг хэрхэн тусгах, олон улсын түвшинд ямар хяналт, судалгаа явуулах, зэргийг тод томруун тусгасан чухал баримт бичиг юм.

Конвенцид “ Эрүүдэн шүүх “ гэдэг ойлголтонд чухам юуг хамруулахыг маш тодорхой заасан. Энэ тодорхойлолт бол хүн төрөлхтөний үе үеийн шилдэг тэмцэгчдийн олон зууны туршид эрүүдэн, тамлан зовоохын эсрэг явуулж ирсэн нүсэр тэмцлийн үр дүн, шаналсны гашуун сургамжийн бодит томъёолол юм.

Конвенцийн 1 дүгээр зүйлээс үзэхэд:

- а) Эрүүдэн шүүх гэмт хэргийг үйлдэгчид нь: төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй этгээд байдаг.
- б) Хууль бус ажиллагаа нь: айлган сүрдүүлэх, албадах, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхаж, бие махбодь, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах аргаар хэн нэгнээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, улмаар шийтгэхээр илэрдэг байна.

Энэ баримт бичгийн бодит хэрэгжилт ямар түвшинд байгаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хир үр дүнтэй байгаа цаашид анхаарах зарим асуудлын талаар ХЭҮК-ын өнгөрсөн нэг жил гаруйн хугацаанд хийсэн хяналт шалгалт, ажиглалт судалгаа, иргэдээс ирж буй өргөдөл гомдлын баримтан дээр түшиглэн өнгөцхөн ч болов гаргахыг оролдьё.

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэвшиж тогтсон олон арга ажиллагаа, хэм хэмжээ нь эрүүдэн шүүх бодит бололцоог нөхцөлдүүлж байна гэж хэлэх үндэстэй.

Манай улсын эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй зарим хүмүүсийг түр саатуулах, албадан саатуулах, цагдан хорих эрхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид олгосон. Харамсалтай нь албан тушаалтнууд энэ албаны онцгой эрхийг хавтгайруулан хэрэглэж, зарим тохиолдолд гэрч хохирогчоос бусдын тухай мэдүүлэг авах, сэжигтэн яллагдагчаар хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болгох нь байна.

Үүний нэг тод баримт бол долоо хоногийн Баасан гаригийн үдээс хойш иргэдийг албадан саатуулдаг явдал юм. 2001 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар Баянзүрх дүүргийн албадан саатуулах байранд хоригдож байсан 51 хүний 16-г нь буюу 32 хувийг мөн оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Баасан гаригт саатуулсан байлаа. Энэ нь Бямба, Ням гаригт нэг талаас ямар нэг байцаалт хийгдэхгүй, нөгөө талаас гомдол, зарга гаргах, прокурорт тэр бүр хандах бололцоогүй болдогтой холбоотой сэжигтнийг албадан саатуулах хуульд заасан шаардлагыг зөрчсөн, залхаах дарамтлах арга юм. Үүнийг хуулийн байгууллагын ажилтнууд ч хүлээн зөвшөөрдөг ба албадан саатуулахыг ард иргэдийн дунд “Цагдаагийнхны хүнээр тоглодог гурван хоног” гэж нэрлэдэг байна.¹

Тэгвэл энэ байдал одоо ямар байгааг харьцуулахад баривчлах төв гэж нэрлэх болсон энэ байранд 2005 оны эхний 6 сарын байдлаар нийт 978 хүн баривчилсны 919 буюу 93.9 хувийг нь хойшлуулшгүй тохиолдол гэсэн үндэслэлээр, дөнгөж 59 хүнийг буюу 6 хувийг ЭБШХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу шүүхээр тогтоолыг нь батлуулсны дараа баривчилсан нь анхаарал татаж байгаа байна.

Ноцтой нь эдгээр 978 хүнийг бүгдийг нь дандаа ажлын бус цагаар баривчлах төвд хүргэн ирсэн байх.

ЭБШ хуулиас үзэхэд хэрэг бүртгэлт урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд цагдан хорихыг дотор нь сэжигтнээр цагдан хорих, яллагдагчаар цагдан хорих гэж хоёр ангилдаг. Хуулиас үзэхэд “онцгой” тохиолдол гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдэд ял сонсгохын өмнө таслан сэргийлэх арга хэмжээ авч болохоор заасан. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын практик ажиллагаанаас харахад албан тушаалтнууд **нэгдүгээрт:** хуулийн энэхүү “онцгой тохиолдол” гэсэн тодотголыг анхаарч үздэггүй, **хоёрдугаарт:** таслан сэргийлэх бусад арга хэмжээг авч болох боломжтой байхад зөвхөн цагдан хорихыг урьтал болгодог байна.

Тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн эсэх талаар шалгалт хийгдээгүй, дөнгөж эрүүгийн хэрэг үүсгээд, уг хэрэг нь шүүхэд очих эсэх нь

¹ “Зууны мэдээ” сонин, 2001-8-2, №178

тодорхойгүй, ер нь хэрэг гарсан эсэх, хэрэв гарсан бол уг хэрэгт энэ хүн холбоотой эсэх ямар зүйл ангиар буруутгагдах эсэх нь огт харанхуй тодорхойгүй байхад сэжигтнээр тооцож, улмаар цагдан хорих гэж махран хөөцөлдөж, хорьж байгаа явдал нь сэтгэл санаа улмаар бие махбодийн шаналал, дарамтын дор хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах сонирхол, оролдлоготой зайлшгүй холбоотой.

ЭБШХ-иас үзэхэд онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл удаа дараа ял шийтгэгдэж байсан буюу онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн мөрдөн байцаалтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайсхийж болох үндэслэл байна гэж үзвэл яллагдагчаар цагдан хорьж болохоор байна.

Өнөөдрийн Эрүүгийн хууль нь (2002 он) нийтдээ 352 үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцсон байх бөгөөд үүнээс 65 үйлдлийг хөнгөн, 185 үйлдлийг хүндэвтэр, 68 үйлдлийг хүнд, 34 үйлдлийг онц хүнд гэмт хэрэгт тооцжээ.

Үүнээс үзвэл гэмт хэрэгт холбогдогчдын дийлэнх хэсгийг нь зөвхөн холбогдсон хэргийнх нь ангиллаар нь цагдан хорьж болох байна. Онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах үйлдэл нь гэмт хэрэгт тооцогддог нийт үйлдлийн 81.5 орчим хувийг эзэлж байна. Түүгээр ч барахгүй хөнгөн гэмт хэрэгт холбогдогчид, жирэмсэн буюу хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг “оргон зайлсхийсэн буюу оргон зайлж болзошгүй, өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн бол” хорьж болохоор байна.

2005 онд 6966 хэрэгт 10153 хүн шүүхээр ял шийтгүүлсэн ба үүнээс 3136 хүнд хорих ял оноожээ.² Гэтэл 2004 онд 2818 яллагдагчаар цагдан хоригдсон байна. Үүнээс эмэгтэйчүүд 259, хүүхэд 262, 2005 онд 3069 хүн яллагдагчаар цагдан хоригдсоноос 314 эмэгтэй, 251 хүүхэд тус тус хоригдсон гэсэн дүн мэдээ байна.³

Манайд хорих цагдах явдал хэт хавтгайрсан, хэрэг хүлээлгэх гол хэрэгсэл болсон ба Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын “Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй” гэсэн заалтыг шууд, илтээр зөрчиж байгааг харуулж байна.

Судалгаанаас үзэхэд: Монгол улсын анхан шатны шүүх 2005 онд 12233 хүнд холбогдох 8231 эрүүгийн хэргийг хүлээн авч 662 хүнд холбогдох 363 эрүүгийн хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцаасан байна.

Шүүгдэгч хохирогч эвлэрснээр 254 хүнд холбогдох 195 хэргийг, 372 хүнд холбогдох 185 эрүүгийн хэргийг цагаатгах тогтоолоор тус тус

² Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны талаархи мэдээ, 2005 он

³ ШШГЕГ-ын 0461-р ангийн дүн мэдээнээс

хэрэгсэхгүй болгосон нь өмнөх жилүүдийн дүн мэдээнээс харахад ихээхэн дэвшилттэй байдал ажиглагдаж байна.

Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэгт холбогдуулан хүмүүсийг олноор нь цагдан хорьж, хэргийг прокурорын хяналтын шатанд нарийн шалгаж тогтоолгүйгээр шүүхэд шилжүүлснээс дээрхи хэргүүд хэрэгсэхгүй болгогдож цагаатгагдаж байгаа нь харагдаж байна.

Тэгвэл эдгээр олон хэргийн цаана хэдэн хүн хэд хоногоор хилсээр хоригдон шалгагдсан нь тодорхой бус.

2. Хорьж мөрдөх хугацааг хэт олон сараар тогтоосон, хорих хугацааг сунгахад тавьж буй прокурорын хяналт хангалтгүй, хоригдсон хүнийг заавал хориотой чигээр нь шүүхэд шилжүүлдэг зэрэг нь эрүүдэн шүүхийн янз бүрийн хэрэг гарах бас нэг нөхцөлийг бүрдүүлж байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ-иар (69 зүйл) хүндэвтэр, хүнд онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 24 сар, цаазаар авах ял оногдуулж болох хэрэгт холбогдогчдыг нэмж 6 сар нийтдээ 30 сарын хугацаагаар хорьж болохоор заажээ. Манай улсын хуулийн энэхүү хэм хэмжээг олон улсын стандарт хэм хэмжээтэй харьцуулж үзэхэд яах аргагүй хэтэрхий олон хоног, сар, жилээр хорих боломжийг мөрдөн байцаах шатанд олгосон нь эцэстээ хүнийг залхаах, дарамтлах, улмаар хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болж байна.

2005 оны цагдан хорих төвийн мэдээнээс харахад 10 хүнийг 2 буюу түүнээс дээш жилээр цагдан хорьж байгаа баримт байна.

Удаан хугацаагаар хатуу хүнд нөхцөлд хорьж цагдсанаас болж иргэн хүн яаж хохирдогийг ганцхан баримтаар хэлье.

“Food Land” худалдааны төвийн манаачийн амь насыг хохироосон гэх хэрэгт холбогдон шалгагдаж байсан хүмүүсээс энэ хэргийн яллагдагч Б гэгч 9 сар хоригдсоны эцэст уушигны сүрьеэгийн хүндрэл гэсэн оноштойгоор нас барсан /ар гэрийнхэн нь өөр шалтгаан хэлдэг/.

Энэ хэрэг бүтэн 6 жилийн турш шалгагдсан хэрэгт холбогдож байсан хүмүүс 300-1200 хоног хүртэл цагдан хоригдож байсан байна. Эцэстээ шүүхийн цагаатгах тогтоол гарч эдгээр хүмүүсийн хэрэг эцэслэн шийдэгдсэн билээ. Энэ бүх хугацаанд хүнд гэмт хэрэг үйлдсэн, оргон зайлж болзошгүй гэсэн жижүүрийн үндэслэл гаргасан байлаа.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад: (9-р зүйл)

- Эрүүгийн хэргээр баривчлагдсан буюу саатуулагдсан хүн бүр хүнээ аль болохуйц ахар богино хугацаанд шүүхээр хэлэлцүүлэх буюу суллуулах эрхтэй.
- Насанд хүрээгүй яллагдагчийг аль болохуйц богино хугацаанд шүүхэд шилжүүлж шийдвэр гаргуулна (10-р зүйл) гэж тус тус заасан.

Үүнтэй ижил төстэй үүргийг манай Хүүхдийн эрхийн Конвенц, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Конвенциудаар бас давхар авчээ.

Одоо мөрдөгдөж буй ЭБШХ-нд насанд хүрээгүй хүнийг хорьж мөрдөх нийт хугацаа нь 18 сар хүртэл байж болохоор заасан (366-4-р зүйл). Тэгэхлээр Пактад заасан “аль болохуйц ахар богино хугацаа”-тай манай 30, 24, 18 сарын хугацаанууд аль хир тохирч байна вэ? гэдэг зүй ёсны асуулт гарна.

Бидний бодоход хоёр жил хагас, хоёр жил, нэг жил хагасыг явч ахар богино хугацаа гэж хэлэхгүй. Үүнтэй холбоотойгоор ер нь хэзээнээс хууль тогтоомжид ийм хугацаа орж ирэв, ямар үндэслэл шалгуураар тогтоов гэж сонирхож үзэхэд:

- Үүнтэй холбоотойгоор тэмдэглэхэд: Хаант Монголын Зарлигаар тогтоосон Хууль Зүйлийн бичиг “ хэмээх баримт бичигт Хэрэг үйлдэгчийг нэг сар хорих, хэрэв амжихгүй бол хугацааг нэг жилээр сунгах, хэрэв хугацааг алдвал түшмэлийг эвд” гэж заасан байжээ гэж манай судлаач эрдэмтэд сонин баримт дурддаг.

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн тухай засгийн газруудын илтгэлийг Эрүүдэн шүүхийн эсрэг хороогоор авч хэлэлцээд улс орон бүрт өгсөн зөвлөмжийг үзэж байхад (7 орныхыг үзэв) шүүхээс өмнөх шатанд хорьж, саатуулах хугацааг багасгахыг зөвлөмж болгосон байгаа нь анхаарал татаж байна. Энэ 7 орны дотор ОХУ ба Украин оржээ. Гэтэл эдгээр улсуудад хорьж мөрдөх дээд хугацааг 18 сараар тогтоосон байх ба энэ хугацаа дуусвал хоригдогчийг нэн даруй суллах ёстой байна.

3. Конвенцийн “айлган сүрдүүлэх, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие мах бодь, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах” замаар мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэхэд урьдчилан хорих, албадан саатуулах байрнуудын нөхцөл байдал “онцгой үүрэг” гүйцэтгэж байгаа нь хэнд ч нууц биш байна. НҮБ-аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд”: -Хоригдогсодын амьдарч буй өрөө тасалгаа нь ариун цэврийн бүх шаардлагыг хангасан байх, өрөөний цонх нь байгалийн гэрэлд уншиж болохуйцаар гэрэл өгөх, агааржуулалтын хиймэл системтэйгээс үл хамаарч цэвэр агаар орохоор хийгдсэн байх, ариун цэврийн төхөөрөмж нь хоригдогсод бүр нь шаардлагатай үедээ цэвэрч, чөлөөтэй нөхцөлд бие засах, хоригдогсод бүр тусдаа ор дэвсгэртэй байх шаардлагатай гэж заасан.

Монгол улсад 1999 онд анх удаагаа Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг батлан гаргаж сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих нөхцөл журмыг хуулийн хэмжээнд тогтоосон.

Хэдийгээр энэ хууль нь олон улсын жишиг, стандартад хүрээгүй боловч Сэжигтэн яллагдагчийн эрхийг баталгаатай болгох, хоригдох

нөхцөл журмыг дээшлүүлэхэд том алхам болсон гэж үзэх бүрэн үндэстэй.

Харамсалтай нь уг хууль батлагдан гарч мөрдөгдөөд зургаа дахь жилийнхээ нүүрийг үзэж байгаа боловч хуулийн тодорхой заалтуудыг амьдралд хэрэгжүүлэх, ялангуяа хоригдогсодын эдлэх эрхтэй холбоотой амин чухал асуудлуудыг шийдвэрлэх, тэдний эрхийн хамгаалалтанд дорвитой өөрчлөлт гаргах талаар төр засгийн байгууллагаас үр өгөөжтэй арга хэмжээг тэр бүр авч хэрэгжүүлэхгүй байна.

Уг хуульд (17-р зүйл): Хоригдсон этгээдийн байрлах өрөөний цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, агааржуулах салхивчтай, модон шалтай, эсхүл модон наартай байх бөгөөд хорих өрөөний чийглэг 55-60 хувь, өвлийн улиралд 18 хэмээс багагүй дулаантай байх, хорих байрны өрөө нь нэг хүнд 2.5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ноогдож байх, хоригдсон этгээд бүр хучлага, дэвсгэрээр хангагдана.

Бүх өрөө нь цонхгүй учраас байгалийн гэрэл ордоггүй, өрөөн дотроо гэрэл асдаггүй, зөвхөн хаалганы дээд хэсгээс ташуу тусгасан нэг чийдэнтэй, нэгэнт цонхгүй учраас цахилгаан тасарвал өрөөнүүд бүрэн харанхуй болдог.

Цонх байхгүй, цорын ганц чийдэн нь өрөөн дотроо байрлаагүй учраас ном, сонин унших, бичих боломж байхгүй байгаа бөгөөд хүний харах, үзэх наад захын хэрэгцээ шаардлагагыг огт хангахгүй байгаа юм. Бүх өрөөнүүдэд агаарын солилцоо явагдах ямар ч боломжгүй учраас үхмэл агаарын эхүүн, эвгүй үнэр байнга үнэртэнэ.

Зөвхөн “Ганц худаг”-ийн цагдан хорих төвд хийсэн шалгалтаас харахад тус цагдан хорих төв нь нийт 2 корпус 5 давхар барилгатай, “А” корпус нь 1996 онд, “Б” корпус нь 2002 онд ашиглалтанд орсон. 181 камертай. Үүнээс 15 камерт гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч хүүхдүүдийг, 19 камерт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч эмэгтэйчүүдийг хорьж байна.

Нэг давхарт коридорын нийт 16 цонх байрладаг. Зарим давхрын цонхнууд гаднаасаа хаалттай харанхуй туйпуугаар хааж битүүлсэн байна.

Шалгалт хийгдэх үед /2005 оны 6 дугаар сарын 29-нөө 7 дугаар сарын 5-ны өдрүүдэд/ 9 камер нь хоосон хүнгүй байсан бөгөөд 172 камер шалгалтанд хамрагдсан. 1999 оны “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хуулийн 24 дүгээрт зааснаар хорих байрны өрөө нь нэг хүнд 2.5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор заасан байдаг бөгөөд өнөөдрийн байдлаар цагдан хорих төвийн нийт 128 камер буюу нийт камерын 70.7 хувь нь дээрхи хуулийн шаардлагад тохирохгүй бага талбайд хүмүүсийг хорьж байгаа нь хуулийг ноцтой зөрчиж байгаагийн илрэл мөн. Зарим камер 10 хүнийг хорьсон байсан бөгөөд энэ камеруудад нэг хүнд ноогдох талбай нь 0.83-0.85 метр кв байна.

172 камерын 15 камерт насанд хүрээгүй хүмүүсийг хорьсон бөгөөд 5 камерт хоригдож байгаа хүүхдүүдэд оногдох талбай нь 1.7-2.2 метр кв байна.

Эмэгтэйчүүдийг нийт 19 камерт хорьсноос 13 камерт хоригдогсдын хувьд хуулинд заасан талбай хүрэлцэхгүй байна. Эмэгтэй хүлээлэгний өрөө гэхэд л 12 хүнийг 9.07 метр кв өрөөнд хорьж байгаа бөгөөд энэ камерт нэг хүнд 0.8 мкв оногдож байна.

0461-р анги нь хуульд заасны дагуу нийтдээ 650-670 хүнийг хорих багтаамжтай атлаа 1009 хүнийг хорьж хууль зөрчиж байгаа бөгөөд нэг камерт хүмүүсийг олноор нь хорьж байгаагаас болж тэнд хоригдож байгаа хоригдогсод сульдаж тураалд орох, өвчин эмгэг үүсэх, сүрьеэ тусах улмаар амьсгалах агаар, унтаж амрах зайны төлөө бие биенээ дарамтлах, залхахад хүргэж байна.

Үүнээс үзэхэд хоригдож буй нэг хүнд хуульд заасан нормоос 2.5 м²-ээр бага талбай ноогдож байна.

Хоригдсон хүмүүст өглөө, оройд талх, цай, өдөр шөлтэй хоол өгдөг боловч тэр нь амт муутай байдаг. Өдрийн хоолыг бэлтгэж байгааг үзэхэд шар будаа, цувдайгаар хийж байсан бөгөөд сонгино, хачир, амт оруулагч байдаггүй гэж тогооч нь ярьж байлаа.

Усны хангамж туйлын хангалтгүй, өдөрт хоёр удаа ус шахдагаас чөлөөтэй бие засах боломжгүй, хоригдогсод цангаагаа гаргах, ариун цэврийн хэрэгцээгээ хангахын тулд жорлон руу орсон цоргоноос ус авч ялгар уут буюу пиовар саванд нөөцөлдөг байна.

Лабораторийн шинжилгээгээр Цагдан хорих төвийн өрөөний 1м³ агаарт байх нянгийн тоо эрүүл ахуйн нормоос хоёроос дөрөв дахин их, цус задлагч стафиλλюкокк нян эрүүл ахуйн нормоос 7.2 дахин их ба шинжилгээ авсан өрөөнүүдийн агаарт хөгц илэрсэн байна /Эрүүл ахуй, халдвар судлалын байцаагчийн 2001-04-30-ны өдрийн 60 тоот акт/. Үүнээс бүүр ноцтой нь Төв хорих байрыг халдварт өвчин, тэр тусмаа сүрьеэ өвчний үүр уурхай, голомт гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг. Бусад аймаг хотуудад байгаа урьдчилан хорих байрнууд ч нөхцөл байдлын хувьд туйлын хангалтгүй байна. Өнгөрсөн онд явуулсан судалгааны тоймоос дурдахад:

Тодорхой зарим баримт жишээг дурдвал:

- Иргэн “Г”-г 8 удаагийн үйлдлээр бусдын эд зүйлийг дээрэмдсэн, нэг эмэгтэйг хүчиндсэн, иргэн “Д”-г шунахай сэдэлтээр алсан гэж Улсын мөрдөн байцаах газар ял сонсгон, Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж, шүүх 22 жилийн хорих ял оногдуулсан байв. Гэтэл энэ хэргийг Улсын ерөнхий прокурорын газар шинэ нөхцөл байдлаар шалгаад: “Г”-г төв хориход хоригдож байхад нь Хамт

хоригдогсодоор нь дарамтлуулан, гарынх нь салаанд сойз, халбаганы иш эргүүлэх, гар хазах, шөнө унтуулахгүй жорлон дээр гар өргүүлж зогсоох, гуя руу нь өшиглөх, тогонд цохиулах зэргээр тамлаж бусдыг алсан хэргийг хилсээр хүлээлгэсэн нь тогтоогдсон байна. Улсын Дээд шүүх энэ хэргийг хэлэлцээд 200-7-18-ны өдөр 312-р тогтоол гаргаж, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгожээ.

- Төв аймгийн Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч байсан “А” нь иргэн “Б”-г бусдын хөөргийг хулгайлсан хэрэгт сэжиглэн, эрүүгийн хэрэг үүсгэж, улмаар “Б”-г нэг сар орчим цагдан хорихдоо хөөргийг эзнийх нь гэрээс авч гараад айлд очих замдаа хаясан гэж хэрэг хүлээлгэжээ. Үүнээс өмнө цагдан хорихынхоо өмнө зодож айлган сүрдүүлж байжээ. Иргэн “Б”-д шүүх нэг жил хорих оногуулж, ялаа Хархорин дахь Хорих ангид эдэлсэн байна. Гэтэл хөөргөний эзэн “Д” нь хөөрөг алдагдсан гэх өдрөөс нэг сарын дараа гэрээ буулгах үедээ хөөргөө номын тавиур доороосоо олжээ. Үүнийгээ 9 сарын дараа цагдаад мэдэгдсэн байх авч иргэн “Б” шоронд ял эдлээд нэгэнт 10 сарын хугацаа өнгөрсөн байлаа. Иргэн “Б”-тэй уулзаж, яагаад хийгээгүй хэргийг хүлээсэн, юу нөлөөлсөн тухай асуухад: Цагдаагийн ажилтан “Зөвхөн чи л авсан, чамаас өөр хэн ч аваагүй гэж тулгаж, улмаар архи уусан үедээ зодож, айлган сүрдүүлж, гавлаж, хорьж цагдсан” учраас хөөргийг авсан гэж мэдүүлсэн юм гэж тайлбарлаж байв. Үүнтэй төстэй жишээ олныг дурдаж болно.

Олон хэрэг илрүүлсэн, хоригдсон хүнээр хэрэг хүлээлгэдэг, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг шагнаж урамшуулдаг, алдар цол, албан тушаал ахиулдаг гаж буруу тогтолцоо нь эрүүдэн шүүх шалтгааны нэг болж байна гэж ОХУ-ын илтгэлийг эрүүдэн шүүхийн эсрэг хороогоор авч хэлэлцээд гаргасан зөвлөмжид дурджээ. Манайд ч байдал ийм л байна.

5. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 2 дугаар зүйлээс үзэхэд оролцогч улс бүр эрүүдэн шүүх үйлдлээс урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээ авах, 4 дүгээр зүйлд зааснаар “Эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулиараа гэмт хэрэг, бүүр онц аюултай гэмт хэрэг” гэдгийг тогтоох ёстой байна.

Эрүүгийн хуульд Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн тухай бүлэгт Хүнийг хууль бусаар баривчлах (249-р зүйл), Шүүхээс хууль бус шийдвэр гаргах (250-р зүйл), Мэдүүлэг өгөхийг албадах (251-р зүйл) гэсэн гурван зүйлийг Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцтэй холбож үзэж болох юм. Гэвч эхний хоёр гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талд нь “шунахай болон хувийн бусад сэдэлт” заавал байхаар тусгажээ. Хэрэв энэ хоёр сэдэлт тогтоогдохгүй бол гэмт хэрэг биш болохоор байна. Гурван зүйлийн аль нь ч онц аюултай гэмт хэрэгт тооцогдохооргүй байна. Манай нөхцөлд хамгийн анхаарал татах асуудлын нэг нь Конвенцийн 15 дугаар

зүйлийн “Эрүүдэн шүүх замаар гаргуулсан болох нь тогтоогдсон мэдүүлгийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахгүй байх явдлыг хангана” гэсэн заалт юм. ЭБШХ-даа энэ заалтыг тод тусгаж өгч байж л хэрэгжих боломжтой. Хэрэв эрүүдэн шүүх замаар гаргуулж авсан мэдүүлгийг нотлох баримт гэж үзэхгүй байх журмыг хуулиар нэг мөр тогтоож өгөх зайлшгүй шаардлагатай байна.


6. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, тийм үйлдлийг гаргуулахгүй байхад үр нөлөө бүхий хөндлөнгийн хяналт, ялангуяа хүнийг баривчилсан тухайд нь нэн даруй өмгөөлөгч, ар гэрийнхэнтэй нь уулзуулах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд өмгөөлөгчийг байнга, тогтмол байлцуулах, хэрэг бүртгэлт мөрдөн байцаачийн хууль бус арга ажиллагаа, үйлдлийн тухай өргөдөл мэдээллийг ямарч үед гаргах нөхцөл боломжийг бий болгох, үүний мөрөөр хийх хараат бус мөрдөн шалгалтын систем чухал ач холбогдолтой юм.

Үндсэн хуульд хүнийг баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ гэж заасан. Одоогийн ЭБШХ-д тодорхой заалт байхгүй байсан. Харин ЭБШ шинэ хуульд энэхүү мэдэгдэх хугацааг 24 цагаар тогтоосон байна. Гэтэл ОХУ-ын ЭБШХ-иар энэ хугацааг 12 цаг байхаар тогтоосон байдаг.

Эрүүдэн шүүхийн эсрэг хороогоор улс орнуудын илтгэлийг авч хэлэлцээд гаргасан зөвлөмжөөс үзэхэд хоригдсон хүн бүрийн өмгөөлүүлэх, эрх зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг онцгойлон анхаардаг байна.

Хоригдож буй хүмүүсийг өмгөөлүүлэх эрхээр хангах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, өмгөөллийн чанар, үр нөлөөтэй тусламж дэмжлэг авахад цаашдаа анхаарч үзвэл зохих асуудал их байна.

Ганц худагт хийсэн шалгалтаар та өмгөөлөгчтэй юу? гэсэн асуултанд өмгөөлөгч авсан гэсэн хариултыг 575 буюу 64.8 хувь нь, өмгөөлөгч аваагүй байна гэсэн хариултыг 269 буюу 30.3 хувь нь, өмгөөлөгч авах ар гэрийн




болон санхүүгийн ямар нэгэн боломжгүй гэсэн хариултыг 37 буюу 4.1 хувь нь, өмгөөлөгч авах боломжоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хангаагүй гэсэн хариултыг 5 буюу 0.5 хувь өгсөн байна.

Сүүлийн үед эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн олон тооны онц ноцтой гэмт хэрэг гарсан гэдэгтэй нэн ялангуяа дуулиан шуугиан ихтэй хэрэгт холбогдогсдыг Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн цагдан хорих байранд аваачиж хорьдог хууль бус арга ажиллагаа нилээд гарах болсон.

Зарим аймгуудад энэхүү буруу хууль бус арга ажиллагаа “халдварлаж” хоорондоо сэжигтэн, яллагдагчдыг сэлгүүлэн хорих болсон. Тухайлбал: Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн урьдчилан хорих байранд хүмсүүсийг сэлгүүлэн хорьж буй талаар комисст ирсэн гомдлын дагуу шалгахад Увс аймгийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч өмчийн хэрэгт холбогдсон Ц гэгч эмэгтэйг 300 км-ийн алсад орших Баян-Өлгий аймгийн цагдан хорих төвд шилжүүлэн хорьсон байлаа.

ШШГЕГ-ын харьяа Ганц худаг дахь цагдан хорих төвд хийсэн шалгалтаар эрүүгийн хэргийг шалгах нутаг дэвсгэрийн тухай заалтыг цагдаагийн байгууллагын ажилтнууд ноцтойгоор зөрчиж 2004 онд өөр аймаг, хотоос 58 сэжигтэн, яллагдагчийг, 2005 онд 19 сэжигтэн, яллагдагчийг 0461-р ангид авчирч хорьсон байна.

Эдгээр сэжигтэн, яллагдагчийн 10 нь ЭХ-ийн тусгай ангийн 91-р зүйлд заасан хүн амины гэмт хэрэгт холбогдогсод байгаа нь анхаарал татаж байна.




Ганц худгийн цагдан хорих төвөөс бусад аймгийн цагдан хорих байранд шилжүүлэн хорьсон сэжигтэн, яллагдагч 2004 онд 102 байсан ба энэ оны эхний 6 сарын байдлаар 59 хүн шилжүүлэн хорьсон нь нийт хоригдогчийн 6.6 хувийг эзэлж байна.

ЭХ-ийн тусгай ангийн 145 дугаар зүйлээр шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч эдгээр 59 хүний 33.8 хувийг, 91-р зүйлээр шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч 11 буюу 18.6 хувийг эзэлж байна.

Сэжигтэн, яллагдагчийг хэрэг үйлдсэн газраас нь өөр газарт шилжүүлэн хорьж цагдах нь түүний хуульд заасан олон эрхийг тухайлбал

өмгөөлөгчтэйгээ уулзах, хууль зүйн туслалцаа авах, ар гэрийнхнээсээ эргэлт уулзалт авах, хэрэгт нь хяналт тавьж байгаа прокурортойгоо уулзах, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх гэх мэтийн эрхүүдээ эдлэх боломжгүйд хүрч, улмаар гадуурхагдаж бие махбодийн болон сэтгэл санааны эрүү шүүлтэнд хүрдэг нь тодорхой юм.



Угтаа ингэж сэжигтэн, яллагдагчийг орон нутгаас нь алс хол аваачиж хорих нь тэдний хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлж, сэтгэл зүйн хүнд дарамт учруулж буйгаараа эрүү шүүлтийн нэг илрэл болно.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд зааснаар “албадан саатуулагдсан цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт, тулгах эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтанд оруулахыг хориглоно” хэмээн заасантай шууд зөрчиж байгаа юм.

Мөн байцаалтыг уг хэрэг гарсан газар нь явуулна гэж заасан ЭБШХ-тай давхар зөрчилдөж байгааг хэлэх хэрэгтэй.

Үүнээс гадна эрүүдэн шүүгдсэн хүний хохирлын асуудал өнөөдөр дэлхий дахинаа өндөр хэмжээнд яригдаж байгааг хэлэх хэрэгтэй.

Сонин хэвлэл дээр нэр төрөө гутаалгасан хэмээн асар өндөр тоо хэлээд байдаг мөртлөө эрүүдэн шүүгдсэн хүмүүсийн сэтгэл санааны болон бие эрхтний эд хөрөнгийн хохирлыг хэрхэн шийдвэрлэж байх нь тодорхойгүй байдаг. Эдгээр хүмүүс насан туршдаа сэтгэл мэдрэлтийн хүнд дарамтанд зовон шаналан амьдардаг, эсвэл эдгэршгүй өвчтэй болдог, эд хөрөнгийн хувьд ч мөн ялгаагүй асар их

Эдгээрээс үзэхэд манай улсын хувьд энэхүү Конвенциар хүлээсэн үүргээ биелүүлэх талаар дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ЗААЛТУУД МОНГОЛ УЛСЫН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖИЖ БАЙГАА НЬ

Ж.Бямбаа

Доктор, профессор

НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгаас 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенц”-д манай улс 2000 оны 11 дүгээр сарын 2-нд нэгдэн орсноос хойш 5 жил хагасын хугацаа өнгөрсөн атлаа “хүчин төгөлдөр үйлчлүүлэх” боломж бараг байгаагүй гэхэд хэтрүүлэг болохгүй биз. Учир нь дөнгөж 2005 онд Гадаад Хэргийн Яамнаас албан ёсны Монгол орчуулгыг “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт нийтлүүлснээс хойш энэхүү Конвенцийн зүйл заалтууд үндсэн хуулийн баталгаатай, практик амьдралд хэрэглэгдэх бүхий л талын нөхцөл бүрдсэн юм.

Конвенцид “Эрүүдэн шүүх гэдгийг”, “хэн нэг хүн буюу гуравдах этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гуравдах этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гуравдах этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаат үйлдлийг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Манай өдөр тутмын амьдралд Конвенцийн заалтыг өргөн утгаар нь бус “үйлдсэн буюу үйлдсэн гэх хэрэгт нь мэдээ сэлт, мэдүүлэг авах зорилгоор төрийн тусгай эрх бүхий албан тушаалтаны хийж буй санаатай үйл ажиллагаа” хэмээн авч үздэгээрээ онцлогтой¹

Гэхдээ Конвенцийн үзэл баримтлал Монгол Улсад дараахи утгаар илэрхийлэгдэж байна гэж үзэх үндэслэл бий.

- A/. Эрүүдэн шүүх ажиллагааг мэдүүлэг авах төдийгүй аливаа мэдээ сэлт, мэдээлэл авахын тул явуулж болно.
- Б/. Эрүүдэн шүүсэн гэх этгээд нь /субъект нь/ төрийн эрх бүхий албан тушаалтан байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж, албадлага хэрэглэх эрх бүхий төрийн ажилтан байна. Хуульчлагдсан тэрхүү эрх, үүргийг зөвхөн ЭБШ ажиллагааг эрхлэн

¹ ХҮҮК-ийн мэдээлэл сэтгүүл Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн тухай ойлголт 3 дах тал

явуулагчид л эдэлж хэрэгжүүлэх бөгөөд энэ тухай ЭБШ хуулийн 4 дүгээр бүлэгт тодорхой зааж өгчээ.

В/. “Эрүүдэн шүүх” гэдэг нь мэдээ сэлт, мэдүүлэг авахын тул уг эх сурвалжийг мэдэх буюу гаргуулан авах этгээдийн бие махбодийг өвтгөн тарчлаах, санаа сэтгэлийг шаналган дарамтлах, янз бүрийн хэлбэр бүхий давтамжийн шинжтэй санаатай үйлдлээр илрэх учиртай. Нэг удаагийн өвтгөсөн, шаналган зовоосон тохиолдлыг эрүү шүүлт гэж үзэхгүй боловч энэ нь зүй бус, хэрцгий, хүнлэг биш харьцаанд тооцогдож зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ёстой юм. Эрүү шүүлт нь үргэлжилсэн буюу давтагдсан шинжтэй, зориудын, тодорхой зорилго, сэдэлттэй, эсхүл ямар нэгэн төрлийн ялгаварлах, алагчлах үндэслэл бүхий урьдаас төлөвлөсөн үйлдэл, эс үйлдэлийн бодит илрэл юм.

Г/. “Эрүү шүүлтийн” хэлбэр, агуулга, мөн чанарыг улс орон бүр дотоодын хууль тогтоомжиндоо нарийвчлан тусгаж болох авч Конвенцийн үзэл баримтлал, зүйл заалтуудын утга санааг “өөрийн болгож” мушгин гуйвуулах, хасаж, нэмэх аливаа оролдлого хийх нь зүйд үл нийцнэ.

Эрүү шүүлт нь хувь хүний төдийгүй хэсэг бүлгийн, хамт олны энэрэнгүй сэтгэл, шударга журмыг сахих илтгэл үнэмшлийг алдагдуулах аюул бүхий төдийгүй мэдүүлэг өгч буй этгээдтэй хүний ёсноос гадуур харьцах нь хэвийн үзэгдэл мэт ойлголтыг нийгмийн амьдрал, төрийн албаны бүхий салбарт ужигруулах хор хөнөөлтэй гаж үзэгдэл мөн.

Ийм төрлийн үйлдэл бүр эрүүгийн хуулиар нэг мөр тодорхойлогдсон хүнд, онц хүнд гэмт хэрэгт хамаарах учиртай нь зүй ёсны бөгөөд ингэснээрээ эрүүдэн шүүхийг завдах, түүнчлэн эрүүдэн шүүхэд хамжих, хатгах зэргээр хамтран оролцсон этгээд бүрт зохих ял зэмийг заавал оноож байх үндэс суурь ч бас тавигдана.

Хүний эрхийн үндэсний комиссоос өнгөрсөн 2005 онд “Эрүүдэн шүүхийг хориглох нь” сэдэвт нээлттэй хяналт шалгалтыг жилийн турш тусгай графикайн дагуу явуулж мэдээ судалгааг нь нэгтгэсэн зарим дүгнэлтээс үзэхэд одоо үйлчилж буй эрүүгийн хууль тогтоомжийн холбогдох заалтууд нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зохистой механизмын эрх зүйн үндсийг тавьж чадаагүй, Конвенцийн үзэл санааг бүрэн хэрэгжүүлэх хуулийн үйлчлэл, ухамсарын орчин хангалттай бүрдээгүй нь харагдаж байна.

Үнэхээр Конвенцид бие махбодийн болон сэтэл санааны хүчирхийллийн аль алиныг эрүүдэн шүүж буй хэлбэр гэж үзсэн байхад манай Эрүүгийн хуулинд зөвхөн бие махбодийн хүчирхийллийг тухайн төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн элемент болгон явцууруулсан нь учир дутагдалтай байна. Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг эрүү, шүүлтийн шинжтэй бүхий л үйлдэл, бүрэлдэхүүнийг

багтаасан мэтээр үзэж буй өнөөгийн практик ойлголт нь Конвенцийн үзэл баримтлалтай илэрхий зөрчилдөж байна. Эрүүдэн шүүсэн гэмт хэргийн субъект нь ийм үйл ажиллагаа явуулсан “төрийн албан тушаалтан” хэн ч байж болохоор Конвенцид тусгасан байхад манай эрүүгийн хуулийн дээр нэрлэсэн зүйлд зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэмээн хэт явцууруулсан² гэж шүүмжлэх судлаачдын саналыг ч анхаарч үзэх нь зүйтэй юм.

Шүүхийн өмнөх шатанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид төдийгүй, эрүүгийн шуурхай эрэн сурвалжлах ажилтнууд, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий “жирийн” гэгдэх албаныхан хүртэл мэдүүлэг, тайлбар, тодорхойлолт гаргуулан авахын тул иргэдэд хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, дарамтлан зовоох үйлдлийг байнга гаргадаг нь нууц биш. Хохирогчийн хувьд энэ нь нэг удаагийн үйлдэл үү, давтамжийн шинж чанартай юу? гэдэг нь огт хамаагүй бөгөөд харин “төрийн ажилтан” гэх субъектийн хувьд эрүүдэн шүүх шинж бүхий үйлдэл нь ужиг шинжтэй, байнгын хэлбэр агуулсан эсэхээр мөн чанар нь тодорхойлогдох учиртай.

Манай эрүүгийн “эрх зүйн харилцаанд “захиалагч” гэх шинэ нэр томъёо орж ирсэн. Захиалагч гэдэг нь гэмт хэрэг үйлдэх санаагаа өөрөө гардан хийдэггүй, бусдыг хөлслөн авч гүйцэтгүүлдэг хэлбэр юм. Захиалагч нь зохион байгуулалт бүхий буюу гэмт бүлэглэлтэй холбоотой байхаас гадна зарим тохиолдолд зөвхөн нэг, хоёроор тоологдох ноцтой гэмт хэрэг үйлдэх зорилготой байж болно. Захиалагчийн санаа бодол нь тусгай зорилго, жигшүүрт сэдэлт бүхий гэмт хэргийг үйлдэхэд чиглэгдсэн байдаг нь олонтой.

Эрүүдэн шүүх ажиллагаанд захиалгын шинжтэй үйлдлүүд гарсаар байдаг тухай баримт хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цөөнгүй дурьдагддаг. Мөнгө, төгрөг, тэр ч атугай эрх мэдэлд дулдуйдан холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар, захиалга өгч гэрээ, хэлэлцээр бүхий иргэний маргааныг эрүүгийн ноцтой гэмт хэрэг, залилангийн хортой үйлдлүүд хэмээн тооцуулахаар тулгах, мөрдөн байцаах, шүүн таслах харьяалалыг хууль бусаар тогтоолох, цагдаагийн зарим албад, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад илт хууль бусаар нөлөөлж хохирогчдыг бие, сэтгэлийн дарамтанд оруулах явдал сүрхий өсөх хандлагатай байгаа нь судлаачид³ онцлон тэмдэглэсээр байна.

Эрүүдэн шүүх агуулга бүхий гэмт хэрийн материаллаг шинжийг тодорхойлохдоо эрүүгийн хуулийн “251 дүгээр зүйлд буюу мэдүүлэг өгөхийг албадах” хэлбэрээр хязгаарлаж болохгүй санагдана. Конвенцид тусгагдсан өргөн утгаар нь авч үзвэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн

² 2006 оны 1 дүгээр сарын 18-нд болсон ХЭҮК-оос зохион байгуулсан Зөвлөлгөөн дээр тавигдсан Үндсэн илтгэл, бусад материалаас үзнэ үү.

³ Мөн Зөвлөлгөөнд тавигдсан илтгэл, хавсралт илтгэлээс.

27 дугаар бүлгийн зарим гэмт хэргүүд, тухайлбал, илт гэм буруугүй хүнийг сэжигтнээрээ тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх /эрүүгийн хуулийн 248 дугаар зүйл/, шүүхээс хууль бус шийдвэр гаргах /эрүүгийн хуулийн 250 дугаар зүйл/-ыг шууд хамааралтай хэмээн тухайлан нэрлэж болно. Ер нь материаллаг хуульд, тэр тусмаа Эрүүгийн хуулийн зохих бүлэг, зүйлд эрүүдэн шүүх шинж бүхий гэмт хэргийн объектив, субъектив шинжийг тов тодорхой тусгаж өгөх нь зүйтэй. Учир нь бүтэц, агуулга, мөн чанарыг ямарч эргэлзээгүй тодорхойлж өгсөн эрх зүйн зохицуулалтгүйгээр “эрүүдэн шүүх”-ийн эсрэг Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдэхгүй. Тэгээд ч материаллаг хуулийн заалтаар эрүүдэн шүүх шинжийг гарган тодорхойлж чадахгүй бол төсөөтэй жишиглэлээр гэмт хэргийг зүйлчилж ял зэм оноох тухай ямар ч яриа байж таарахгүй. Түүгээр ч үл барам Эрүүгийн хуультай хүйн холбоо бүхий ЭБШ хуулийн үйлчлэлд ч илэрхий сөрөг нөлөө үзүүлнэ. Тодорхой нэгэн хэргээр энд жишээлье. Эрүүгийн хуулийн 253 дугаар зүйлд буюу “нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх” гэмт хэрэг яагаад “эрүүдэн шүүх” ажиллагаатай холбогддог билээ гэсэн асуулт тавигдаж болох юм. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, шүүгч, хэргийн оролцогчид, талууд эрүүгийн болон иргэний хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээх учиртай.

Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх гэмт хэрэг бол шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хэвийн ажиллагаа, нэр хүнд, үйл ажиллагааны үндсэн зарчимд халдахын хамт хүний эрх, эрх чөлөөнд халдаг давхар объект бүхий ноцтой гэмт хэрэг юм.

Энэ гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр илэрдэг бөгөөд сэдэлт нь өш хонзон, атаархал хорсол, албан тушаалтын хуурамч нэр хүнд хөөцөлдөх, шунахайн зэрэг ямарч хэлбэрээр илэрч болно.

Байцаан шийтгэх ажиллагааны ийм ноцтой хэлбэр сүүлийн үед манайд улам өсөн нэмэгдсээр байгаа нь нууц биш. Төдийлөн эс тоодогоос болоод иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүртэл сэтгэлийн зовлон, “эрүүдэн шүүхийн” сонгодог жишээ болон хувирч байна. “Алдсан хүн арван тамтай” гэчээр заль мэх дарамт шахалтанд байнга нэрвэгдэж эцэс дүнд нь мэтгэлцээн нэрт “илт хуурамч” жүжгийн дүрд хүссэн хүсээгүй “тоглож”, эцэс төгсгөлгүй үргэлжилсэн маргаанд аргамжлагдаж хуулийн хүчирхийлэлд өртөн эд хөрөнгө, орон байраа алдан хоосорч, сэтгэл санааны шаналалд автах нь өнөөгийн нийгмийн бодит дүр зургийн нэг болоод байна. Гэтэл илт хуурмаг баримт бүрдүүлсэн гээгээр эрүүгийн хариуцлага хүлээж байгаа хувь хүн, албан тушаалтан, тухайлбал, шүүгч, өмгөөлөгч, прокурор ер байна уу.

Авилгын гэмт хэрэг гэж тусгайлан зүйлчлэгдэггүй боловч түүний объектив, субъектив шинжийг тодорхойлсон олон зүйл, заалтууд Эрүүгийн

хуулинд тусгалаа олж чадсан. Түүнтэй нэгэн адил “Эрүүдэн шүүх” ноцтой гэмт үйлдлийн бүтэц, бүрэлдэхүүнийг мөн тэнд нарийвчлан тодорхойлж, амьдрал үйлчлэлтэй болгох нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг яриангүй мөн.

Манай Эрүүгийн хуульд төрийн албан тушаалтан албаны эрх мэдлээ хэтрүүлэх, албан үүргээ урвуулан ашиглах гэсэн зүйл анги /эрүүгийн хуулийн 263, 264 дүгээр зүйлүүд/ байдаг ч энд “эрүүдэн шүүх” ямар ч шинж тусгагдаагүй, энэ зүйлийн албан тушаалтан гэдэг нь зөвхөн удирдах албан тушаалтан хамаарах, бас үлэмж хэмжээний хохирол учирсан байхыг шаарддаг, тэгээд ч хүндэвтэр хэргээс цааш халихгүй ял зэмтэй учраас Конвенцийн үзэл санаанд төдийлөн нийцэхгүй, үйлчлэл үр нөлөө бараг байхгүйтэй адил.

Эрүүгийн хэргийг “мөрдөн мөшгинө” гэдэг нь мөрдөн байцаах, хянах, эрүүгийн эрэн сурвалжлах /ихэнх тохиолдолд гүйцэтгэх ажил хэмээн нэрлэгддэг/ чиг үүргүүдийн цогц шинжийг агуулсан ойлголт билээ⁴.

Гэтэл мөрдөн мөшгих ажиллагааг зөвхөн хүний мууг үзэх зорилготой мэтээр ойлгох, мөрдөн байцаалтыг дан ганц байцаалт хэмээн үзэх, шүүхийн өмнөх шатанд бүхий л нотлох ажиллагааг дан ганц **байцаалтаар** хэрэгжүүлэхээр туйлшрах явдал нийтлэг шинжтэй байна. Тодруулбал, ЭБШ тодорхой ажиллагаа түүний төрлүүдийг /үзлэг, нэгжлэг, туршилт, шинжилгээ гэх мэт/ цогц байдлаар энэ чацуулан ашиглахгүй, зөвхөн /сэжигтэн, яллагдагч, гэрч хохирогчийн/ мэдүүлгийн хойноос улайран хөөцөлдөж, хуульчлагдсан арга, тактикуудыг эс тоомсорлон зөрчих нь улам олширлоо. Тулган балмагдуулах, сэтгэл зүйн хувьд дарамтлах, хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх зэрэг янз бүрийн бохир аргуудыг уламжлагдсан жишиглэл мэтээр яс махандаа шингээсэн цагдаагийн ажилтан төдийгүй, прокурор, шүүгч цөөнгүй байгаа нь нууц биш.

Зөвхөн “байцааж нотолсон” хэрэг ЭБШ ажиллагааны дараа дараачийн шатанд буцаж няцах нь амархан. Хамгийн ноцтой нь мэдүүлэг авахын тул “эрүүдэн шүүх” хэлбэрийн ямарч үйл ажиллагаа явуулахаас буцахаа больсон баримт мэдээллүүд холбогдох байгууллагуудад тасралтгүй ирж байна.

Хүний Эрхийн үндсэний Комиссоос 2005 онд явуулсан хяналт шалгалтын хүрээнд хуулийн байгууллагын 600 шахам ажилтнуудтай ярилцлага зохион байгуулж, цагдан хоригдож буй 1338 хүнээс санал асуулга авч, тэндээс 110 тай нь жичлэн ярилцаж “эрүүдэн шүүхийн” дүр зургийг тодорхойлсон нэгэн судалгааны дүнг энд авч үзье.

Хуульчдын дотроос шүүгчид ихэвчлэн “хэрэгт холбогдогчид шүүх хуралдааны үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэн, айлган

⁴ Г.Совд нар Хууль зҮйн тайлбар толь УБ 2003 он

сүрдүүлж хэрэг хүлээлгэсэн, би энэ хэргийг хийгээгүй” гэх нь нэлээд гардаг, өмгөөлөгчид “...хэрэгт холбогдогчдыг зодох дарамтлах, хатуу ширүүн харьцах, хүчээр хэрэг хүлээлгэх зэрэг зөрчил багагүй байдаг”, прокурорууд “...ийм зөрчил дутагдал бараг байдаггүй бид байнгын хяналт тавьдаг” гэж ихэвчлэн хариулж байна. Харин хэрэгт холбогдон мөрдөгдөж байгаа хүмүүсийн санал бодлыг судалж үзэхэд санал асуулгад хамрагдсан 1338 хүний 39.9 хувь дарамталж айлган сүрдүүлж хэрэг хүлээлгэдэг, 32.0 хувь нь зодож хүч хэрэглэж хийгээгүй хэрэг хүлээлгэдэг гэж хариулсан байна. Ялангуяа “Ганц худаг” болон Төв аймагт хоригдож байсан хүмүүсийн хариулт энэ чиглэлээр харьцангуй өндөр хувь эзэлж байна. Тухайлбал, Ганц худагт хоригдогсдын 44.6 хувь нь айлган сүрдүүлж, дарамталдаг, 36.7 хувь нь хүч хэрэглэж зодож дарамталдаг гэж тус тус хариулсан байна. Хяналт шалгалтын явцад уулзсан хүмүүсээс олон тооны өргөдөл гомдол гаргаж байсан ба зармыг нь шалгаж шийдвэрлүүлэхээр Прокурорын мөрдөн байцаах албанд шилжүүлсэн аж. Эрүүдэн шүүсэн, хэргийг хүнлэг бус харьцсан зарим тодорхой тохиолдлууд ч ажиглагдсаар байна. Хүн амины хэрэгт холбогдуулан эх, эцэг, төрөл төрөгсдөд нь мэдэгдэлгүй баривчилсан Ж.Мөнхбаяр ганц худагт 3 хонохдоо эрүүл газаргүй болтлоо зодуулж амь насаа алджээ. “Food land”-ын манаачийн амь насыг бүрэлгэсэн хэрэгт холбогдон хоригдож байгаад ганц худагт нас барсан С.Хүрэлбаатарын эх нь “би хүүтэйгээ уулзах гээд очиход хоёр төмсөг нь хавдаж, явж чадахгүй болтлоо зодуулсан байсан, гэтэл эмнэлэг нас барсаны шалтгааныг уушигны өвчин гэж тогтоосон” гэдэг бөгөөд түүнтэй хам хэрэгт холбогдон хоригдож байсан нэр бүхий 3 хүн хилс хэрэг хүлээж эцэстээ хэрэгт холбогдолгүй болж, мөрдөнд байхдаа эрүү шүүлт байнга амсаж байсан талаар гомдол гаргаж байв. Талийгаач С.Хүрэлбаатар нь эрүү шүүлтийн улмаас нас барсан байхыг ч үгүйсгэхийн аргагүй юм.

2005 оны 6 дугаар сард манай улсад айлчилж, эрүүдэн шүүхийн асуудлаар баримт нотолгоо цуглуулах ажлыг ахалж ирсэн НҮБ-ын тусгай илтгэгч ноён Манфред Новак “Эрүүдэн шүүх болон тамлан зовоох, хүнлэг бусар хүний нэр төрийг доромжлон хэрцгий харьцсан мэдээ баримт Монголд хангалттай байна” гээд эрүүдэн шүүх тамлан зовоох болон бусад хэрцгий шийтгэлийн нөхөн төлбөр олгох боломж сулыг ч мөн илтгэлдээ тэмдэглэжээ.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т “...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ...” гэж тунхагласан байдаг.

ЭБШ хуулийн 58, 59, 68 дугаар зүйлээс үзэхэд сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг хөндлөнгийн шинжтэй, хараат бус шүүх өгч байхаар болсон билээ.

ЭБШ шинэ хуулиар “шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч цагдан хорихыг хориглоно” гэж зааснаар Монголын шүүх, шүүгчид цоо шинэ үүрэг гүйцэтгэх болсон учраас зохион байгуулалтын зарим арга хэмжээ авч шүүгчдийн сургалт, семинар явуулах, хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж, тойм гаргах, хагас бүтэн жилээр мэдээ тайлан авах, ЭБШ хуулийн 58, 59 дүгээр зүйлүүдийг тайлбарлаж Улсын Дээд Шүүхийн тогтоол гаргах, баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг ажил үүргийн хуваариар иргэний шүүн таслах ажиллагаа эрхэлдэг шүүгч нарт хариуцуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, хүний эрхийн байгууллагуудтай болон шүүхийн үйл ажиллагааг дэмжиж туслалцаа үзүүлдэг “Hanns Seidel”-ийн сан, Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр зэрэг газруудтай хамтран ажилласаны үр дүнд ЭБШ хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажиллагаа овоо жигдэрч эхэлсэн. Гэвч баривчлах, цагдан хорих ажиллагаатай холбоотой ЭБШ хуулийн заалтуудыг шүүхийн практикт хэрэгжүүлэхэд зарим бэрхшээлүүд гарсаар байна.

Юуны өмнө шинэ хуулиар шүүхүүдэд нэн хариуцлагатай бөгөөд нүсэр ачаалалтай болсон байхад шүүгчийн орон тоог нэмэгдүүлээгүйгээс энэ ажлыг эрүүгийн шүүн таслах ажиллагаа эрхэлдэггүй, мэргэшээгүй шүүгч нарт хариуцуулсанаас дайвар мэт явж ирлээ. Улсын хэмжээнд баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох 41 шүүгчийн орон тоо шинээр бий болгох тооцоо судалгаа гарсан боловч түүнийг одоо болтол шийдвэрлээгүй байна.

ЭБШ хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэнийг баривчлах тухай тогтоол үйлдэж, прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна”, 68 дугаар зүйлийн 68.3-т “Цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна” гэсэн заалтуудыг шүүгч хэрэгжүүлэхдээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйлдсэн тогтоолд гарын үсэг зурж баталж байгааг бие даасан шийдвэр гаргасан гэж үзэхэд нэн төвөгтэй, өөрөөр хэлбэл ЭБШ хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т “Таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн шүүгч авна” гэсэн заалттай зөрчилдөж байна гэсэн үг.

Шүүгч нь шүүн таслах ажиллагааны хүрээнд өөрийн эрх хэмжээний дотор алив асуудлыг шийдвэрлэхдээ “захирамж” гэсэн эрхийн акт гаргаж шийдвэрлэдэг бөгөөд ЭБШ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.25-д “шүүгчийн захирамж гэж эрүүгийн хэргийг шийдвэрлэхтэй холбогдуулж гаргасан

цагаатгах, шийтгэх тогтоолоос бусад шүүгчийн дангаараа гаргасан шийдвэрийг” ойлгоно гэж тодорхой заасан байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйлдсэн заримдаа /хуулийн шаардлага тэр бүр хангаагүй, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих үндэслэлээ тодорхой заагаагүй/ тогтоолыг шүүхээр батлуулахаар тулгаж байгаа нь “шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах” болон “албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно” гэсэн ЭБШ хуулийн 15 дугаар зүйлд заасан зарчмыг зөрчихөд хүргэжээ.

Нөгөө талаас баривчлах, цагдан хорих, хугацаа сунгуулах тухай тогтоолыг шүүгчид танилцуулах, хүргүүлэх талаархи хугацааг болон ЭБШ хуулиар тогтоосон журмыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорууд тэр бүр хэрэгжүүлэхгүй байна.

Шүүгчид 2003 онд 1741 сэжигтэнийг баривчлах, 5472 сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, 2004 онд 12687 сэжигтэнийг баривчлах, 6110 сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, 2005 онд 1876 сэжигтэнийг баривчлах, 5703⁵ хүнийг цагдан хорих зөвшөөрөл тус тус өгсөн нь анхаарал татахаас аргагүй нэн ярвигтай ажил хариуцаж буйг, бас ихээхэн ачаалалтайг харуулж байна.

Иймд баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг зөвхөн шүүгчийн захирамжаар олгох чиглэлээр ЭБШ хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулж баривчлах, цагдан хорих журмыг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Баривчлах, ялангуяа цагдан хорих /ТСАХ/ авах үндэслэлийг ч мөн адил төгөлдөржүүлэх зүйн хэрэг. Тухайлбал, “оргон зайлсхийж болзошгүй” гэх мэтийн субъектив хандлагыг биш, “оргон зайлах үндэслэл байвал” гэх зэрэг объектив шинжийг нь дээрх арга хэмжээний тулгуур үндэс болгох шаардлагатай.

Хүний Эрхийн үндэсний Комиссоос прокурорын байгууллагатай хамтран 2004, 2005 онд цагдан хоригдсон байдлыг шалгаад “энэхүү арга хэмжээ” сэжигтэн, яллагдагчийг залхаах, улмаар хэрэг илрүүлэх нэгэн “арга” болоод байгааг жичлэн дүгнэсэн байдаг.

Хэргээ хүлээгээгүй болон өөрийнхөө үйлдлийг хэрэг биш гэж үзсэн хүмүүс ихэвчлэн цагдан хоригдож, энэ арга хэмжээ нь хэрэг хүлээгэдэг нэгэн төрлийн “зэвсэг” болдог нь нууц биш. Хэргээ хүлээгээгүй, гэм буруутай болох нь нотлогдоогүй хүнийг удаан хугацаагаар хорьж, эрүүл мэнд нь хохирч амь насаа алдах явдал ч гарсаар байна. Өнгөрсөн 2005 онд гэхэд хүн амины хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байсан Батдорж гэгч 2 жил шахам хоригдож энэ хугацаандаа сүрьеэ тусч тэр нь эмчилгээ

⁵ Шүүхийн жилийн тайлан 2003, 2004, 2005 он

авахгүй боллоо хүндэрч нас барсан, мөн хэрэгт холбогдон 300 гаруй хоног хоригдсон Шижирбаатар гэгч хоёр нүд нь сохорсон зэрэг тохиолдлууд гарч НҮБ-ын тусгай төлөөлөгчийн шалгалтанд баримт болон тэмдэглэсэн. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдоогүй этгээдийг амь насаа алдал, эрүүл мэнд нь хэзээ ч нөхөн сэргээгдэхгүй болтол хэт удаан хугацаагаар хорино гэдэг бол жинхэнэ эрүү шүүлт, хэргий, хүнлэг бус харьцаа гэж үзэхээс өөр аргагүй. Гэтэл урт удаан хугацаагаар хорьж, эрүүл мэнд нь муудаж улмаар нас барсан тохиолдлыг хууль ёсны үйлдэл мэтээр шүүх, прокурорын байгууллага эс анхаарсан нь үнэхээр харамсалтай.

Цагдан хорих төвүүдэд ажиллаж байгаа эрүүгийн төлөөлөгчдийн “гүйцэтгэх ажил” нэрийн дор зарим хоригдогсдын өрөө камерыг сонгож нэгийг нөгөөгөөр нь зодуулж дарамтлуулж хэрэг хүлээлгэх үйл ажиллагаа идэвхжиж хорих байрны захиргаа, эрүүгийн төлөөлөгч, байцаагч нарын хооронд зөрчил гарах тохиолдол буурахгүй байна. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, цагдан хоригдсон л бол тэнд явуулах “гүйцэтгэх ажил” болгон прокурорын хяналтаас гадуур хийглэх учиргүй юм.

Хүний Эрхийн үндэсний Комиссоос 2005 онд 9 газар хийсэн шалгалтаар цагдан хоригдож байсан 1338 хүний 230 нь 6 сараас 1 жил, 109 нь 1-2 жил, 17 нь 2 жилээс дээш цагдан хоригдож байв. Цагдан хорих хугацаа шинэ ЭБШ хуулиар төдийлөн багассангүй, насанд хүрээгүй хүмүүсийг цагдан хорих хугацаа насанд хүрэгчдийнхтэй адил, тэдэнд тавих прокурорын хяналт хуучин арга барилаас салаагүй, тусгаарлагдсан этгээдүүдийн эрүүл мэнд, ахуй нөхцөлийг дээшлүүлэх олигтой арга хэмжээ авахгүй байгаагаас “урьдчилан хорино” гэдэг нь хэрэг хүлээлгэх, “нааштай” мэдүүлэг авахын тул ашигладаг шалгарсан арга хэвээр байна.

2006 оны эхээр болсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглох нь” зөвлөлгөөн дээр нийслэлийн орлогч прокурорын тавьсан илтгэлээс үзэхэд “урьдчилан хорих байруудад хийх хяналт-үзлэг график төлөвлөгөөний дагуу 10 хоногт нэг удаа заавал явагддаг. Тийм ч учраас тэнд эрүү шүүлтийн элдэв хэлбэр эрс багасч байна” хэмээсэн нь үндсэн илтгэлд дурьдагдсан судалгаа тоо баримттай илэрхий зөрчилтэй, үндэс муутай байгааг тэрхүү зөвлөлгөөний зарим оролцогчид шүүмжилж байсан.

“Эрүү шүүлтийг” төлөвлөгөөт шалгалтаар биш янз бүрийн мэдээлэл авах арга барилаа нарийсгасан хүртээмжтэй болгож, түүндээ байнгын дүгнэлт хийж, **ГЭНЭТИЙН** шинжтэй хяналтаар илрүүлэх боломж илүү гэдгийг практик туршлага харуулж байна.

Сүүлийн жилүүдэд өмгөөлөгчдийн тоо харьцангуй нэмэгдэж байгаа ч өмгөөлүүлэгчдийн эрх, ашиг сонирхолыг тууштай дагнан хамгаалах нь зохих түвшинд хүрч чадаагүй байна. Судалгаанд хамрагдсан өмгөөлөгчид

хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гарч байгаа зөрчил дутагдлын талаар тэр бүр бичээд гомдол гаргаад байх нөхцөл муу байдаг, хэд хэдэн удаа гомдол, санал гаргавал өмгөөлөгчид өширхөх, шахалт дарамт үзүүлэх, өө сэв хайж шалгуулах, янз бүрийн аргаар процесс ажиллагаанд оролцоход саад учруулах, өмгөөлөгчдийн тавьсан санал хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зүгээс хайхархаа болих явдал гардаг” гэсэн санал шүүмжлэл нийтлэг байсныг ч энд онцлох нь зүйд нийцнэ. Зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч оролцуулах сонирхол бага байдаг төдийгүй “өмгөөлөгч хэрэгт оролцохоор л биш болдог, хэргээ хүлээж байсан хүн хэргээ хүлээхээ байдаг, тэд янз бүрийн үг зааж өгдөг” гэж тайлбарлаж байгаа нь өмгөөлөгчид хандах хандлагын нэг илэрэл юм.

Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийн төлөө тууштай ажилладаг өмгөөлөгчдийг мохоох оролдлого өндөр эрх мэдэлтний зүгээс, шүүхийн зүгээс хэд хэдэн удаа гарсан гэдгийг Хүний Эрхийн үндэсний Комиссын 2005 илтгэлд тэмдэглэжээ.

Хүний Эрхийн үндэсний Комисс цомхон бүрэлдэхүүнээрээ хүний эрхийн салбар дахь янз бүрийн зөрчлүүдийг, түүний дотор “эрүүдэн шүүсэн” гэмт хэргийн шинжтэй өдий төдий ноштой дутагдал илрүүлээд түүнийг арилгах, арга хэмжээ авахуулах талаар дуу хоолойгоо огтхон ч сулруулахгүй байхад “хүчирхэг зэвсэгтэй”, орон тоо сайтай, хууль хамгаалах байгууллагууд эрүүдэн шүүхтэй тэмцэх үндсэн үүргээ биелүүлж буй өнөөгийн байдал үнэхээр чамлалтай.

Энэ бүхнээс дараах товч дүгнэлтийг хийж болох юм. Үүнд:

- Эрүүдэн шүүхийн эсрэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг байнга эрэлхийлж цаг алдалгүй хэрэгжүүлж байх
- Эрүүдэн шүүх зохисгүй ажиллагаа үүсэж бий болох бүхий л боломжийг илрүүлж арилгах. Энэ чиглэлээр явуулах судалгаа шинжилгээний ажлыг тогтмол, үр нөлөөтэй болгох
- Эрүүдэн шүүхийн янз бүрийн илрэлийн эсрэг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг эрс дээшлүүлэх
- Хамтарсан зөвлөлгөөн, онол практикийн хурал, ярилцлагыг тогтмолжуулах
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн зүйл, заалтын биелэлтийг энэ чиглэлээр ажиллах бүх байгууллага тусгайлан тайлагнаж, түүнд эрдэм судлалын чиглэлээр боловсруулалт, дүгнэлт гаргуулж Хүний Эрхийн үндэсний Комисс тухай бүр үнэлгээ өгдөг журам тогтоох.

“Эрүүдэн шүүх”-ийн шинж бүхий элдэв зөрчил дутагдлыг арилгах, энэ талаар ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт тогтмол зохион байгуулах зэргийг юу юуны урьд анхаарч хэрэгжүүлэх.

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН ХЭРЦГИЙ ХҮНЛЭГ БУСААР ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ, ШИЙТГЭХИЙГ ХОРИГЛОСОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ж.Дашдорж
ХЭҮК-ын гишүүн

Монгол улс 1992 онд шинэ ардчилсан Үндсэн хуулиа баталж, хүний эрх, эрх чөлөө шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилго дэвшүүлсэн билээ. Иймд төрийн байгууллагын бүхий л салбарт ялангуяа хуулийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хууль ёсыг чандлан биелүүлэх нь хуулийн байгууллага, тэнд ажиллаж буй хуульчдын эрхэм зорилго байх ёстой.

Хуулийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүү болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг дэлхий нийтийн хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн суурь зарчмуудад тулгуурлан өөрчлөх нь шилжилтийн үеийн гол зорилт байсан.

Монгол улс хуулийн байгууллагын тогтолцоо, бүтцэд багагүй өөрчлөлт хийж, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн баталж, эрүүгийн байцаан шийтгэх хууль журмандаа олон улсын гэрээ конвенцид заасан хүний эрхийг хангах зарим нэг суурь зарчим баталгааг тусгасан нь онцгой ач холбогдолтой болсон. Монгол улсын Үндсэн хууль болон ЭБШ хууль бусад хууль тогтоомжид эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглосон. Үүний зэрэгцээгээр Монгол улс НҮБ-аас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 50 орчим гэрээ конвенцид нэгдэн орж, эдгээр гэрээ конвенцид заасан хүний эрхийг хангах баталгааг биелүүлэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн. Энэ нь хуульчдаас илүү их өргөн мэдлэг чадвар, ур ухааныг шаардаж байна гэсэн үг юм.

Монгол улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой заалтыг амьдралд хэрэгжүүлэх нь хүний үйл ажиллагаатай тухайлбал хуульчдын мэдлэг чадвар, сахилга хариуцлага, хүний эрхийн чиг хандлагатай шууд холбоотой байдаг.

Монгол улс 1976 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад, 2000 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг

бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэн орсон. Гэсэн хэдий ч эдгээр гэрээ конвенцоор хориглосон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцах шийтгэх зөрчил бүрэн арилж чадахгүй байна. Иймээс ХЭҮК 2005 онд “Эрүүдэн шүүхийг хориглох нь” сэдэвт нээлттэй хяналт шалгалтын ажлыг нэг жилийн хугацаатай зохион байгуулж, тайлан илтгэл гаргахаар бэлтгэж байна. Энэхүү хяналт шалгалтын ажлыг Нийслэл Улаанбаатар хот, хэрэг зөрчил ихээхэн гардаг Төв, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод, Увс, Хөвсгөл, зэрэг аймгуудад зохион байгууллаа. Хяналт шалгалтын явцад дотоодын хууль тогтоомжийн заалт нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зохистой механизм болж чадаж байгаа эсэх, олон улсын гэрээ конвенцийн заалттай хэрхэн нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, цагдан хорих байранд хоригдож байгаа хүмүүсээс санал асуулга авах, биед нь үзлэг хийх, өрөгдөл гомдлыг нь хүлээн авах, биечлэн уулзах, шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаагийн ажилтнууд, иргэдтэй уулзалт ярилцлага зохион байгуулах, иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах, зөвлөгөө өгөх, прокурор шүүхээр шалгагдаж байгаа хэрэг материалтай танилцах зэрэг ажлыг зохион байгуулж, энэ хугацаанд энэ асуудалтай холбоотой мэдээлэл, сургалт, сурталчилгааны багагүй ажлыг зохион байгууллаа.

Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн өөрчилж, мөрдсөн хэдий ч Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн үзэл санаа эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулинд бүрэн хэмжээгээр тусгалаа олоогүй гэж дүгнэх үндэстэй байна. Эрүү шүүлтийн тухай ойлголт эрүүгийн хуулинд бүрэн хэмжээгээр тусгагдаагүй байна. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийллийг аль алиныг нь эрүүдэн шүүлт хэмээн үзэхээр заасан ч манай эрүүгийн хуулинд зөвхөн бие махбодийн хүчирхийллийг гэмт хэрэг хэмээн тодорхойлж сэтгэл санааны хүчирхийллийг орхигдуулсан байна. Эрүүгийн хуулийн 251-р зүйлд заасан гэмт хэргийг эрүү шүүлтийн гэмт хэрэгт тооцсон заалт гэж үздэг ч энэ нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэсэн хоёр этгээдэд холбоотой байхаар хуульчилж, энэ хэргийн субьектийг хэт явцууруулсан байна. Конвенцид зааснаар эрүүдэн шүүсэн гэмт хэргийн субьект нь төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй хэн боловч байж болохоор заасан байхад манай эрүүгийн хуулинд энэ хүрээг ихээхэн хязгаарлаж өгсөн нь зөрчилтэй болсон байна. Эрүүдэн шүүсэн тухай гэмт хэргийн субьект нь эрүүдэн шүүх заавар, зөвлөгөө, даалгавар өгсөн, дэмжсэн зөвшөөрсөн, гардан гүйцэтгэсэн зэрэг аливаа үүрэг гүйцэтгэсэн төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй хэн боловч байж болохоор хуулинд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн байгууллагын тэр тусмаа цагдаагийн байгууллагын ажилтнуудаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа эрх хэмжээгээ хэтрүүлж, урвуулан ашиглаж хэрцгий хүнлэг бус хандаж, бусдын эрх чөлөөнд

халдаж, бие эрхтэнд нь гэмтэл учруулсан, эрх, эрх чөлөөг нь ноцтой зөрчсөн үйлдлийг тусгайлан зүйлчилж илүү өндөр хариуцлага хүлээлгэж байх ёстой. Гэвч өнөөгийн мөрдөж буй хуулиар ийм байж чадахгүй байна, энгийн иргэдийн адил энгийн зүйл ангиар ял шийтгэл хүлээж байна. Хяналт шалгалтын явцад УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас албан үүргээ гүйцэтгэх явцадаа /цагдаа, хэсгийн байцаагч, ахлах офицерууд/ бусдыг зодож хүч хэрэглэж бие эрхтэнд нь гэмтэл учруулсан, хэргийг хандсан тухай нилээд хэрэгт мөрдөн байцаалт явуулдаг хэдий ч эдгээр хэргүүд нь ихэнхи тохиолдолд мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд хохирогч гомдол саналгүй болсон, эвлэрсэн, хохирлоо нөхөн төлсөн гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгогдож, тэднээс маш цөөн нь буюу цагдаа голдуу ажилтнууд эрүүгийн хариуцлага хүлээдэг байна. Хэрэг шалгагдах явцад хэрэгт холбогдож буй ажилтнууд хохирогчид элдэв дарамт шахалт үзүүлэх замаар аргагүй байдалд оруулж гомдол саналгүй болгож эвлэрсэн болгодог байхыг ч үгүйсгэх аргагүй байна. Зарим хохирогчид ч ийм байдалд орж эвлэрсэн тухайгаа ярьж байсан. Манай эрүүгийн хуулинд төрийн албан тушаалтан албаны эрх мэдлээ хэтрүүлэх, эрх мэдэл албан тушаалаа урвуулан ашиглах /ЭХ-263.264/ гэсэн зүйл анги байдаг ч энэ зүйлийн албан тушаалтан гэдэгт зөвхөн удирдах албан тушаалтан хамаарах, бас үлэмж хэмжээний хохирол учирсан байхыг шаарддаг тул энэ зүйл ангиар удирдах бус албан тушаалтан шийтгэгдэх боломжгүйд хүрдэг байна. Иймээс эрүү шүүлтийн тухай тодорхойлолтыг эрүүгийн хуулинд бүрэн хэмжээгээр тусгах, албан тушаалын байдлаа хэтрүүлэх, урвуулан ашиглах зэргээр бусадтай хэргийг хүнлэг бус харьцаж, бие эрхтэнд нь халдаж хохирол учруулсан хуулийн байгууллагын ажилтны хууль бус үйлдлийг тусгайлан зүйлчилж, ял хариуцлага тооцдог байх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Хяналт шалгалтын хүрээнд хуулийн байгууллагын 600 орчим ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж, цагдан хоригдож буй 1338 орчим хүнээс санал асуулга авч, 100 гаруй хүнтэй биечлэн уулзаж, иргэдээс 40 орчим өргөдөл гомдол хүлээн авсан байна. Хуульчдын санал бодлыг сонсоход хуульчид харилцан адилгүй санал бодолтой байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал шүүгчид ихэвчлэн "... хэрэгт холбогдогчид шүүх хурлын үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж, айлган сүрдүүлж, дарамталж хэрэг хүлээлгэсэн, би энэ хэргийг хийгээгүй гэж мэдүүлэх тохиолдол нилээд гардаг" гэж, өмгөөлөгчид "... хэрэгт холбогдогчдыг зодох, дарамтлах, хатуу ширүүн харьцах, хүчээр хэрэг хүлээлгэх зэрэг зөрчил багагүй байдаг" гэж, прокурорууд "... ийм зөрчил дутагдал бараг байдаггүй бид байнгын хяналт тавьдаг" гэж ихэвчлэн хариулж байна. Харин хэрэгт холбогдон мөрдөгдөж байгаа хүмүүсийн санал бодлыг судалж үзэхэд санал асуулгад хамрагдсан 1338 хүний 39.9 хувь нь дарамталж айлган сүрдүүлж хэрэг хүлээлгэдэг гэж, 32.0 хувь нь

зодож хүч хэрэглэж хийгээгүй хэрэг хүлээлгэдэг гэж хариулсан байна. Ялангуяа ганц худаг болон Төв аймагт хоригдож байсан хүмүүс энэ асуултанд харьцангуй их хариулсан байна. Тухайлбал ганц худагт хоригдогсдын 44.6 хувь нь айлган сүрдүүлж, дарамталдаг гэж, 36.7 хувь нь хүч хэрэглэж зодож дарамталдаг гэж тус тус хариулсан байна. Хяналт шалгалтын явцад олон тооны өргөдөл гомдол гаргаж байсан ба зарим өргөдөл гомдлыг шалгаж шийдвэрлүүлэхээр МБА-нд шилжүүлж байсан байна. Эрүүдэн шүүсэн, хэргийг хүнлэг бус харьцсан зарим тодорхой тохиолдлууд ч ажиглагдсаар байна. Тухайлбал өнгөрсөн онд гарсан Б.Мөнхбаярын тухай асуудал. Хүн амины хэрэгт холбогдуулан эх, эцэг, төрөл төрөгсдөд нь мэдэгдэлгүй баривчилж, Ганц худагт 3 хонохдоо эрүүл газаргүй болтлоо зодуулж амь насаа алдсан тохиолдол байна. Энэ хэрэг эцэслэн шалгагдаагүй ч ар гэр, эх эцэгт нь мэдэгдэлгүй хорьж, тийм аймшигтайгаар зодож нүдсэнийг харахад эрүү шүүлт явагдсаныг ч үгүйсгэхгүй. “Фуд ланд” гэгчийн хэрэгт холбогдон хоригдож байгаад ганц худагт нас барсан С.Хүрэлбаатарын эх нь би хүүтэйгээ уулзах гээд очиход хоёр төмсөг нь хавдаж, явж чадахгүй болтлоо зодуулсан байсан, гэтэл эмнэлэг нас барсны шалтгааныг уушигны өвчин гэж тогтоосон хэмээн гомдоллож, түүнтэй хам хэрэгт холбогдон хоригдож байсан нэр бүхий 3 хүн хилс хэрэг хүлээж эцэстээ хэрэгт холбогдолгүй болж, мөрдөнд байхдаа эрүү шүүлт амсаж байсан талаар гомдол гаргасан байна. Иймээс түүнийг эрүү шүүлтийн улмаас нас барсан байхыг ч үгүйсгэхгүй. Дээрэм хүн амины хэрэгт холбогдон 2 сар гаруй хугацаанд ганц худагт хоригдон зодуулж цохиулж эрүү шүүлтэд өртөж байсан тухай У.Оргилболд шүүхэд хандаж хохирлоо гаргуулж байсан байна. Дархан-Уул аймагт ажиллаж цагдан хорих байранд үзлэг хийхэд 10 гаруй хоригдогсод байцаагчдаа зодуулж цохиулж дарамтлуулсан тухай гомдол гаргаж байсан ба Ч.Одгэрэл гэгч би 3 адуу хулгайлсан хэргээ хүлээсэн гэтэл байцаагч 3 үхэр 26 адууны хэрэг хүлээхийг тулгаж шалны модоор хөл, гарлуу цохиж, чихрүү алгадаж чихний хэнгэрэг цоолсон хэмээн гомдол гаргаж, түүнийг аймгийн эмнэлэгт үзүүлэхэд үнэхээр чихнийх нь хэнгэрэг шинээр цоорч эдгэрч байгаа нь үнэн болох нь нотлогдож байсан. Хэрэгт холбогдон мөрдөгдөж буй хүмүүсээс өөрийн үйлдсэн хэргээ хүлээсэн боловч өөр хэрэг үүрүүлэх гэж дарамт шахалт үзүүлж байна гэж олон тооны хүмүүс бичсэн байгаа нь анхаарал татаж байна. Төсвийн удирдлага санхүүжилтийн хуулийн дагуу цагдаагийн байгууллагын ажилтнууд үр дүнгийн гэрээ байгуулж уг гэрээнд илрүүлсэн, ял төлөвлөсөн хэргийн тоогоор цалинг нь тооцож байгаа нь ямар нэгэн аргаар аль болох олон хэрэг илрүүлэх хүлээлгэх сонирхол бий болгож энэ нь сөрөг үр дагавар үүсгэж байж болзошгүй байна.

Хяналт шалгалтын явцад ажиглагдсан нэг анхаарал татсан асуудал бол гэмт хэрэгт холбогдон хоригдогсдыг өрөө камер дамжуулан хорьж, өөр бусдаар дарамтлуулж, зодуулж, цохиулж хэргээ хүлээхийг тулгадаг

тухай гомдол санал юм. Иймэрхүү үйлдлийг эрүүгийн төлөөлөгч болон байцаагчдын зүгээс гаргадаг тухай хоригдогсод их тавьдаг. Эрүүдэн шүүх болон хэрэг тулган хүлээлгэх гол арга нь ийм хэлбэрээр хийгддэг байж болзошгүй байна. Цагдан хорих төвүүдэд ажиллаж байгаа эрүүгийн төлөөлөгчдийн зүгээс “гүйцэтгэх ажил” нэрийн дор зарим хоригдогсдын өрөө камерыг сонгож нэгийг нь нөгөөгөөр нь зодуулж дарамтлууулж хэрэг хүлээлгэх үйл ажиллагаа явуулдаг, үүнээс болж хорих байрны захиргаа, эрүүгийн төлөөлөгч байцаагч нарын хооронд маргаан зөрчил гардаг хорих газрын ажилтнууд гомдол санал гаргаж байсан. Хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүсээс ч ийм гомдол бага бус гарч байна. Тухайлбал Төв аймгийн Дэлгэрхаан сумын иргэн Г.Долгороос миний хүү Батсайханыг хэрэгт холбогдуулан хорьж, 3 хоносны дараа эрүүгийн төлөөлөгч өөр нэгэн хүнийг нэмж оруулж тэр үеэс хойш хүүгийг минь толгой түрүүгүй нүдэж, дээрээс нь дэвсэх зэргээр зодож тамлаж, 9 хоноод гарахад бүх бие нь хөх няц болж, гэдэс нь хавдаж амьсгаадаж байсан ба эмнэлэгт үзүүлэхэд элэг задралттай эмчилгээгүй гэж гаргаж гэртээ байж байгаад нас барлаа гэж гомдол гаргаж байсан. Тухайн үед аймгийн прокурортой хамтран шалгахад сүүлд орсон Эрхэмбаатар гэгч энэ талаар хүлээн мэдүүлж байсан болно. Тэрээр эрүүгийн төлөөлөгч Мөнхбат намайг дуудаж чиний ордог камерт хүн амины хэрэг хийсэн хүн байгаа, хэргээ хүлээхгүй байгаа юм, чамаас хүн амины хэрэг гарч байсан, чи зодож байгаад хэргийг нь хүлээлгэ, би чиний хэргийг цайруулна гэсэн би үгүй гэхэд чамайг нутгийн чинь шоронд миаруулж өгнө шүү, чи төлөөлөгчтэй гайгүй байвал зүгээр шүү гэж дарамталсан гэж мэдүүлж байсан байна. Хорих байранд хөтлөгддөг бүртгэл тэмдэглэлээс харсан ч түүнтэй төлөөлөгч Мөнхбат уулзаж ярилцсаны эцэст Батсайханы өрөөнд шилжүүлж оруулсан байх ба хорих байрны ажилтнууд ч үүнийг баталж байгаа нь хохирогчийн гомдол үндэстэй болохыг харуулж байна. Саяхан ХЭҮК-т иргэн Б гэгчээс нэгэн гомдол ирсэн ба тэрээр гомдолдоо “... намайг Ганц худгийн 41 номероос 18 номерт шилжүүлж энэ үеэс эхлэн тэнд хоригдож байсан залуу чи авсан мөнгөө хаана нуусан хэнтэй хуйвалдсан гэж дарамталж, бие засуулахгүй 2, 3 хонуулж, толгой тархи руу сохиж, үснээс туг тугаар нь зулгааж, унтуулдаггүй байсан” хэмээн бичсэн байна. Үнэхээр тэр залуугийн толгойн оройн хэсгийн үс хэсэг газар байхгүй болсон байгаагаас харахад түүнийг хэлснийг үгүйсгэх аргагүй. Түүнчлэн зарим цагдан хорих газруудад хорих ангиудаас хоригдлууд авчирч хорьж бусдыг дарамтлуулах хэрэг хүлээлгэх үйл ажиллагаа явуулдаг байж болзошгүй гэсэн мэдээллийг ч албаны хүмүүс өгч байгаа нь анхаарал татна. Иймээс гүйцэтгэх ажил нэрийн дор хийгдэж буй аливаа ажилд прокурорын зүгээс сайтар хяналт тавьж байх шаардлагатай байна.

Манай цагдан хорих байрны хүнд хатуу нөхцөлд хэргээ хүлээгээгүй хүмүүсийг урт удаан хугацаагаар хорих нь эрүүдэн шүүх хүнлэг бус

хэргийг хандах харьцааг нөхцөлдүүлж байна. Шинэ ЭБШ хууль мөрдөгдөж эхэлсэн эхний жилүүдэд нилээд нааштай хандлага ажиглагдаж байсан боловч энэ нь тогтвортой байж чадсангүй. ХЭҮК анх байгуулагдсаныхаа дараа Ганц худагт шалгалт хийх үед 793 хүн хоригдож байсан бол 2005 оны 7 сард шалгалт хийхэд тэнд 1009 хүн хоригдож байсан нь үүнийг гэрчилнэ. 2005 онд шүүхийн мэдээгээр 1776 хүнийг баривчилж, 5703 хүнийг цагдан хорьсон байна. Шалгалт судалгааны явцад хэргээ хүлээгээгүй болон өөрийнхөө үйлдлийг хэрэг биш гэж үзсэн хүмүүс ихэвчлэн цагдан хоригдож, энэ арга хэмжээ нь хэрэг хүлээлгэх нэг арга болсоор байна. Хэргээ хүлээгээгүй гэм буруутай болох нь нотлогдоогүй хүнийг удаан хугацаагаар хорьж, эрүүл мэнд нь муудаж амь насаа алдах, эрүүл мэнд нь хохирох явдал ч гарсаар байна. Өнгөрсөн онд гэхэд хүн амины хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байсан Батдорж гэгч 2 жил шахам хоригдож энэ хугацаандаа сүрьеэ тусч тэр нь эмчилгээ авахгүй болтлоо хүндэрч нас барсан, мөн хэрэгт холбогдон 300 гаруй хоног хоригдсон Шижирбаатар гэгч хоёр нүд нь сохорсон зэрэг тохиолдлууд гарсан байна. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нотлогдоогүй этгээдийг амь насаа алдал, эрүүл мэнд нь хэзээ ч нөхөн сэргээгдэхгүй болтол хэт удаан хугацаагаар хорино гэдэг бол жинхэнэ эрүү шүүлт, хэргийг хүнлэг бус харьцаа гэж үзэхээс өөр аргагүй. Гэтэл урт удаан хугацаагаар хорьж, эрүүл мэнд нь муудаж улмаар нас барсан тохиолдлыг хууль ёсны үйлдэл мэтээр шүүхээс дүгнэж байсан нь үнэхээр гайхаш төрүүлнэ. Төв аймагт адуу хулгайлсан хэргээр олон хоног хоригдож сүрьеэ тусч тэр нь хүндэрч нас барсан Ганбат гэгчийн эх нь хүүгээ алдаж хохирсны хохирол нэхэмжилж шүүхэд хандсан. Гэтэл шүүх энэ тохиолдлыг байж болох хууль ёсны асуудал мэтээр дүгнэж нэг ч төгрөгний хохирол гаргаж өгөөгүй байна. Хяналт шалгалтанд хамрагдсан 9 газарт хоригдож байсан 1338 хүний 230-нь 6 сараас 1 жил хүртэл, 109-нь 1-2 жил хүртэл, 17-нь 2 жилээс дээш хугацаагаар цагдан хоригдож байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд заасан цагдан хорих хугацаа хэт урт байгааг ч өөрчлөх шаардлагатай байна. Цагдан хорих арга хэмжээг гарцаагүй тохиолдолд аль болох бага хугацаагаар хэрэглэдэг, хоригдогсдын эрүүл мэндийн байдалд онцгой анхаардаг, эрүүл мэнд нь муудаж өвдөж гэмтсэн тохиолдолд чанартай эмнэлгийн тусламж үзүүлдэг, арга хэмжээг нь өөрчилдөг хүнлэг энэрэнгүй ханддаг байх нь чухал байна.

Иргэдийг аливаа гэмт хэрэг зөрчлийн улмаас албадан саатуулах, баривчлах, эрүүлжүүлэх явцдаа хэргийг хүнлэг бусаар хандах, бие эрхтэнд нь хандаж гэмтэл учруулах явдал багагүй гарч байна. Үүнийг прокурор, болон мөрдөн байцаах албанд ирж буй өрөгдөл гомдол илтгэн харуулна. Баянзүрх дүүрэгт 2005 онд гэхэд л УЕП-ын дэрэгдэх мөрдөн байцаах алба 40 гаруй хэрэгт мөрдөн байцаалт явуулж 28 хэрэгт ял төлөвлөж шүүхэд шилжүүлсний нилээд хэсэг нь цагдаагийн ажилтнуудаас

бусадтай зүй бус харьцсан эрх чөлөөнд нь халдсан хэргүүд байна. Түүгээрч үл барам Эргүүл хамгаалалтын газрын цагдаа Г.Гансүх иргэн Б-г саатуулах явцад 2 гарыг нь гавлаж, гавтай гаранд нь хөлийг нь углаж, толгой биед нь хэд хэдэн удаа цохиж зодсоны улмаас хохирогч гавал тархины битүү гэмтэл, бөөрний цус хуралтын улмаас нас барсан байна. Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн жижүүрийн мөрдөн байцаагч Б.Мөнхбаяр ахтайгаа марган хүргэгдэж ирсэн иргэн Болдыг тайлбар тавилаа гэж цээж толгой, чихрүү нь цохиж, хэнгэрэг хальсыг нь цоолж биед нь гэмтэл учруулж, заамдаж боож саатуулах камерт хийж хэрцгий хандаж шүүхэд шилжиж байжээ. Баянгол дүүргийн цагдаагийн хэлсийн эрүүлжүүлэх байрны цагдаа О.Баярсайхан иргэн Мөнхбаярыг ахыгаа сурж очиход нь би яаж мэддэг юм, би агуулж байдаг юм уу гэж уурсаж, эрүүлжүүлэх байранд оруулан хувцсыг нь тайлуулан зодож, камерт оруулж цэвэрлэгээ хийлгэж байсан байна. Хөдөө орон нутагт ажиллаж буй хэсгийн байцаагч, цагдаа нараас бусдын эрх чөлөөнд халдах, хатуу ширүүн харьцах, дураараа авирлах явдал гарсаар байна. Хөдөө сумдад тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох ямарч механизм байхгүй, иргэд тэдний үйл ажиллагаанд тухай бүр нь гомдол гаргах боломжгүй байгаа нь ийм нөхцөл байдал бий болоход боломж олгож байна.

Эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бус хандах, хэрэг тулган хүлээлгэх, дарамтлах зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гол нөхцөл нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны мэтгэлцээний нэг тал болох өмгөөлөгчийн оролцоо байдаг. Сүүлийн жилүүдэд өмгөөлөгчийн тоо харьцангуй нэмэгдэж байгаа ч өмгөөлөгчид хандах хандлага, тэдний оролцоо хангалттай түвшинд байж чадахгүй байна. Нийслэлийн болон орон нутгийн өмгөөлөгчидтэй уулзаж санал хүсэлтийг нь сонсоход хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын явцад гарч байгаа зөрчил дутагдлын талаар тэр бүр бичээд гомдол гаргаад байх нөхцөл муу байдаг, ихээхэн гомдол санал гаргасан өмгөөлөгчид өширхөх, шахалт дарамт үзүүлэх, янз бүрийн өө сэв хайж шалгуулах, тийм өмгөөлөгчийг аль болох авхуулахгүй байхыг ятгах, өмгөөлөгчдийн тавьсан санал хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зүгээс хайхарч үзэхгүй явдал гардаг гэсэн санал шүүмжлэл нийтлэг гарч байсныг дурьдахад илүүдэхгүй. Зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч өмгөөлөгч оролцуулах сонирхол бага байдаг төдийгүй өмгөөлөгч хэрэгт орохоор л биш болдог, хэргээ хүлээж байсан хүн хэргээ хүлээхээ байдаг, тэд янз бүрийн үг зааж өгдөг гэж тайлбарлаж байсан нь өмгөөлөгчид хандах хандлагын нэг илрэл юм.

Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийн төлөө тууштай ажилладаг зарим өмгөөлөгчдийг мохоох зарим тохиолдол гарсныг ХЭҮК зориуд тэмдэглэж байна. Гадаадаас хууль бусаар баривчлагдан ирж, нууц газар хоригдож, эрүү шүүлтэнд өртөж, шахалт дарамтын дор хууль бусаар туслах ажилтнаар элсүүлэгдэн хохирсон хүнийг тууштай өмгөөлж, энэ

хууль бус үйл ажиллагааг олон нийтэд мэдээлсэн өмгөөлөгч Санжаасүрэн ял шийтгүүлж, өмгөөлөгчөө солихыг тулгасан шүүгчийн хууль бус үйл ажиллагааг эсэргүүцэж түүнийг татгалзсан өмгөөлөгч Нямзундуй баривчлагдаж байсан нь анхаарал татаж байна. Ийм байдлаар цаашид үргэлжилбэл өмгөөлөгчид үйлчлүүлэгчийнхээ төлөө шийдвэртэй, тууштай ажиллахад ихээхэн, бэрхшээлтэй болно, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо ч өмгөөлөгчдийнхөө эрх ашгийг хамгаалах талаар идэвхитэй ажиллах шаардлагатай.

Хууль болон мөрдөж буй дүрэм заавраар хоригдогсдыг өрөө камерт хуваарилах нь цагдан хорих шийдвэрийг биелүүлж буй байгууллагын эрх хэмжээний асуудал бөгөөд тэднийг өрөө камер хэсүүлэн хорих, өөр орон нутагт шилжүүлэн хорих нь тэдэнд сэтгэл зүйн дарамт учруулаад зогсохгүй хуульд заасан олон эрх ашиг хөндөхөд хүргэж байна. ХЭҮК-оос өөр газарт шилжүүлэн хорьдог зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагуудад шаардлага зөвлөмж хүргүүлсэн ч энэ зөрчил байсан хэвээр байна. Хяналт шалгалтанд хамрагдсан 9 газарт судалгаа хийж үзэхэд нийтдээ 2005 онд 198 хүнийг өөр газар шилжүүлэн хорьсон байна. Зарим хүнийг 2-3 газар ч шилжүүлэн хорьж байсан тухай дурьдагдаж байсан байна.

Энэ мэтээр хууль ёсыг гажуудуулсан хүнлэг бус харьцсан тухай гомдол мэдээлэл бага бус гардаг ч энэ зөрчилдөө эрүүгийн хариуцлага хүлээсэн, арга хэмжээ авагдсан эрүүгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бараг байхгүй байна. Хэрэг хүлээлгэхийн тулд хүч хэрэглэсэн дарамт шахалт үзүүлсэн тухай гомдол санал цөөн бус гардаг ч гол төлөв үр дүнгүй болж өөрөөр хэлбэл хэрэгсэхгүй болгогдон шийдвэрлэгддэг байна. Манай улсад сүүлийн хэдэн жилд Эрүүгийн хуулийн 251-р зүйлээр хууль бус аргаар мэдүүлэг авсан буюу авахыг завдсан нэг ч албан тушаалтан шийтгэл хүлээгээгүй байна. Энэ нь энэхүү зөрчил маш далд нууц аргаар үйлдэгддэг, хохирогчид цаг тухайдаа гомдол санал гаргадаггүй, гомдол санал гаргах ч таатай орчин бүрдээгүй, энэ төрлийн хэргийг мөрдөх илрүүлэх арга барил дутмагтай холбоотой гэж үзэхэд хүргэж байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар харьцах шийтгэх зохисгүй үзэгдэл хэзээ ч ямар ч нөхцөлд гарах ёсгүй бөгөөд ийм зөрчил дутагдал нийгэм, эдийн засаг, санхүүгийн ямар нэгэн учир шалтгаан байхгүй. Өөрөөр хэлбэл төр, нийгмийн зүгээ ийм зөрчил гаргахад зайлшгүй нөлөөлж буй хүчин зүйл өнөөдөр байхгүй. Ийм зүйлийг хийж болохгүй, энэ нь хуулиар хориотой гэдгийг мэддэггүй ухамсарладаггүй хуулийн ажилтан бүү хэл тийм иргэд ч байхгүй гэхэд хилсдэхгүй. Гэсэн хэдий ч ийм зөрчил дутагдал гарсаар байгаад манай хуульчид, хуулийн байгууллагын удирдлагууд онцгой анхаарч хүний эрхийн энэхүү зөрчлийг таслан зогсоохыг та бүхнээс уриалж байна.

ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО

*Х.Алтанзүрх,
Нийслэлийн прокурорын орлогч,
хууль цаазын итгэмжит зөвлөх*

Прокурорын байгууллага нь ЭБШ хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд заагдсаны дагуу эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглох үйл ажиллагаанд оролцож байна.

Прокурорын байгууллагын тухай хуульд шүүхээс зөвшөөрөл авахаас бусад тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагааг явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгөх тухай заасан. Прокурорын зөвшөөрөл дээрх хуульд заагдсан ажиллагааг явуулах албан тушаалтны шийдвэрийг батламжлах хэлбэрээр үйлдэгдэнэ.

Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хуулийг зөв хэрэглэх баталгаа болоод зогсохгүй хүний эрхийн баталгаа болдог. Гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан, цагдан хоригдож байгаа хүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах баталгаа нь прокурорын хяналт юм.

Эрүүгийн хуульд мэдүүлэг өгөхийг албадах /Эрүүгийн хуулийн 251-р зүйл/ гэсэн эрүүдэн шүүхтэй холбоотой гэмт хэргийн тухай заалт байдаг. Нийслэлийн прокурорын газрын судалгаагаар сүүлийн 3 жилд зөвхөн 1 удаа мэдүүлэг өгөхийг албадах гэсэн зүйл ангиар Хан-Уул дүүрэгт эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явагдсан боловч гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Сэжигтнийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг хянах нь прокурорын үүрэг. 2005 онд нийслэл дэх цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч нар 889 хүнийг баривчилснаас 311 буюу 34 хувийг прокурор, мөрдөн байцаагчийн тогтоолыг шүүхэд танилцуулж 578 буюу 65 хувийг мөрдөн байцаагч тогтоол үйлдэн шууд баривчилсан ба 576 буюу 99 хувийг зөвхөн прокурорт танилцуулсан байна.

Мөн 5391 хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авснаас /цагдаа 5156, ТЕГ-57, Прокурорын мөрдөн байцаах алба 1781/ 1915 буюу 35 хувьд нь

цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний 632 буюу 33 хувийг сэжигтнээр цагдан хорьсон байна. Нийт цагдан хоригдсон хүмүүсийн 362 буюу 19 хувийг 5 сар, 97 буюу 5 хувийг 9 сар, 106 буюу 5.5 хувийг 9 сараас дээш хугацаагаар цагдан хорьсон байна.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар батлагдсан эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокуророос тавих хяналтын ажилд ЭБШ хуулийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааварт мөрдөн байцаагч ЭБШ хуулийн 58.1-р зүйлд заасан сэжигтнийг баривчлах үндэслэл байгаа гэж үзвэл тогтоол үйлдэж прокурорт ирүүлнэ. Прокурор мөрдөн байцаагчийн тогтоолтой танилцаад үндэслэлтэй бол зөвшөөрсөн гарын үсэг зурж шүүхэд танилцуулж шийдвэрлэнэ. Хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн байцаагч сэжигтнийг баривчилж энэ тухай тогтоол үйлдэж тогтоолыг 24 цагийн дотор прокурорт хүргүүлнэ. Сэжигтнийг баривчлах, цагдан хорих хуульд заасан үндэслэл байхгүй гэж үзвэл прокурор энэ тухай тогтоол /мөрдөн байцаагчийн/ дээр зохих тэмдэглэл хийж тогтоолыг хэргийн материалын хамт мөрдөн байцаагчид буцаах тухай заасан. Мөн сэжигтэн, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах хуульд заасан үндэслэл байна гэж прокурор үзсэн бол зохих шатны прокурорт урьдчилан танилцуулна.

Баривчлах, цагдан хорих байр бол эрүү шүүлт гарах хамгийн магадлалтай газруудын нэг. Дээрх газруудад үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын үйлдлийг хянах боломж нь эрүү шүүлтийг багасгах нэг нөхцөл. Мөн эрүү шүүлт болсон гэдгийг нотлох нь чухал ач холбогдолтой. Төрийн албан хаагч шийтгүүлнэ гэдгээ мэдэж байвал эрүү шүүлт багасна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхийн тулд цагдан хорих, баривчлах үйл ажиллагаатай холбоотой журмыг албан ёсоор тогтоох, төрийн албан хаагчдын гаргаж байгаа хэрэг, зөрчлийг ил тод мэдээлэх хэрэгтэй. Цагдан хорьсон, баривчилсан тухай ар гэр, өмгөөлөгчид нь мэдэгдэх, сэжигтэн, яллагдагчийн эрхийг тайлбарлаж өгөх, өмгөөлөгчөөр эрхээ хамгаалуулах нөхцөлөөр хангах, цагдан хорих байрнаас гомдол, хүсэлтээ төрийн байгууллагад чөлөөтэй гаргах боломжийг бүрдүүлэх зэрэг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлнэ.

Өнөөдөр мөрдөн байцаалтын шатанд нотолгоо цуглуулах арга хэрэгсэл “байцаалт” болж байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч өөртөө хэрэгтэй нотлох баримт олж авахын тулд эрүү шүүлт хэрэглэх явдал гарсаар байна. Нотлох баримтыг “байцаалтаар” биш шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан цуглуулах нь эрүүдэн шүүх явдал гаргахгүй баталгаа юм.

Мөн эрүүдэн шүүх замаар гаргуулсан нотлох баримтыг байцаан шийтгэх ажиллагааны тухайн шатанд үгүйсгэх нь чухал.

2005 онд мөрдөн байцаагчийн баривчлах тогтоолыг прокурорууд 40 удаа үндэслэлгүй гэж буцаасан ба цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авах тогтоолыг 20 удаа хүчингүй болгожээ. Ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан дээрх зааварт зааснаар эрүүгийн хэрэгт цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчтай прокурор 10 хоног тутам 1-ээс доошгүй удаа уулзаж эрүүл мэндийн байдал болон хэргийн талаарх санал хүсэлтийг сонсож, энэ тухай тэмдэглэл үйлдэж байна. Нийслэл, дүүргийн прокурорын газрын прокурорууд цагдан хорих 0461-р ангийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа бөгөөд хяналтын прокурорууд 7 хоног бүр очиж яллагдагчтай уулзаж сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих баривчлах тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж байна.

Цагдан хорих төвд шалгалт хийхдээ мэргэжлийн хяналтын газартай хамтарч байгаа ба өнгөрсөн онд 167 зөрчил илрүүлж илэрсэн зөрчлийг арилгуулахаар 2 удаа прокурор шаардлага бичлээ. Гэвч цагдан хорих төвд хоригдогсдын тоо буурахгүй, бие биедээ хүч хэрэглэх, зодох, айлган сүрдүүлэх явдал гарсаар байна. Одоогийн байдлаар цагдан хорих төв 560 хоригдогсод хүлээн авах хүчний чадалтай байтал 826 хоригдогсод байна.

Мөн эрүүл ахуйн талаас нь зөвшөөрөгдөх хэмжээнээс нянгийн тоо их байгаа юм. Нийт цагдан хоригдогсдын 467 нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хүмүүс байна. Цагдан хорих ангийн даргын сонголыг Нийслэлийн прокурорын зөвлөлийн хурлаар хэлэлцэж тодорхой үүрэг өгч биелэлтийг шалгалаа.

2005 оны 06-р сард Мөнхбаярыг зодсон хянагч Бат-Үнэн, Батгэрэл нар эрүүгийн хэрэг үүсгэн хэргийг шүүхэд шилжүүлж бусдаас мөнгө авсан хянагч Чингис, Отгонбаяр нарт сахилгын арга хэмжээ авахууллаа.

Нийслэл дэх мөрдөн байцаах байгууллагууд хэрэг илрүүлэх нэрээр сэжигтэн, яллагдагчийг Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн цагдан хорих байранд хорьж байсныг журамлах зорилгоор 2005 оны 11-р сарын 07-нд Нийслэлийн прокурор тушаал гаргаж цагдан хорих 0461-р ангид сэжигтэн, яллагдагчаар цагдан хоригдож байгаа этгээдийг өөр газар шилжүүлэн хорихдоо сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг баримтлах, хэргийн материалтай сайтар танилцсаны эцэст зөвхөн Нийслэлийн прокурорын орлогч шийдвэрлэдэг болголоо.

Сүүлийн үед Нийслэлийн хэмжээнд эрүүгийн нөхцөл байдал хүндэрч онц ноцтой гэмт хэргүүд олноор гарч цагдан хоригдогсдын тоо нэмэгдэж тэднийг Нийслэлд байгаа ганц цагдан хорих төвд олноор нь хорьж байна. Иймд эдгээр хоригдогсод өөртөө давуу байдлыг олж авахын тулд бие биедээ хүч хэрэглэх айлган сүрдүүлэх бусдад хэргээ хүлээлгэх, бусдын хэргийг худалдаж авах зэрэг зөрчил арилахгүй байгаа. Түүнчлэн зарим

ноцтой эрүүгийн хэрэг ч тус төвд гарч байна Энэ нь хэд хэдэн нөхцөлөөс шалтгаалж байна.

Цагдан хоригсдын тоо хүчин чадлаас давсан. Энэ байдлаас болон хоригдогсдыг олноор нь нэг камерт хорьж байна. Хүнд гэмт хэрэг үйлдэгсэд олширсон. Цагдан хорих төвд камерийн хяналт хангалтгүй байна.

Энэ нь бусад хоригдогсдод дарамт болж байна. Мөрдөн байцаалтыг түргэн шуурхай явуулах, хуулийн заалтыг сахиулах зорилгоор өнгөрсөн онд нийслэл, дүүргийн прокурорууд 141 мөрдөн байцаагчид сахилгын, 13 мөрдөн байцаагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэлээ.

Цаашид мөрдөн байцаалтыг түргэн шуурхай явуулах хэргийн сэжипэн, яллагдагчид аль болох цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авахад ажлаа чиглүүлнэ.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЛЭРЧ БУЙ ЭРҮҮ ШҮҮЛТ, ХҮНЛЭГ БУС АРГА, АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

*Б.Галдаа,
Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх
Мөрдөн байцаах албаны дарга*

1961 онд Монгол улс НҮБ-д гишүүнээр элссэн түүхт үйл явдал хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан Олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, улмаар дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, эрх чөлөөний нийтлэг жишгийг хангах, дагаж мөрдөх нэгэн шинэ үеийн эхлэл тавигдсан билээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд батлан гаргасан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг Монгол улс 1974 онд соёрхон баталсан нь уг конвенцийн 7 дугаар зүйлийн “Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэнтэй ч хэрцгий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглоно” гэсэн заалтыг хүлээн зөвшөөрч, түүнийг хангах үүргийг Дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээснээрээ Монгол улсад хэн ч гэсэн эрүү шүүлтийн аливаа хэлбэрээс ангид байх эрх Дэлхийн хамтын нийгэмлэгийн хяналтанд орсон гэж болно.

Манай улсад 1990 оноос эхэлсэн ардчилал улс орны хөгжил дэвшил, хүн ардынхаа эрх, эрх чөлөөг хангахад эрх зүйн орчинг цоо шинэ агуулгаар баяжуулж баталгаажуулсан юм. Энэ бол Монгол улсын 1992 оны Үндсэн хууль мөн.

Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг бүхэлдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах, хамгаалахад чиглэгдсэнээрээ урьд нь нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцээр хүлээсэн үүргийг баталгаажуулсан төдийгүй хүний эрхийг хамгаалах талаар гарсан олон улсын бусад конвенцид нэгдэн орох өргөн боломж бий болгон эх орондоо хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг байгуулах хууль зүйн дээд хүчинтэй баримт бичиг юм. Энд Үндсэн хуулийн зарим заалтыг иш татъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн “... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй”, мөн зүйлийн 14 дэх хэсгийн “... өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар

шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэж буруутайд тооцож үл болно...” гэсэн, түүнчлэн мөн хуулийн арван есдүгээр зүйлийн 2 дахь заалтад “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл, үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заажээ.

Монгол улсын Үндсэн хууль нь бусад улс орны Үндсэн хуулийн нэгэн адил бүх хуулиудын гол эх сурвалж болдог утгаараа Монгол Улсын Эрүүгийн хууль, ЭБШ Хууль, түүнчлэн хүний эрх, эрх чөлөөнд хамааралтай хуулиудын аль ч хэм хэмжээ Үндсэн хуулийн заалт түүний дотор хуулийн “Хоёрдугаар бүлэг”-ийн заалтад чанд нийцсэн байхаас гадна тухайн хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх бүхий л үйл явц ч гэсэн хуулийн дагуу хэрэгждэг байх ёстой. Энэ нь Үндсэн хуулийн далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалттай салшгүй холбоотой.

Төрийн зүгээс эрүү шүүлт тулгах болон хүний нэр төрийг гутаасан хэрцгий албадлагаас чөлөөтэй байх явдал бол ардчилсан нийгмийн ёсонд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн нэг хэлбэр гэдгийг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээгээр зохицуулдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” конвенцийг батлан гаргасан бөгөөд Монгол улс энэ конвенцид 2000 оны 11 дүгээр сарын 2-нд нэгдэн орж, биелүүлэх үүрэг хүлээсэн. Энэ үеэс эхлэн “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн заалт Монгол улсын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх эрх зүйн үндэслэлтэй болмоо гэсэн үг юм.

Гэхдээ Монгол улсын Үндсэн хуулиар болон Монгол улсын олон улсын гэрээгээр гэмт хэрэг, түүнд оногдуулах эрүүгийн хариуцлага, мөрдөн шалгах процессын тухай шууд заалт байдаггүй учраас Монгол улсын эрүүгийн болон ЭБШ Хуулийн аль ч хэм хэмжээ нь тус улсын Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ, үзэл баримтлалд үндэслэсэн байх нь эрх зүйт төрийн үйл ажиллагааны нэг гол шинж мөн. Дээрх шаардлага эдүгээ үйлчилж байгаа Эрүүгийн болон ЭБШ хуулинд тодорхой тусгалаа олсон. Энэ бүхнээс үзэхэд Монгол Улс эрүү шүүлтийг хориглосон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Үндсэн хууль болон бусад хуульдаа эрүүдэн

шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн гэж болох юм. Түүнчлэн хүний эрхийн Үндэсний Хөтөлбөр баталсан, хүний эрхийн манаанд голлох үүрэг бүхий төрийн дагнасан байгууллага (ХЭҮК)-тай болсон, төрийн албадлагыг хэрэглэдэг төрийн зарим байгууллагын ажилтнуудын үйлдсэн хэрэгт мөрдөн байцаалт явуулах алба бий болгосон зэрэг нь хүний эрх зөрчигдөх, түүний дотор эрүүдэн шүүх явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хэрэгт үр нөлөөтэй арга, механизм болох учиртай.

Эрүүдэн шүүхтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэн гэдэг нь хууль зүйн ойлголт. Эрүү шүүлт хэмээх ойлголтын хүрээ маш өргөн. Үүнийг төрийн албадлага хэрэглэдэг, хэрэгжүүлдэг хүчний байгууллага, тэр тусмаа зөвхөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд гарч болох гажуудал мэтээр үзэж болохгүй. Эрүү шүүлтийн хэлбэр нь төрийн төдийгүй төрийн бус байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, гэр бүлийн хүрээнд ч илэрч болно гэж үзэж байна.

Одоо илтгэлийнхээ үндсэн сэдэвтэй холбоотой зарим асуудалд та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна.

Цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг (гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах), үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх хамгийн их эрсдэл дагуулж болох талтай.

Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба сүүлийн 3 жил (2003-2005)-д цагдаагийн байгууллагын ажилтан нарт холбогдох гэмт хэргийн талаарх 2100 гомдол, мэдээллийн 4.2 хувь буюу 89 нь хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, бусдаар дарамтлуулах, зодуулах зэрэг хууль бус аргаар хэрэг хүлээлгэсэн тухай гомдол, мэдээлэл эзэлж байгааг байж болох мэтээр зөвтгөх хандлага байж болохгүй. Тэгээд ч дээрх тоо жил дараалан 4.2-5.6 хувиар нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Хэдийгээр гомдол бүр үндэстэй, Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэрсийн бүрэлдэхүүнтэй байдаггүй ч шалгалтын явцад байцаан шийтгэх ажиллагааны журам, харилцааны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн дутагдал илрэх нь олонтой тохиолддог. Энэ бол Цагдаагийн байгууллагын ажилтан бүр хууль хэрэглэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх үндсэн зарчмаа тууштай баримтлах мэдлэг, чадвар, сахилга, хариуцлага сул байгаатай холбоотой. Хэрцгий, хүнлэг бус харьцааг хориглох нь хувь хүний нэр төр болон бие махбодь, сэтгэл санааны бүрэн бүтэн цогц байдлыг хамгаалах хамгаалалт юм.

Өнөөдөр Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн 90 гаруй хувийг ЭБШ хуульд заасан харьяаллын дагуу цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан нар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг илрүүлэх үүргийг эрүүгийн цагдаагийн газрын ажилтан нарын дэмжлэг, оролцоотойгоор гүйцэтгэж байна. Гэсэн хэдий ч хэрэг илрүүлэх, гэм бурууг тогтоох мөрдөн байцаалтын ажиллагаанд заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан 11 хэрэгт мөрдөн байцаалт явуулж 3 хэргийг хэрэгсэхгүй болгох, 6 хэрэгт Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1-ээр ялах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын хяналтанд шилжүүлж, одоо 2 хэрэгт мөрдөн байцаалт явуулж байна. Үүнээс шүүх 3 хэргийг хянан шийдвэрлэж 1 хэргийн холбогдогчийн үйлдлийг эрүүгийн хуулийн 99.1 болгон өөрчилж эвлэрүүлэн хэрэгсэхгүй болгож, нөгөө 2 хэргийг холбогдогчид 2 жилийн хорих ял оногдуулж, мөн хугацаагаар тэнсэн хянан харгалзсан байна. Үүнээс гадна цагдаагийн байгууллагын бусад ажилтан (төлөөлөгч, цагдаа гэх зэрэг) нар хэрэг илрүүлэх нэрийн дор сэжигтэн, яллагдагчийг өөрөө болон бусдаар дарамтлуулах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх зэрэг аргаар хэрэг хүлээлгэх, гэмтэл учруулах, хууль бус үйлдэл цөөнгүй бүртгэгдэж эцэстээ Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-ээр зүйлчлэгдэн эвлэрснээр хэрэгсэхгүй болох нь олонтой байна. Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн 251.1 дэх хэсэг нь хүндэвтэр, 251.2 нь хүнд гэмт хэрэгт тооцогддог. Гэтэл мэдүүлэг өгөхийг албадан түүний бие махбодид гэмтэл учруулж байгааг хүний бие махбодид санаатайгаар хөнгөн гэмтэл учруулсан хөнгөн гэмт хэрэг болгон эвлэрүүлэх замаар хэрэгсэхгүй болгож байгаа практикийг эргэн харах учиртай гэж үзэж байна. Мэдүүлэг өгөхийг албадах гэмт хэргийн субъект нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байхаар хуульчлагдсан болохоор дээрх шийдвэрийг буруутгах хууль зүйн үндэс байхгүй юм. Гэсэн хэдий ч эрүүгийн төлөөлөгч нарын хэрэг илрүүлэх, хэрэг хүлээлгэх зорилгоор хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцсан санаатай үйлдлийг ердийн үйлдэлтэй адилтган үзэх нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэхийг судлах шаардлага байж болохыг үгүйсгэхгүй.

Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар догшин авирлах замаар өөрөөр хэлбэл, ЭБШ Хуулийн 92 дугаар зүйлийн 92.4 дэх хэсгийн “Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно” гэсэн заалтыг санаатайгаар зөрчиж нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид түүний дотор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, эрх ашгийг ноцтой зөрчсөн гэмт хэргийн нэг мөн. Хэрэв шүүн таслах ажиллагааны явцад илрээгүй тохиолдолд хэрэг тулган хүлээлгэж

улмаар ял шийтгэл оногдуулах, эсхүл гэмт этгээд ял завших, хохирогчийн эрх ашиг давхар хохирох аюултай үр дагаварт хүргэж болох уршигтай.

Ийм гашуун сургамж шүүхийн практикт нэг бус удаа гарч байсныг бид мартаагүй. Хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх (устгах) гэмт хэрэг жил дараалан нэмэгдэж байна.

Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагчид сүүлийн 3 жил (2003-2005 он)-д эрүүгийн хэргийн нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн 38 холбогдогчтой эрүүгийн 32 хэрэгт мөрдөн байцаалт явуулж 24 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлснээс 11 хэрэг прокурорын хяналтын шатанд, 1 хэрэг шүүхийн шатанд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болсон, 2 хэргийг шүүх цагаатгасан шийдвэр гарчээ. Илтгэл бэлтгэх явцад хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан зарим хэргийн нөхцөл байдлыг шүүх, прокурорын гаргасан шийдвэрийн үндэслэлтэй харьцуулан судлах оролдлого хийсэн юм. Энэ судалгаанаас үзэхэд хуульч бидний хууль хэрэглэх, нотлох баримтыг үнэлэх онол, практикийн сэтгэлгээ ихээхэн зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Жишээлбэл, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын хэрэг бүртгэгч “Э” гэгч иргэн “Н”-ын “Гэрээсээ их хэмжээний эд зүйлээ хулгайд алдсан тухай” илтэд гэмт хэргийн шинжтэй гомдлыг хүлээн аваад эрүүгийн хэрэг үүсгэж байцаан шийтгэх ажиллагааг зохих өсоор явуулахын оронд зохиомлоор хуурамч материал бүрдүүлж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлснийг прокурор хуурамч нотлох баримт бүрдүүлснийг мэдэхгүйгээс эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тогтоол гаргасан үйлдэлд эрүүгийн хуулийн 253.2-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлснийг шүүх “гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй” гэсэн үндэслэлээр цагаатгасан; Увс аймгийн цагдаагийн хэлтэст дадлагажих ажилтнаар ажиллаж байсан цагдаагийн сонсогч “Б” гэгч хэрэг бүртгэх эрх олгосон эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хэрэг бүртгэгчээр ажиллаж байхдаа эрүүгийн хэргийн зарим нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн хэрэгт Увс аймгийн прокурор Эрүүгийн хуулийн 253.2 дахь хэсгээр яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлснийг шүүх “Б”-г хэрэг бүртгэх субъект биш гэсэн үндэслэлээр цагаатгасан; Завхан аймгийн цагдаагийн хэлтсийн хүүхдийн байцаагч “Ц” гэгч эрүүгийн 309460 тоот хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, “А” гэгчийг торгох нэрийдлээр 15000 төгрөг авч оронд нь 3000 төгрөгийн тасалбар бичиж 12000 төгрөгийг завшсан үйлдлийг мөрдөн байцаагч эрүүгийн хуулийн 253.2, 150.1 дэх хэсгээр яллагдагчаар татаж, яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг прокурор ЭБШ Хуулийн 208.1.1 (хэрэг бүртгэх эрхгүй тул гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн) үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. Гэтэл Ц гэгч тухайн онд хамгийн олон хэрэг шийдвэрлэсэн хэлтсийнхээ шилдэг хэрэг бүртгэгчээр шалгарсан байх юм. Булган аймгийн цагдаагийн хэлтсийн

мөрдөн байцаагч “Н”, хэрэг бүртгэгч “Г” нар хэргийн гол гэрчийн мэдүүлгийг хуурамчаар бүрдүүлсний уршгаар иргэн “Х” гэгч шүүхээр ял шийтгүүлсэн нь тогтоогдсон байхад шүүх “Н”, “Г” нарт холбогдох хэргийг “гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй” гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон аж.

Зөвхөн эдгээр баримтаас үзэхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэх үнэлэмж дэндүү зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Магадгүй ийм практик ихээхэн газар авбал хууль, шүүхийн өмнө иргэн бүр эрх тэгш байх зарчим алдагдах, хүний эрх ноштой зөрчигдөх үр дагавар гарч болох юм. Иймд шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн талаар Улсын Дээд шүүх албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй болов уу.

4. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих үндэслэл, нөхцөл байдалтай холбоотой гомдол их гардаг. Эдүгээ мөрдөж байгаа 2002 оны ЭБШХуулиар сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсон, баривчлах, цагдан хорих, үндэслэл журмыг шинэчлэн тогтоож баривчлахцагдан хорих байрыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяалалд шилжүүлсэн явдал хэн нэгэн эрүүгийн төлөөлөгч, мөрдөн байцаагч хорих гэсэн хүнээ хяналтгүй хорьчихдог, зарим сэжигтэн, яллагдагчийг өөрийн санаснаараа камер хорьж дарамтлуулдаг, маршрут заалгах нэрийдлээр таньдаг хүнээ гадуур чөлөөтэй авч явдаг гэх мэт хууль зөрчсөн үйлдлийг сааруулахад эерэгээр нөлөөлж байгаа хандлага ажиглагдаж байгааг үгүйсгэх аргагүй.

Гэвч цагдан хорих байрны нөхцөл байдлаас шалтгаалан цагдан хоригдож байгаа хүмүүс эрүүл мэндийн хувьд, сэтгэл санааны хувьд туйлын хүнд нөхцөлд хоногь өдрийг тэсч ядан өнгөрөөж байгаа нь нууц биш. Үүнийг эрүүдэн шүүхийн хэлбэрийг агуулж байна гэж болох юм. Нөгөөтэйгүүр цагдан хорих байрны нөхцөл нь хэрэг хүлээлгэх арга болоход хүргэж байна. Гэхдээ бүх зөрчлийг цагдан хорих байрны нөхцөл муу байгаагаар хаацайлж болохгүй юм.

5. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн заалт бол Монгол улсын иргэн бүрийн баталгаатай эдлэх халдашгүй эрхийн нэг мөн. Цагдаагийн байгууллагын зарим ажилтан албанахаа эрх мэдэл, ажил үүргийнхээ онцлогийг ашиглаж бусдыг хууль бусаар саатуулах, хорих, хүний биед үзлэг хийх нэрийдлээр эд зүйлийг нь хураан авч завших, шаардлага биелүүлээгүй гэдгээр шалтаглан эрүүл мэнд, эрх чөлөөнд нь халдах, сэтгэл зүйн дарамт үзүүлэх зэргээр хүний эрхийн хэм хэмжээг зөрчих хандлага гарсаар байна.

Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны мэдээ тайлангаас үзэхэд сүүлийн 3 жилд цагдаагийн ажилтнуудаас хүч хэрэглэн хүний амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсан 585 хэрэгт мөрдөн байцаалт явуулсны 83 хэрэг буюу 14.1 хувь нь цагдаагийн ажилтнуудаас ажил үүргээ гүйцэтгэх явцдаа эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцсанаас үүдэлтэй гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энд хэдэн баримт дурдъя. Өмнөговь аймгийн Цагдаагийн хэлтсийн цагдаа “Б” гэгч иргэн “Ц” гэгчийг гэрийнхэ гадна байхад нь чи согтуу байна, эрүүлжүүлнэ гэсэн шалтгаанаар хүч хэрэглэн халдаж хүндэвтэр гэмтэл учруулсан, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч “С” гэгч иргэн “Д”-г таксины мөнгө төлөөгүй гэсэн шалтгаанаар эрүүл байхад нь дүүргийнхээ Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байранд хонуулж улмаар зодож хамрынх нь ясыг хугалсан, Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга “Б”, “Д” нар иргэн “Б”-г таксигаар гэрт хүргэж өгсөнгүй гэсэн үндэслэлээр эрүүлжүүлэх байранд аваачин зодож гэмтэл учруулсан, Баянхонгор аймгийн Галуут сумын хэсгийн төлөөлөгч “Б” гэгч нь иргэн “Э”-г машинаа дайчлуулахаас татгалзсан гэсэн шалтгаанаар түүний толгой руу 2 удаа бороохойдож машиных нь арын багажны хайрцагт хийж машиныг нь дайчлан авч явсны маргааш өдөр иргэн “Э” тархины цууралт авсаны улмаас нас барсан, Эргүүл хамгаалалтын цагдаа “Г” гэгч иргэн “П”-г эрүүлжүүлэх рүү явсангүй гэсэн шалтгаанаар 2 гарыг ард нь хөлтэй нь хобон сойж гавлан толгой руу өшиглөж амь насыг хохироосон, Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын ахлах ахлагч “С” нь “Б” гэгчийг эрүүлжүүлэх байранд дотуур өмдөө тайлсангүй гэсэн шалтгаанаар нүд рүү нь бороохойгоор цохиж хүнд гэмтэл учруулсан, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийн цагдаа “Ч” гэгч иргэн “Э”-г эрүүлжүүлэхдээ чам шиг хөгшин төгцөг хувцсаа яаж тайлдаагийг харуулна гэж хүч хэрэглэн хэргийг авирлаж хүндэвтэр гэмтэл учруулсан, Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч “Ж” гэгч 15 настай “Б”-г хулгайн хэрэгт сэжиглэн шалгахдаа түүнийг 4 хоног гэрт нь явуулахгүйгээр хэсгийн цагдаагийн саатуулах байр, хохирогчийн машинд хорьсон, өмгөөлөх эрхгүй “Т” гэгчийг байлцуулан хүч хэрэглэн дарамталж мэдүүлэг өгөхийг албадсан, Төв аймгийн Цагдаагийн газрын мөрдөн байцаагч “А” нь иргэн “Г”-г бусдын бие мах бодид хүнд гэмтэл учруулсан хэрэгт сэжигтнээр тооцож зориулалтын бус, эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй өрөөнд 7 хүний хамт ямар ч тогтоол, зөвшөөрөлгүйгээр 3 хоног саатуулсан, гэрчүүдийг айлган дарамталсан, хэсгийн төлөөлөгч нь хууль зүйн үндэслэлгүй саатуулагдсан 7 хүнийг хооронд нь хос, хосоор нь төмөр гинжээр холбон палк ачуулсан гэх мэт. Эдгээр нь цагдаагийн ажилтны хууль зөрчсөн, хүнлэг бус хэргийг ажиллагааны баримт юм. Энэ илтгэлд дурдсан тоо баримтыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, нэр

хүндийг унагах зорилгоор бус, нөхцөл байдалд бодитой дүгнэлт хийх, цаашид энэ төрлийн зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ авахуулах, энэ ажилд хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын санаачлага, дэмжлэгийг идэвхжүүлэх ажил зохиогоосой гэсэн утгаар хэлж байгаа гэдгийг энэ зөвлөлгөөнд оролцогчид болон цагдаагийн байгууллагын удирдлага нийт бие бүрэлдэхүүн зөвөөр ойлгоно гэдэгт найдаж байна.

Бидний үзэж байгаагаар цагдаагийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаа эрүүдэн шүүх хэлбэр бүрэн арилаагүй цагдаагийн зарим ажилтны ажлын арга барил, сэтгэлгээ шинэчлэгдээгүй байна гэсэн дүгнэлт хийж болох юм. Хүний эрх түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах явдал зөвхөн цагдаагийн байгууллагын хүрээнд оршиж байгаа хандлага гэж ойлгож болохгүй гэдгийг дахин хэлье. Энэ нь төрийн бусад байгууллага ялангуяа цэрэг арми, хорих байгууллагын хүрээнд нэгэн адил бий шүү гэдгийг хэлэх ёстой.

Эрүү шүүлтэд өртөж буй хүмүүсийн дийлэнх нь нийгмийн эмзэг хэсгийнхэн буюу ахуй амьдралын хувьд ядуу, дорой байдлаас шалтгаалан сайн өмгөөлөгч хөлслөх санхүүгийн боломжгүй, хууль эрхийн мэдлэг сулаас өөрийнхөө эдлэх ёстой эрхээ хэрхэн хамгаалуулах арга замаа мэддэггүй хүмүүс байдгийг мартаж болохгүй. Ийм учраас эрхээ хамгаалах санхүүгийн болон эрх зүйн боломжгүй хүмүүсийг төрийн зүгээс онцгой анхаарч тийм хүмүүст үнэ төлбөргүй үйлчлэх өмгөөллийн тогтолцоо бий болгох шаардлагатай байна. Ийм үйлчилгээг төрөөс санхүүжүүлэх ёстой. Ингэснээр сэжигтнээр тооцсон үеэс өмгөөлүүлэх эрхийг хүссэн, хүсээгүй хангах нөхцөл байдал бий болно. Үүнийг дагаж эрүүдэн шүүх боломж хязгаарлагдаж, иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим бодитой хэрэгжих нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

ЭРҮҮ ШҮҮЛТ БА ХҮНИЙ ЭРХ

Монгол улсын Үндсэн хуульд: “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасан /Арванзургадугаар зүйлийн 13, 14/. Үндсэн хуулийн энэ заалт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд чанд мөрдөгдөх ёстой. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд /2002 он/: “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй, сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгааныг мэдэгдэж, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна” /ЭБШХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5/ гэж, Эрүүгийн хуульд /2002 он/ “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан бол гэмт хэрэг гэж үзэж ял шийтгэл оноохоор заасан байна /ЭХ-ийн 251 дүгээр зүйл/.

Түүнчлэн Монгол улс 2000 оны 11-р сарын 2-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенцид /цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц гэх/ нэгдэн орсон. Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хуулиар хориглосноор эрүү шүүлтээс ангид байх эрх бүрэн хангагдахгүй нь ойлгомжтой. Хэдийгээр хүний эрхийг зөрчсөн тийм үйлдлийг дээрх хуулиудаар хориглосон, хариуцлага хүлээлгэхээр заасан байгаа боловч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд, ялангуяа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хүнийг эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар харьцах, доромжлох явдал байнга гарсаар байгааг иргэдийн өргөдөл, гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнчлэн нэгэнт шалгагдаж тогтоогдсон баримтуудаас харж болно.

Иймд эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг судалж, санал дүгнэлт гаргах зорилгоор Хүний Эрхийн Үндэсний Комиссоос “Эрүүдэн шүүхийг хориглох нь” сэдэвт нэг жилийн хугацаатай, нээлттэй хяналт шалгалтын ажлыг 2005 онд зохион байгуулсан болно. Энэхүү хяналт шалгалтын хүрээнд хууль тогтоомж, дүрэм, журам нь эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх оновчтой хөшүүрэг болж чадаж байгаа эсэх, ийм хууль бус арга ажиллагаанд ямар хүчин зүйлүүд нөлөөлж байгааг судлан тогтоох,

түүнээс урьдчилан сэргийлэхэд цаашид явал зохих талаар санал, зөвлөмж боловсруулах зорилтуудыг тавьсан. Түүнчлэн шүүгч, өмгөөлөгч, прокурор, цагдаагийн ажилтнууд, иргэд, төрийн бус байгууллагын ажилтнуудын санал бодлыг судалж, иргэдээс өргөдөл, мэдээлэл хүлээн авч шалгаж тодруулах, зарим хэрэг материалыг уншиж судлах, баривчлах, цагдан хорих байруудад үзлэг шалгалт хийх, тэнд хоригдож буй хүмүүстэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтын явцад цуглуулсан мэдээлэл, баримтанд тулгуурлан эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийв.

Нэг. Эрүүдэн шүүхийг хориглосон олон улсын гэрээ, конвенци ба үндэсний хууль тогтоомж

Монгол улсын Үндсэн хуульд: Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ хэмээн заасан /Аравдугаар зүйл/. Түүнчлэн Монгол улсын ихэнхи хуулиудад Монгол улсын олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжтой зөрчилдвөл олон улсын гэрээг баримтална гэж заасан байдаг. Монгол улс 2000 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нэгдэн орсон хэдий ч энэхүү конвенцийн заалт үндэсний хууль тогтоомжид бүрэн хэмжээгээр тусгагдаж чадаагүй ба уг конвенцийн үзэл санаа, шаардлагууд амьдралд хэрэгжихгүй байна.

1.1. Конвенцид зааснаар оролцогч улс бүр эрүүдэн шүүх үйлдлийг эрүүгийн хуулиараа гэмт хэрэг гэж үзэх ба эрүүдэн шүүхийг завдах, түүнд хамтран оролцохыг гэмт хэрэгт тооцох үүрэг хүлээсэн. Манай улсын Эрүүгийн хуульд /2002 он/ одоо болтол энэхүү конвенцид зааснаар эрүү шүүлтийг тодорхойлсон зүйл заалт байхгүй.

Харин Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр, энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн заасан байна. Энэ зүйлийг эрүү шүүлтийг хориглосон, гэмт хэрэгт тооцсон заалт гэж үздэг.

1.2. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид бие махбодь болон сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох гэсэн хоёр төрлийн үйлдлийг эрүү шүүлт гэж тодорхойлсон байхад Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнээс харахад зөвхөн бие махбодийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, сэтгэл санааны хүчирхийллийг орхигдуулсан байна. Иймээс эрүү шүүлтийн хоёр хэлбэрийг хоёуланг нь гэмт хэрэг гэж авч үзэж энэ зүйл ангийг өөрчлөн найруулах шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэсэн хоёр төрлийн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохоор байгаа нь конвенцийн заалттай нийцэхгүй байна. Конвенцид энэ гэмт хэргийн субъект нь “төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд” байх, өөрөөр хэлбэл эрүүдэн шүүсэн гэмт хэргийн субъект нь төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй хэн боловч байж болохоор байхад манай эрүүгийн хуульд хоёрхон төрлийн албан тушаалтнаар хязгаарласан байна. Иймээс прокурор, цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуулын байгууллагын албан тушаалтнуудын зүгээс үйлдсэн ийм төрлийн гэмт хэргийг эрүү шүүлт хэмээн үзэж, тусгайлан зүйлчлэх боломжгүй байна. Түүнчлэн эрүүдэн шүүх зөвшөөрөл олгосон, хатгасан, хамтран оролцсон, хамжсан зэрэг үйлдлийг эрүүдэн шүүхэд хамтран оролцсон гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид заасан боловч энэ талаар манай Эрүүгийн хуулинд тусгагдаагүй байна. Гэтэл эрүүгийн хэргийг илрүүлэх, байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд эрүүдэн шүүх болон хэрэг тулган хүлээлгэх үйл ажиллагааг өөрөө гардан гүйцэтгэхээсээ өрөөл бусдаар, хамт хоригдогсдоор нь, удаа дараа ял шийтгүүлсэн хүмүүст даалгавар өгч хийлгэх байдал ажиглагдах болсон. Үүнийг ч хуулиндаа тусгаж, зохицуулах хэрэгтэй байна.

1.3. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсийг байцаахтай холбогдсон журам, заавар, арга хэрэгслэл, түүнчлэн тэднийг хянан харгалзах, харьцах журам, арга хэмжээнд шат дараалсан хяналт тавих /Конвенцийн 11 дүгээр зүйл/, эрүүдэн шүүх үйлдэл үйлдэгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал мөрдөн шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаараа шударга, шуурхай явуулах /Конвенцийн 12 дугаар зүйл/ ёстой атал манай Эрүүгийн байцаан шийтгэх хуульд энэ талаар тусгайлсан ямар нэг заалт байхгүйгээс эрүүдэн шүүлт, зүй бус харьцаанд өртсөн тухай гомдол, мэдээлэл нь бусад өргөдөл, гомдлын ерөнхий тогоонд хутгалдаж, ихэнхи тохиолдолд хараат бус, хөндлөнгийн, шударга мөрдөн шалгалтгүйгээр, байгууллага, албан тушаалтнуудын хэлбэрийн төдий явцуу лавлагаа, тодорхойлолтоор хязгаарлагдаж байна.

1.4. Конвенцийн 14 дүгээр зүйлд оролцогч улс бүр өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй хэмээн заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд /2002 он/ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг, бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгахтай холбоотой асуудлыг зохицуулсан Дөчин дөрөвдүгээр бүлэг шинээр орсон боловч энэ бүлэгт эрүүдэн шүүгдсэн болон хэрцгий, хүнлэг бус харьцсаны улмаас иргэнд учирсан эрүүл мэндийн болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тухай асуудал огт тусгагдаагүй орхигдсон байна. Энэ бүлэгт заасан хохирол нөхөн төлүүлэх үндэслэлүүд гэдэгт зөвхөн хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, цагдан хоригдсон, албан үүргээ биелүүлэхийг нь хориглосон, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ авагдсан зэрэг хууль бусаар хоригдсон буюу хууль бусаар ял шийтгүүлсэн зэрэг тодорхой тохиолдлуудыг нэрлэн зааж, энэ тохиолдолд учирсан зөвхөн эд хөрөнгийн хохирлыг /авч чадаагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, хураасан, улсын орлого болгосон эд хөрөнгө, төлсөн торгууль, шүүхийн зардал, өмгөөлөгчид төлсөн хөлс зэрэг/ л гаргуулахаар тусгагдсан байна. Эрүүдэн шүүгдсэн болон хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж амь нас, бие эрхтэн, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирсон этгээдийн хохирлыг арилгах, нөхөн төлбөр төлүүлэх асуудлыг зохицуулсан заалт байхгүй байна. Конвенцид эрүү шүүлт болон хэрцгий хүнлэг бус харьцаанд өртөж амь насаа алдсан тохиолдолд гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд нь нөхөн төлбөр авах эрхтэй гэж заасан. Энэ бүлэгт сэтгэл санааны буюу эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө /ЭБШХ-ийн 391 дүгээр зүйл/ гэсэн боловч Иргэний хуульд эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт байхгүй байна. Үүнээс үзвэл манай улс эрүүдэн шүүгдсэн болон хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж эрүүл мэнд, амь нас, сэтгэл санаагаараа хохирсон иргэнд учирсан хохирлыг шударгаар барагдуулах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж чадаагүй байна. Эрүүдэн шүүсэн болон хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж хохирсон иргэдэд хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин зохих ёсоор бүрдээгүйгээс энэ асуудлаар гарсан нэхэмжлэл шударгаар шийдвэрлэгдэхгүй байна.

- Төв аймгийн иргэн “Г” адуу хулгайлсан хэрэгт холбогдон, 26 адуу хулгайлсан хэргээ хүлээсэн байна. Түүнд өөр олон тооны адуу хулгайлсан хэрэг тулгаж, тус аймгийн цагдан хорих төвд удаан хугацаагаар хорьж мөрдөн байцаалт явуулснаас болж тэрээр 15 кг-аар жин нь буурч, 44 кг болтлоо турж, тэнд сүрьеэ өвчин тусч

эмчилгээ авахгүй болтлоо хүндэрч, шүүхээр таслагдсаныхаа дараахан нас барсан байна. Тэрээр удаа дараа бие муу байгаа талаараа мэдэгдэж байсан боловч цагдан хорих байрны эмнэлэгт хэвтүүлсэн нэр хэмээж, сүрьеэ өвчтэй болсныг нь ч мэдээгүй байсаар эмчилгээ авахгүй болтлоо хүндэрч амь насаа алджээ. Түүний ээж, зарим хуульчид хамтарч “Г”-г эрүүдэн шүүж, шоронгийн хүнд, хатуу нөхцөлд удаан хорьсноос өвчин тусч амь насаа алдсан, хэрэг бүртгэх мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хэрцгий, хүнлэг бус хандсан, хоригдон мөрдөгдөж буй этгээдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ аваагүй гэж үзэж 30.0 сая төгрөгний нөхөн төлбөр авахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэгчид бага бус зардал гаргаж, гурван шатны шүүх дамжин заргалдсан хэдий ч шүүх энэ маргааныг хянан шийдвэрлэхдээ “Г”-г цагдан хорьж мөрдөн байцаалт явуулж байсан нь хууль зөрчсөн гэх үндэслэлгүй байна хэмээн дүгнэж нэхэмжлэлийг нь хэрэгсэхгүй болгож, нэг ч төгрөгний хохирол гаргаж олгоогүй байна. Өөрөөр хэлбэл, удаан хугацаагаар цагдан хорьж, эрүүл мэнд нь муудаж амь насаа алдсаныг хууль ёсны байж болох асуудал гэж үзжээ /Төв аймгийн шүүхийн 2003 оны а/237 дугаар шийдвэртэй хэргийн материалаас/.

- Дээрэм, хүн амины хэрэгт холбогдон Ганц худгийн цагдан хорих төвд 2 сар гаруй хугацаагаар цагдан хоригдож, зодуулж, цохиулж эрүү шүүлтэд өртөж байсан иргэн “О” шүүхэд хандаж хохирлоо гаргуулахаар нэхэмжлэл гаргасан боловч эд хөрөнгийн бодит зарим хохирлыг гаргаж, харин эрүүдэн шүүгдсэний улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нь хэрэгсэхгүй болгосон байна.

Хүн амины хэрэгт холбогдон 300 гаруй хоног хоригдон мөрдөгдөж байсан “Ш”-ийн нүднийх нь хараа муудсаар, хоёр нүд нь сохорч нүдээ авахуулсан ба түүний үйлдэл нотлогдоогүйгээс хэргийг нь хэрэгсэхгүй болгосон байна. Амин чухал эрхтэнээсээ салсан энэ хүний хохирлыг барагдуулах, төрөөс нөхөн төлбөр гаргуулахаар ХЭҮК-оос Баянзүрх дүүргийн шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргасан боловч Сүхбаатар дүүргийн прокурорын газраас хэргийг дахин сэргээн мөрдөж, айлган сүрдүүлэх, дарамтлах үйл ажиллагаа явуулж, улмаар шүүх дээрхи нэхэмжлэлийг нь хэрэгсэхгүй болгож байв. Түүнд дахин өргөдөл гомдол гаргаж хохирлоо нэхэмжлэхийг санал болгоход дарамт шахалтад өртсөн нь мэдрэгдэж, “эргээд л хэргийг сэргээж бөөн юм болох байх” хэмээн хариулж байв.

Эдгээр баримт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүсэн болон хэрцгий, хүнлэг бус хандсаны улмаас иргэдэд учирсан эд хөрөнгө, эрүүл мэнд, амь нас, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин байхгүй, шүүхээс ийм төрлийн маргааныг хянан шийдвэрлэх талаар нэгдмэл практик тогтоогүйг харуулж байна. Хуульд

заасан тодорхой үндэслэл байвал сэжигтэн, яллагдагчийг аливаа гэмт хэрэгт холбогдуулан баривчлах, цагдан хорих, мөрдөн байцаалт явуулах нь төрийн эрх бүхий албан тушаалтны эрх мөн хэдий ч түүний амь нас, эрүүл мэнд, нэр төрийг хамгаалах нь мөн л төрийн үүрэг байх ёстой. Төр энэ үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол учирсан хохирлыг нөхөн төлөх ёстой. Үүний тулд холбогдох хууль тогтоомждоо зохих өөрчлөлт оруулах, энэ төрлийн нэхэмжлэл, гомдлыг хянан шийдвэрлэх шүүхийн практик тогтоох шаардлагатай байна.

1.5. Конвенцид /15 дугаар зүйл/: оролцогч улс бүр эрүүдэн шүүх замаар гаргуулсан болох нь тогтоогдсон мэдүүлгийг эрүүдэн шүүсэн хэрэгт яллагдаж буй этгээдийн эсрэг ийнхүү мэдүүлэг гаргуулсны нотолгоо болгохоос бусад тохиолдолд шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахгүй байх явдлыг хангана гэж заасныг хууль тогтоогч шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд /2002 он/ анхааран авч үзээгүй. ЭБШХ-д “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” /ЭБШХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3/, “нотлох баримтыг цуглуулахдаа ... бусдын нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэршгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно” /ЭБШХ-ийн 92 дугаар зүйлийн 92.4/ гэж тус тус заасан боловч эдгээр хориглолтыг зөрчөөд нэгэнт авчихсан, хавтаст хэрэгт орчихсон мэдүүлгийг хэргийг шийдвэрлэхэд хэрхэн авч үзэх, үнэлэх, улмаар нотлох баримтанд тооцох эсэх талаар ЭБШХ-д заагаагүй орхисон. Иймээс практик дээр ийм замаар гаргуулсан мэдүүлгийг бусад нотлох баримтын нэг адил үнэлж, гэм буруутайд тооцох үндэслэл болгож ашигласаар байгаа нь конвенцийн дээрх заалттай илт зөрчилдөж байна.

Хууль бус аргаар гаргуулж авсан мэдүүлгийг нотлох баримтанд тооцохгүй байхаар ЭБШХ-д оруулж өгөх нь өнөөдрийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд анхны хэрэг хүлээлгэсэн мэдүүлгүүдийг өмгөөлөгчгүйгээр, насанд хүрээгүй хүмүүсийн хувьд хууль ёсны төлөөлөгч, багш, сурган хүмүүжүүлэгчгүйгээр авдаг гаж буруу практик, аргыг таслан зогсооход чухал ач холбогдолтой юм.

1.6. Эрүүдэн шүүх болон бусад хууль бус аргаар мэдүүлэг авахаар албадсан хэрэгт /ЭХ-ийн 251 дүгээр зүйл/ зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэсэн хоёр субъектээр хязгаарласан нь учир дутагдалтай байна. Хуулийн байгууллагын ажилтнуудаас ялангуяа, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтнуудаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа тухайлбал, хэрэг зөрчилд холбогдуулан албадан саатуулах, баривчлах, байцаалт авах, цагдан хорих, эрүүлжүүлэх явцдаа эрх

хэмжээгээ хэтрүүлэн бусдын эрх чөлөөнд халдаж, хэрцгий хандаж бие эрхтэнд гэмтэл учруулсан, амь насыг нь хохироосон үйлдлийг албан тушаалын эсрэг гэмт хэрэгт тооцож, тусгайлан зүйлчилж хариуцлага хүлээлгэхгүй, зөвхөн хоёр иргэний хоорондын асуудал мэтээр ердийн зүйл ангиар ял, хариуцлага хүлээлгэж байна.

Эрүүгийн хуулийн Хорин наймдугаар бүлэгт албан тушаалын гэмт хэргийг тусгайлан зүйлчилсэн ба мөн хуулийн 263, 264 дүгээр зүйлд төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, эрх мэдлээ хэтрүүлэх гэсэн гэмт хэргийг тодорхойлсон. Гэвч энэ зүйлд заасан албан тушаалтан гэсэн ойлголтыг эрүүгийн хуулиар тайлбарлахдаа төрийн улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний албаны **удирдах албан тушаалтан** энэ бүлэгт заасан албан тушаалтанд хамаарна гэж тайлбарласан байна. Эрүүгийн хуулиар энэ бүлэгт заасан гэмт хэргийн субъект нь зөвхөн удирдах албан тушаалтан байхаар тайлбарласнаас хүний эрх, эрх чөлөөнд халдах, хязгаарлах эрх мэдэл, үүргийг хүлээсэн хуулийн байгууллагын удирдах бус гүйцэтгэх ажилтнууд энэ зүйл ангиудаар хариуцлага хүлээх боломжгүй болдог байна.

Үүний зэрэгцээгээр тухайн гэмт хэргийн улмаас үлэмж буюу их хэмжээний хохирол учирсан байхыг шаарддаг. Иймээс эдгээр зүйл ангиар албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах зэргээр бусдын бие эрхтэнд гэмтэл учруулсан, эрх чөлөөнд нь хохирол учруулсан хэрцгий, хүнлэг бус харьцсан хуулийн байгууллагын удирдах бус албан тушаалтан хариуцлага хүлээх боломжгүй байна. Хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хэмжээгээр халдах төрийн онцгой эрх мэдлийг хэрэгжүүлдэг албан тушаалтнууд энэ эрх хэмжээгээ урвуулан ашиглах, хэтрүүлэх зэргээр иргэдийн бие эрхтэнд халдаж, гэмтэл учруулж, эрх ашгийг нь хохироох гэмт хэрэг үйлдвэл тэрхүү үйлдлийг тусгайлан зүйлчилж, илүү өндөр хариуцлага хүлээлгэдэг, тухайн хэргийг мөрдөн шалгахдаа ердийн хэргээс өөр журам баримталдаг байх шаардлагатай байна. Ийм журам байхгүй байгаагаас шалтгаалан хуулийн байгууллагын ажилтнуудаас албан үүргээ биелүүлэх явцдаа бусдын эрх чөлөөнд халдаж албаны эрх мэдлээ хэтрүүлж, бусдын биед гэмтэл учруулсан, хэрцгий хандсан, амь насыг хохироосон хэргүүд ихэвчлэн нотлогдоогүй буюу эвлэрсэн, хохирлоо нөхөн төлсөн гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгогдон шийдвэрлэгдэж байна. 2005 онд гэхэд цагдаагийн байгууллагын 256 ажилтан гэмт хэрэгт холбогдон шалгагдаж тэдний 50 гаруй хувь нь хэрэгсэхгүй болгогдсон байгаа нь бусад төрлийн хэрэг, маргаантай харьцуулахад илүү “нааштайгаар” шийдвэрлэгдсэн байна.

1.7. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, байцаах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн

бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг бүрэн тусгана хэмээн заасан. Улсын хэмжээний хууль зүйн боловсрол олгож байгаа их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартуудад эрүүдэн шүүхийн эсрэг конвенци, түүнтэй тэмцэхтэй холбоотой сургалтын агуулга тусгагдаагүй байна. Монгол улс эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн оролцогч улсын хувьд энэхүү гэрээнд нэгдэн орсноосоо эхлэн конвенцийн заалтыг дотоодын хууль тогтоомждоо тусгах, олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээ авах ёстой. Гэвч 2000 онд энэхүү гэрээнд нэгдэн орсноос хойш энэ чиглэлээр зохион байгуулж, хийсэн бодлогын шинжтэй тодорхой арга хэмжээ авагдаагүй байна.

Хоёр. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцах, шийтгэхийн илрэлүүд

Тус Комиссоос хяналт шалгалтын ажлын хүрээнд хуулийн байгууллагын 600 орчим ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж, цагдан хоригдож буй 1400 орчим хүнээс санал асуулга авч, 100 гаруй хүнтэй биечлэн уулзаж, иргэдээс 50 орчим өргөдөл, гомдол хүлээн авсан байна. Эрүү шүүлтийн талаар хуульчид харилцан адилгүй санал, бодолтой байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, шүүгчид "... хэрэгт холбогдогчид шүүх хурлын үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж, айлган сүрдүүлж, дарамталж хэрэг хүлээлгэсэн, би энэ хэргийг хийгээгүй гэж мэдүүлэх тохиолдол нилээд гардаг" гэж, өмгөөлөгчид "... хэрэгт холбогдогчдыг зодох, дарамтлах, хатуу ширүүн харьцах, хүчээр хэрэг хүлээлгэх зэрэг зөрчил багагүй байдаг" гэж, прокурорууд "... ийм зөрчил дутагдал бараг байдаггүй бид байнгын хяналт тавьдаг" гэж ихэвчлэн хариулж байна.

Харин хэрэгт холбогдон мөрдөгдөж байгаа хүмүүсийн санал бодлыг судалж үзэхэд, санал асуулгад хамрагдсан 1338 хүний 39.9 хувь нь дарамталж, айлган сүрдүүлж хэрэг хүлээлгэдэг гэж, 32.0 хувь нь зодож, хүч хэрэглэж хийгээгүй хэрэг хүлээлгэдэг гэж хариулсан байна. Ялангуяа, Ганц худаг болон Төв аймагт хоригдож байсан хүмүүс энэ асуултанд харьцангуй их хариулсан байна. Тухайлбал, Ганц худагт хоригдогсдын 44.6 хувь нь айлган сүрдүүлж, дарамталдаг гэж, 36.7 хувь нь хүч хэрэглэж зодож дарамталдаг гэж тус тус хариулсан байна.

Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах албанд сүүлийн 3 жил /2003-2005/-д хуулийн байгууллагын ажилтнуудтай холбоотой гэмт хэргийн шинжтэй 2100 гомдол, мэдээлэл ирж шалгагдсан ба эдгээр мэдээллийн 4.2 хувь нь буюу 89 мэдээлэл нь хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, бусдаар дарамтлуулах, зодуулах зэрэг хууль бус арга

хэрэглэж хэрэг хүлээлгэсэн тухай мэдээлэл байсан байна. Харин ийм гомдол, мэдээллийн тоо жил дараалан 4.2-5.6 хувиар өссөн болох нь Мөрдөн байцаах албаны мэдээ тоо баримтаас харагдаж байна. Тус албанаас сүүлийн 3 жилд хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан 11 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, 3 хэргийг хэрэгсэхгүй болгож, 6 хэрэгт Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1-ээр ялах дүгнэлт үйлдэх саналтай прокурорт шилжүүлж байжээ. Эдгээр тоо баримт, санал асуулгын дүнгээс үзвэл эрүүдэн шүүх, хүч хэрэглэх, дарамтлах замаар мэдүүлэг авахыг албадсан шинжтэй хүний эрхийн зөрчил байнга гарсаар байна гэж үзэх үндэстэй.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн асуудлаархи Тусгай Илтгэгч Манфрэд Новак 2005 онд Монгол улсын Засгийн газрын урилгаар айлчилж, Монгол дахь эрүү шүүлтийн нөхцөл байдлын талаар илтгэл бэлтгэж, түүндээ: Монгол улсад хууль сахиулах байгууллагын албан хаагчдаас, ялангуяа цагдаагийн албадан саатуулах байр, цагдан хорих газар, чанга, онцгой дэглэмтэй хорих ангиудад хүмүүстэй эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцах явдал оршоор байна. Гэмт хэрэгт холбогдогчийн эсрэг тодорхой хүч хэрэглэхийг хүлээн зөвшөөрдөг зан үйлийн хандлага тогтсон ба сэжигтэн, яллагдагчийг ялахын тулд гэм бурууг нь хүлээлгэхийг зорьдог арга барил давамгайлж, энэ нь эрүү шүүлтийг бий болгоход нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна /Тусгай Илтгэгчийн илтгэлээс/.

2.1. Эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар харьцахтай холбоотой хүний эрхийн зөрчлийн дараахи илрэлүүд онцгой анхаарал татаж байна.

2.1.1. Хяналт шалгалтын явцад ирсэн өргөдөл гомдлыг хянаж шалгах, цагдан хоригдож буй хүмүүстэй уулзах явцад эрүүгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар зодож дарамталдаг, тэд харгис, хэрцгий хүний ёсноос гадуур харьцдаг тухай гомдол цөөнгүй байна.

Дархан-Уул аймгийн цагдан хорих байранд шалгалт хийхэд тэнд хоригдож байсан 87 хүнээс 10 гаруй нь хэргийг нь шалгаж буй байцаагч нартаа зодуулж, дарамтлуулдаг тухай гомдол гаргаж байв. Хэрэг хүлээхгүй байна гэж хоол, цайг нь өгөхгүй өлсгөж цангаах, бие засах, унтах, хэвтэхийг нь хорих, зодох, цохих зэргээр тамлан зовоодог.

- Хүн амины болон онц ноцтой хэргийг хүлээлгэхийн тулд ямар арга хэрэглэж, яаж эрүүдэн шүүдэг болохыг нэр бүхий хэдэн хүний түүх гэрчилнэ. 1999 оны 1 дүгээр сард Баянзүрх дүүргийн “Food Land” хүнсний захын манаачийг алж, алт мөнгөн эдлэл дээрэмдсэн хэрэг гарсан. Энэ хэрэгт таван хүнийг холбогдуулан шалгаж, тэднийг олон жил, сараар хорьж, эрүүдэн шүүсний улмаас нэг нь нас барж, зарим нь амьд гарахын тулд хилсээр хэрэг хүлээж, эцэст нь нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн 2004 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн

350 дугаар цагаатгах тогтоолоор тэднийг энэ хэрэгт холбогдолгүй болохыг тогтоож цагаатгасан.

Энэ хэрэгт холбогдон мөрдөгдөж эрүү шүүлтэд өртсөн “О” /1115 хоног хоригдсон/, “О” /315 хоног хоригдсон/, “Х” /201 хоног хоригдсон/, “Б” /1252 хоног хоригдсон/ нар ХЭҮК-т гаргасан өргөдөлдөө: Биднийг хилс хэрэгт холбогдуулан баривчилж, Ганц худгийн подвалын 7-9 камер дамжуулан хорьж, шинэ камер болгонд ороход тэнд хоригдож байсан хүмүүс “алуурчид хийсэн хэргээ хүлээ, нуусан алт мөнгөө гаргаж өг” гэж шаардаж, бакал гутал болон наарны 5 см-ын банзаар биеийн бүхий л газраар цохиж, зодуулаад хөдөлж чадахгүй болоход шалан дээр ус асгаж байгаад нүцгэлж, нүцгэн биеэр хэвтүүлж, асгасан усандаа тог хүргэж тогоор цохиулж, гялгар уут болон сойзны иш түлж хайлуулж бие дээр тусаах наах, нойр, хоолгүй хонуулах зэрэг аймшигт тамлалыг биеэрээ амсаж, эцэст нь сүрьеэ өвчин тусаж аймшигтайгаар хохирсон. Цагдаа /байцаагч/ нар ирэхдээ “ярих юм байна уу” гэж асуугаад байхгүй гэхээр “өө наадах чинь болоогүй байна, буцаагаад хийчих” гэдэг байсан гэжээ /ХЭҮК-ын 2005 оны архивын 127 тоот өргөдлөөс/.

Сойз болон гялгар уут шатааж биед нь нааж, түлж байсан үл мөр одоо ч тэдний бие эрхтэн дээр тодорхой харагддаг.

Энэ хэрэгт холбогдон мөрдөгдөж байгаад нас барсан “Д”-ийн эх “С” гаргасан өргөдөлдөө: Миний хүүг энэ хэрэгт холбогдуулан баривчилж Ганц худагт хорьсон. Байцаагчтай нь уулзах гээд очихоор “алуурчны эх чи энд орж ирэх ямар эрхтэй юм бэ, чиний хүүхэд хүн алчихаад байхад” гээд өрөөнөөсөө хөөдөг байсан. Тэгээд нэг намар хүүгийн чинь бие муу байна гаргаж ав гэж хүнээр хэлүүлсэн байсан. Ганц худагт очиж хүүгээ гаргаж авахад яс арьс болтлоо турсан, төмсөг нь салтаандаа багтахгүй хавдартай бас сорвитой, толгой нь яр шарх, сорвиндоо баригдсан, өрөөсөн чих нь дүлий болчихсон байсан, миний хүү: “тэртэй тэргүй хүү нь өнгөрнө, зодуурын амт их үзлээ дээ” гэж уйлж байсан. Тэгээд хорихоос гаргаж, сүрьеэгийн эмнэлэгт хэвтүүлээд 3 хоноод нас барсан гэж бичжээ /ХЭҮК-ын 2004 оны архивын 58 дугаартай өргөдлөөс/.

2.1.2. Камерт хамт хоригдогсдоор нь зодуулж, дарамтлуулж хэрэг хүлээлгэдэг тухай гомдол мэдээлэл анхаарал татсан асуудал хэвээр байна. 2002 онд Улсын Ерөнхий Прокурорын газраас Ганц худагт хийсэн шалгалтын дүнг Монгол улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хороогоор авч хэлэлцээд тэнд хоригдогсдыг нэгийг нөгөөгөөр нь зодуулж, дарамтлуулж хэргийг нь хүлээлгэдэг ноцтой зөрчил зарим эрүүгийн төлөөлөгч, мөрдөн байцаагчдын ажлын арга барил болсон байна гэсэн дүгнэлтийг хийж, энэ зөрчлийг таслан зогсоохыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон тогтоол гаргаж байсан. Гэвч энэхүү “арга

барил” нь улам лавшран үргэлжилсээр байгаа нь хяналт шалгалтын явцад тодорхой харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд урьдчилан хорих газар хоригдож байх хугацаандаа хорих байрны ажилтан болон хамт хоригдогсоддоо зодуулж эрүүл мэнд, амь насаараа хохирсон тухай ноцтой гэмт хэрэг гарсаар байна.

- Хүн амины хэрэгт сэжиглэгдэн Ганц худгийн цагдан хорих төвд цагдан хоригдсон иргэн “Г”-г ноцтой хүн амины хэрэг үйлдсэн “У” гэгчтэй хамт хорьж, цагдан хорих байрны ажилтан гаднаас согтууруулах ундаа оруулан өгч “Б” гэгч түүнийг хэрцгийгээр зодож амь насыг хохироосон хэрэг гарсан. Эцэст нь энэ хэрэг зөвхөн хоёр хүний хоорондын таарамжгүй харьцаанаас болсон хэргээр шийдэгдсэн.
- 2005 оны 6 дугаар сард Баянзүрх дүүргийн цагдаагийн ажилтнууд иргэн “М”-ийг хүн амины хэрэгт сэжиглэн ар гэрт нь мэдэгдэлгүйгээр Ганц худагт 3 хоног хориод ар гэрийнхэнд нь хүлээлгэж өгөхөд тэрээр эрүүл газаргүй боллоо зодуулж, ухаан санаа нь муудсан байсан ба гэмтлийн эмнэлэгт очоод удалгүй амь насаа алдсан ноцтой хэрэг гарсан. Энэ хэрэгт зарим нэг хянагч холбогдож шалгагдаж байгаа боловч, талийгаачийн биед учирсан гэмтэл, ар гэр, эх эцэгт нь мэдэгдэлгүй хорьсон, хаана байгааг нь хэлэхгүй нууцалж байснаас үзэхэд, хэрэг хүлээлгэх зорилгоор эрүү шүүлт явагдсан гэж хэлэх бүрэн үндэстэй.
- Хулгайн хилс хэрэгт сэжиглэгдэж, Ганц худагт 36 хоног хоригдсон иргэн “Б” эрүү шүүлтэд өртсөн талаар өгсөн мэдүүлэгтээ: Би эхний 14 хоног сэжигтэн гэж хоригдсон, надад нэгэнт хийсэн хэрэг байхгүй тул хүлээх зүйлгүй гэдгээ хэлсэн. Тэр сэжигтний хугацаа нь өнгөрөөд яллагдагчаар үргэлжлүүлэн хорихдоо өөр өрөөнд оруулсан, гэтэл тэнд байсан хоёр залуу “чи яасан хэргээ хүлээдэггүй хулгайч вэ, хэргээ хүлээ” гээд 54 настай аав шигээ намайг цементэн шалан дээр хөл нүцгэн олон цагаар зогсоох, битүү цохилт хийх, элэг, бөөр, толгойд гараараа цохих, ислэг хавтан, труба болон гутлаар өгзөг, хөл гарын булчинлаг хэсгүүдэд цохиж тамлан зовоож, бие махбодь, сэтгэл санааны хүнд дарамтанд оруулж, хилс хэрэг хүлээлгэхийн тулд маш идэвхитэй үйл ажиллагаа явуулсан гэж ярьсан байв.

Олон удаа ял шийтгүүлсэн болон онц хүнд гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй хүний камерт зарим сэжигтэн, яллагдагчийг зориуд оруулж, хэрэг хүлээхийг дарамтлуулах, мэдүүлгээ хэрхэн өгөхийг зааж өгөх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас байцаалтын үед тавьж байсан асуултуудад хэрхэн яаж хариулах ёстойг зааж, мэдүүлэг бичүүлэх, гэмт хэргийн тодорхой үйлдлүүдийг хүлээлгэхээр дарамталдаг талаар иргэд их гомдол гаргадаг.

2.1.3. Зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар сэжигтэн, яллагдагчийг хорьж саатуулсныхаа дараа ар гэрийнхний эргэлт уулзалтыг хориглож, хувцас солих, ариун цэврийн хэрэглээний зүйлийг оруулахгүй байх, тэр ч байтугай өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхийг нь хязгаарлах зэргээр хэрэг хүлээлгэх, мэдүүлэг өгүүлэхэд чиглэсэн, хоригдогсдын эрүүл мэнд, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхүйц дарамтлалын аргыг хэрэглэх нь ердийн үзэгдэл болсон байна.

Хэрэгт холбогдсон “О”-ийн хэргийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасаг шалгахдаа 7 сарын турш хувцсыг нь нэг ч удаа солиулаагүй, Улсын Ерөнхий Прокурорын газар хүртэл заргалдаж байж ганцхан удаа эргэлт оруулсан /Өмгөөлөгчийн ХЭҮК дээр ирж ярьсан ярианаас/.

2.1.4. Цагдан хорих байруудад эрүүгийн төлөөлөгчдийн зүгээс “гүйцэтгэх ажил” нэрийн дор зарим хоригдогсдын өрөө камерыг зориуд сонгож оруулах, камер хэсүүлэн нэгийг нь нөгөөгөөр нь зодуулж дарамтлуулж, хэрэг хүлээлгэх үйл ажиллагаа явуулж буй нь эрүү шүүлтийн нэг илрэл юм. Үүнээс болж хорих байрны захиргаа, эрүүгийн төлөөлөгч, байцаагч нарын хооронд маргаан зөрчил гардаг тухай зарим хорих газрын ажилтнууд тодорхой баримт түшин ярьж байна. Хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүсээс ч энэ байдлыг батлан ярьж байна.

- Төв аймгийн Дэлгэрхаан сумын иргэн “Д”-гийн ХЭҮК-т ирүүлсэн өргөдлийг шалгахад дараах зүйл тогтоогдсон: “Д”-гийн хүү “Б”-г цагдаагийн байгууллага 2005 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хэрэгт холбогдуулан баривчилж, Төв аймгийн цагдан хорих төвийн 8 дугаар камерт хорьж, гурав хоносны дараа эрүүгийн төлөөлөгч өөр нэгэн хүнийг тус камерт сольж оруулснаас хойш “Б”-г толгой түрүүгүй нүдэж, доош нь харуулж байгаад дээрээс нь дэвсэх, өшиглөх зэргээр тамлаж, хэргээ хүлээхийг шаардаж, ес хоноод гарахад бүх бие нь хөх няц болж, гэдэс нь хавдаж, амьсгаадаж явж чадахгүй болсон байсан ба эмнэлэгт үзүүлэхэд “элэг задралттай эмчилгээгүй” гэсэн онош тавигдсан учраас гаргаж гэртээ байж байгаад нас барсан байв. Аймгийн прокурорын газартай хамтран шалгахад, талийгаач “Б”-гийн хоригдож байсан камерт зориудаар оруулсан “Э” гэгч энэ талаар хүлээж, эрүүгийн төлөөлөгч “М” намайг дуудаж “чиний орох камерт хүн амины хэрэг хийсэн хүн байгаа, хэргээ хүлээхгүй байгаа юм, чамаас хүн амины хэрэг гарч байсан, чи зодож байгаад хэргийг нь хүлээлгэ, би чиний хэргийг цайруулна” гэсэн, би “чадахгүй” гэхэд “чамайг нутгийн чинь шоронд миаруулж өгнө шүү, чи төлөөлөгчтэй гайгүй байвал зүгээр шүү” гэж дарамталсан гэж мэдүүлж байсан. Цагдан хорих байранд хөтлөгддөг бүртгэл тэмдэглэлтэй танилцахад “Э” гэгчтэй эрүүгийн төлөөлөгч “М” биечлэн уулзсаны дараа түүнийг 18 дугаар камераас хохирогч “Б”-гийн хоригдож байсан 8 дугаар камерт шилжүүлж

оруулсан байх ба хорих байрны ажилтнууд ч үүнийг баталж байв. Энэ гомдлыг УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах албанд харьяаллын дагуу шилжүүлж шалгуулсан боловч бусдад даалгавар өгч эрүү шүүлтийг зохион байгуулсан “М” нь эрүүгийн хариуцлагад татагдаагүй өнгөрсөн болно /ХЭҮК-ын 2005 оны архивын 75-д бүртгэгдсэн өргөдлийн шалгалтын материалаас/.

- Иргэн “Б”-г байгууллагынхаа 10 сая төгрөгийг авч завшсан хэрэгт сэжиглэн цагдаагийн ажилтнууд Ганц худагт хорьсон ба гурван давхрын 41 дүгээр камераас зориудаар нэгдүгээр давхрын 18 дугаарын камерт шилжүүлэн хорьж, энэ үеэс эхлэн тэнд хоригдож байсан нэг залуу “хэргээ хүлээ, авсан 10 сая төгрөгөө хаана нуусан, хэнтэй хуйвалдсан, авгайг чинь, 18 нас хүрсэн хүүхдийг чинь авчирч хорино” гэж байнга дарамталж, 2-3 хоног бие засуулахгүй, толгой тархи руу нь сохиж, үснээс нь туг тугаар зулгааж, унтуулдаггүй байсан тухай баримттай, нотолгоотой зүйлийг Комисс тогтоосон. “Б”-гийн холбогдож буй хэргийн талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас өөр хэн ч мэдэх ёсгүй зүйлийг шилжиж ирсэн шинэ камерийн хүн сайн мэдэхээр барахгүй “чи хэргээ хүлээ” гэж дарамталж, зодож тамалж байгаа явдал нь хэргийг шалгаж буй ажилтан тухайн хүнтэй холбоотой бөгөөд “тусгай даалгавар” өгснийг нотлох ба тэр залуугийн толгойны оройн хэсгийн үс нь зулгаагдаж унасан байв. Цагдан хорих байруудад шалгалт хийж байх явцад ч иймэрхүү төрлийн гомдол мэдээллийг цөөнгүй хүн гаргаж байв. Энэ бүхнээс дүгнэлт хийж үзвэл гэмт хэрэгт холбогдогсдыг нэгийг нь нөгөөгөөр нь дарамтлуулж хэрэг хүлээлгэдэг, мэдээлэл авдаг хууль бус арга барил байсаар байна. Түүнчлэн зарим цагдан хорих газруудад хорих ангиудаас хоригдлуудыг зориуд авчирч хорьж, бусдыг дарамтлуулах, хэрэг хүлээлгэх үйл ажиллагаа явуулдаг тухай албаны хүмүүсийн мэдээлэл анхаарал татах асуудал мөн.

Манай улсын бүх баривчлах, цагдан хорих байруудад цагдаагийн байгууллагын эрүүгийн төлөөлөгчид үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдэнтэй холбоотой дээрх хэрэг, зөрчил ихээхэн яригддаг боловч эдгээрийг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ авагдаагүй, хариуцлагын тогтолцоо байхгүй байгаагаас тэд дураараа авирлаж байна. Эрүүгийн эрэн сурвалжлах, хэрэг илрүүлэх болон байцаан шийтгэх ажиллагаанд, тэр тусмаа гүйцэтгэх ажилд онц хүнд хэрэгт холбогдогчид, архаг гэмт хэрэгтнүүдийг ашиглаж байгаа нь туйлын хор аюултай буруу арга юм. Баривчлах, цагдан хорих байр, хорих ангиудад явагдаж буй гүйцэтгэх ажилд хөндлөнгийн хяналт тавигдахгүй байгаагаас энэ үйл ажиллагааны явцад хүний эрх ихээр зөрчигдөж байна. Тагнуулын болон гүйцэтгэх ажлын тухай хуулиар ямар байгууллага, албан тушаалтан ямар төрлийн гүйцэтгэх ажил явуулахыг нарийвчлан тогтоож, хэн яаж зөвшөөрөл өгөх, хяналт тавихыг тодорхой болгох шаардлагатай байна.

2.1.5. Хэрэгт холбогдон мөрдөгдөж буй хүмүүст тогтоогдсон үйлдэл дээр нь өөр хэрэг нэмж хүлээхийг тулган шаардаж, дарамталдаг гэсэн гомдол нилээд гарч байна. Иймэрхүү төрлийн гомдол ихэвчлэн хулгай, дээрэм, хүн амины хэрэгт холбогдсон хүмүүс гаргаж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

- Дархан-Уул аймгийн цагдан хорих байранд хоригдож байсан /2005 оны 5 дугаар сард/ “О” гэгч залуу “би гурван адуу хулгайлж, үйлдсэн хэргээ хүлээн мэдүүлсээр байтал байцаагч 3 үхэр 26 адууны хэрэг нэмж хүлээхийг тулган шаардаж шалны модоор хөл, гаранд цохиж, чих рүү алгадаж, чихний хэнгэрэг цоолсон” хэмээн гомдол гаргасны дагуу түүнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт үзүүлж дүгнэлт гаргуулахад үнэхээр чихнийх нь хэнгэрэг шинээр цоорч эдгэрч байгаа болох нь тогтоогдож байв /Дархан-Уул аймагт хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай илтгэлээс/.

Хэрэг үйлдсэн болох нь нотлогдсон хүмүүст ямар ч аргаар хамаагүй өөр бусад эзэнгүй хэрэг нэмж үүрүүлж, олон тооны хэрэг, үйлдэл илрүүлсэн, мөрдсөн болох гэдэг буруу сонирхол бий болоход хуулийн байгууллагын, ялангуяа цагдаагийн байгууллагын ажилтнуудын ажлыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу үр дүнгийн гэрээгээр дүгнэж, цалин хөлсийг олгож байгаа нь нөлөөлдөг байж болзошгүй. Цагдаагийн байгууллагад мөрдөгдөж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгчийн ажил дүгнэх үзүүлэлт ийм дүгнэлтэнд хүргэсэн.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагчийн 2005 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний зарим үзүүлэлтүүдийг сонирхвол:

- **Хэргийн шийдвэрлэлт**

Хэргийн шийдвэрлэлтээр үндсэн цалингийн 45 хувийг авах ба:

А. Сард 4 хэрэг шийдвэрлэсэн тохиолдолд цалингийн 20 хувийг авна. Шийдээгүй хэрэг тутамд 5 хувь хасуулах ба илүү шийдсэн бол нэмэгдэл бүтээгдэхүүний урамшуулалт авна.

Б. Шийдсэн 4 хэргээ хуулийн хугацаанд шийдсэн бол цалингийн 5 хувь

В. 4 хэргээ гологдолгүй шийдсэн тохиолдолд цалингийн 5 хувь ...

- **Хэргийн илрүүлэлт**

Илрүүлсэн далд үйлдэлтэй хэрэгт цалингийн 20 хувийг олгох ба эзэнгүйгээс түдгэлзүүлсэн далд үйлдэлтэй хэргийг илрүүлэхэд

- Онц хүнд 1 хэрэг эсвэл

- Хүнд 2 хэрэг эсвэл

- Хүндэвтэр 3 хэрэг эсвэл
- Үйлдэл 20
- Далд үйлдэлтэй хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх буюу мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн бол
 - Онц хүнд 1 хэрэг эсвэл
 - Хүнд 2 хэрэг эсвэл
 - Хүндэвтэр 3 хэрэг эсвэл
 - Үйлдэл 20

Мөрдөн байцаагчийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дээрх үзүүлэлтээс харахад аль болох олон хэрэг, үйлдэл илрүүлж, шийдвэрлэж байхыг гол үзүүлэлт болгож цалинг олгохоор тогтоосон байна. Тухайлбал, нэг мөрдөн байцаагч сард 4 хэрэг шийдвэрлэж шалгаж барагдуулбал цалингийн 45 хувиа авах ба цалингийн 40 хувиа тогтоосон тооны түдгэлзүүлсэн далд үйлдэлтэй хэрэг, үйлдлүүдийг илрүүлж байж авахаар тусгагдсан байна. Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар нэгэн аргаар олон хэрэг үйлдлийг илрүүлж байж цалин хөлсөө бүрэн авах хэрэгтэй болж байна.

Гэтэл хэрэг илрүүлэх, яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэх, оргодлыг баривчлах, эрэн сурвалжлагдаж буй этгээдийг илрүүлэх гэх мэт ажлууд нь тухайн ажилтны хүсэл зоригоос шууд хамаарах ажил биш гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой. Энэхүү хүнд бэрх ажилд удирдлага зохион байгуулалт, санхүү хөрөнгө мөнгө, техник технологи, тоног төхөөрөмжийн хангамж гэх мэт олон хүчин зүйл нөлөөлнө. Энэ бүхнийг бодолцохгүйгээр ийм маягаар ажил дүгнэж, аль болох олон хэрэг үйлдэл илрүүлэхийг шахаж, цалин хөлстэй нь хатуу тооцох нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж, эцэстээ хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг зөрчихөд хүргэж буйг онцлон тэмдэглэж, холбогдох байгууллагын анхаарлыг хандуулах нь зүйтэй.

2.1.6. Өөр газар шилжүүлэн хорих явдал нь эрүү шүүлт, хэрсгий хүнлэг бус харьцааны нэг илрэл болж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 180 дугаар зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагааг хэрэг гарсан газар нь явуулна хэмээн заасан. Хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг баривчлах, цагдан хорих, энэ шийдвэрийг хэрэгжүүлэх нь мөрдөн байцаах ажиллагааны нэг хэсэг мөн тул цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шийдвэр гаргасан шүүхийн харьяалагдах газар биелүүлэх учиртай. Гэтэл хэрэгт холбогдогчийг мөрдөн байцаалт явагдаж буй газраас өөр орон нутагт, олон зуун километрийн алсад аваачиж хорьж, сэтгэл санааны дарамт учруулах, эрхийг нь хохироох явдал сүүлийн жилүүдэд нилээд нийтлэг ажиглагдаж байна. Энэ тухай ХЭҮК-т өргөдөл, гомдол олон удаа ирж, Комиссоос энэ

зөрчлийг таслан зогсоох талаар холбогдох байгууллагуудад шаардлага зөвлөмж гаргаж байгаа боловч өөрчлөлт гарахгүй байна. Өөр газар шилжүүлэн хорьдог зөрчил дутагдал нийслэл болон Төв, Увс, Дархан-Уул, Баян-Өлгий аймагт харьцангуй их гарч байгаа нь хяналт шалгалтын ажлын явцад харагдаж байна. ХЭҮК-оос хийсэн шалгалтаар Ганц худгийн цагдан хорих төвд 2004 онд өөр аймаг хотоос 58 сэжигтэн, яллагдагчийг, уг цагдан хорих төвөөс өөр аймгийн цагдан хорих төв рүү 102 сэжигтэн яллагдагчийг, 2005 оны эхний хагас жилд 19 сэжигтэн, яллагдагчийг, өөр аймгийн цагдан хорих төвүүдэд, 59 сэжигтэн, яллагдагчийг өөр аймаг хотоос шилжүүлэн авчирч тус тус хорьсон байна. Өөр аймаг хотоос 2004 онд шилжүүлэн авчирч хорьсон хүмүүсийн 10 нь хүн амины хэрэгт холбогдон мөрдөгдөж байсан хүмүүс байжээ.

2005 онд шилжүүлэн хорьсон тохиолдол Дархан-Уул аймагт 15 удаа, Төв аймагт 11 удаа, Увс аймагт 7 удаа тус тус гарсан байна.

- Увс аймгийн иргэн “Б”-г хулгайн хэрэгт холбогдуулан шалгахдаа эхлээд Увс аймгаас Төв аймгийн цагдан хорих байранд авчирч 5-6 камер дамжуулан хорьж дарамтлуулж, дараа нь Баян-Өлгий аймагт аваачиж хорьж байжээ /ХЭҮК-ын архиваас, 2004 он/.

Ер нь олны анхаарал татсан, дуулиан шуугиан ихтэй хэргүүдийн холбогдогчдыг ихэвчлэн өөр газар шилжүүлэн хорих нь нэг ёсны хэвшил болоод байна. Хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүсийг мөрдөн байцаалт явагдаж буй газраас өөр газар аваачиж хорих нь сэтгэл зүйн дарамт учруулаад зогсохгүй түүний олон эрхийг зөрчихөд хүргэж байна. Өөр газар аваачиж хорьсноос шалтгаалан гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсдөөсөө эргэлт уулзалт авах, өмгөөлөгчтэйгээ хүссэн цагтаа уулзах, зөвлөгөө авах, тухайн хэрэгт хяналт тавьж буй прокурорт санал гомдлоо гаргах эрх нь хязгаарлагдаж, хүндрэл учирч байна. Ийм нөхцөлд тухайн этгээд эрүү шүүлт болон хэргийг хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалд өртөх, эрх нь зөрчигдөх илүү магадлалтай болдог. Хэрэгт холбогдон хоригдож буй этгээд гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд, өөрийн сонгосон өмгөөлөгчтэйгээ тогтмол уулзаж байх нь эрүү шүүлт, аливаа хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гомдлоо цаг тухайд нь гаргах боломжийг бий болгодог. Үүний зэрэгцээгээр хэрэг зөрчилд холбогдсон иргэдийн дийлэнхи олонхи нь эрхэлсэн тодорхой ажилгүй, хөрөнгө орлогоор хомс иргэд байдаг учир хол газар аваачиж хорих нь хоригдогчийн төдийгүй түүний ар гэрийнхэн, төрөл төрөгсөд болон өмгөөлөгчид илүү их хөрөнгө, мөнгө, цаг хугацаа, зардал чирэгдэл учруулж, үндсэндээ эргэлт уулзалтыг хийх боломжгүй болгодог.

2.1.7. Бага насны хүүхэдтэй эхчүүдийг баривчлах, хорихоор далайлган сүрдүүлж мэдүүлэг авах, улмаар цагдан хорьж сэтгэл зүйн эрүү шүүлт тулгаж, хэргийг, хүнлэг бус харьцах явдал байна. Ялангуяа,

хулгай, залилангийн гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүд энэ талаар өргөдөл гомдол байнга гаргадаг.

- Сэлэнгэ аймгийн Хөтөл хорооны цагдаагийн ажилтнууд хулгайн хэрэгт холбогдуулан Улаанбаатар хотоос 02-13 насны гурван хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэйг баривчилж, Сэлэнгэ аймаг руу авч явсан ба гурван хүүхэд нь ямар ч асаргаа, хамгаалалтгүй үлдсэн байсан талаар иргэдийн ирүүлсэн мэдээллийг шалгаж, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн хэлтсийн удирдлагатай ярьж, тэр эмэгтэйг суллуулсан болно.
- Өөрсдөө хэрэгт холбогдон олон сар, жилээр урьдчилан хорих байранд хоригдож, хүүхэд нь хаана, яаж амь зууж байгаа нь тодорхойгүй байгаа талаар 2005 оны 11 дүгээр сард Ганц худгийн урьдчилан хорих төвд ажиллаж байсан ХЗДХ-ийн Дэд сайд тэргүүтэй шалгалтын хэсэг /уг шалгалтын хэсэгт прокурор, өмгөөлөх, цагдаагийн байгууллагын ажилтнууд, хүний эрхийн төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд оролцсон/-т хэд хэдэн эмэгтэй гомдол гаргаж байсан. Бага насны болон хөхүүл хүүхэдтэй эхийг гэмт хэрэгт сэжиглэн баривчилж хорих нь хэрцгий, хүнлэг бус арга ажиллагааны илрэл яах аргагүй мөн бөгөөд удаан хугацаагаар хорьж байгаа нь эрүү шүүлт юм. Ер нь гэмт хэргийг илрүүлж, буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг зорилт мөн боловч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, сурлага хүмүүжил нь төрийн хамгаалалтын гадна үлдэх ёсгүй. Хүүхдийн эрх ашиг, амь нас, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх арга барилаар мөрдөн байцаалтыг явуулж байгааг юугаар ч зөвтгөх боломжгүй.

2.1.8. Хүнийг гэмт хэрэгт сэжиглэн баривчлах, цагдан хорих арга хэмжээ нь цаг ямагт хүний эрхийн асуудлыг хөндөж байдаг төдийгүй, эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцах эрсдэлийг дагуулж байдаг. Хорих таслан сэргийлэх арга хэмжээнд тавигддаг олон улсын шалгуур хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжид тусгах, энэхүү эмзэг, эрсдэл ихтэй арга хэмжээг аль болох оновчтой, хүний халдашгүй байх эрхийг баталгаатай хангах зорилгод нийцүүлэн хэрэглэх нь туйлын хариуцлагатай үйл ажиллагаа юм. Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ нь яригдаж буй эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар харьцахыг хориглох, түүнтэй тэмцэх сэдвийн хүрээнд дараахи хоёр чиглэлээр анхаарал татаж байна.

2.1.8.1. Баривчлах, цагдан хорих үндэслэл.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд /2002 он/ баривчлах, цагдан хорих үндэслэл хэт өргөн хүрээнд, хэнийг ч, ямар ч хэрэгт сэжиглэн баривчлах, цагдан хорих боломж нөхцөл нээлттэй байгааг хүний эрхийг хамгаалагчид, судлаачид шүүмжилж байна.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх Үндсэн хуулийн эрхтэй ЭБШХ-д тусгагдсан сэжигтэн, яллагдагчийг баривчлах, саатуулах, цагдан хорих

үндэслэл, журам нь хэрхэн уялдаж, гэм буруугүй хүн хууль бус баривчилгаа, хоригдолтоос эгнэгт ангид байх баталгаа хэр найдвартай байж чадах нь хүний эрхийн талаасаа маш чухал үзүүлэлт юм. Хуулийн Наймдугаар бүлэг бүхэлдээ сэжигтнийг баривчлах асуудлыг зохицуулж байна. Сэжигтнийг гурван тохиолдолд нэгдүгээрт, сэжигтэн оргон зугатахыг завдсан, хоёрдугаарт, хүнд гэмт хэрэгт, гуравдугаарт, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэж буй бол баривчлахаар /хуулийн 58 дугаар зүйл/ заасан. Үүний оргон зугатахыг завдсан сэжигтнийг болон онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэгсдийг баривчлахыг зүй ёсны гэж үзэж болох боловч “хүнд” гэмт хэрэгт холбогдогсдыг заавал баривчилж байхаар хуульчилсны үндэслэлийг зөвтгөхөд төвөгтэй юм. Эрүүгийн хуулиас үзэхэд нийтдээ 352 үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцсон байх бөгөөд үүнээс 65 үйлдлийг хөнгөн, 185 үйлдлийг хүндэвтэр, 68 үйлдлийг хүнд, 34 үйлдлийг онц хүнд гэмт хэрэгт тооцжээ. ЭБШХ-ийн дээрх заалтаас үзэхэд нийтдээ /хүнд, онц хүнд/ 102 үйлдэлд хардагдаж сэрдэгдсэн хүнийг зөвхөн зүйл ангийг нь хараад шууд баривчлах үндэслэл нээлттэй байна. ЭБШХ-ийн 58.1 нь императив шинжтэй норм. Учир нь зөвхөн “баривчилна” гэж таслан сэргийлэх арга хэмжээг сонгох хувилбаргүйгээр тогтоожээ. Шууд баривчлагдах “хүнд” гэмт хэрэгт: татварын хэрэг, гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах, газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих /болгоомжгүй хэрэг/ гэх мэтийн мөрдөн байцаалтын явцад шүүхэд шилжих эсэх нь шийдвэрлэгддэг үйлдлүүд зонхилж байна. Тэгэхээр ийм хэргүүдэд сэрдэгдсэн хүмүүсийг эхнээс нь шууд л баривчилж хорихоор хуульчилсан нь хүний халдашгүй эрхийг ноцтой зөрчихөд хүргэж буй заалт юм.

ЭБШХ-ийн хүний эрхийн эрсдэлийг бий болгож буй энэхүү заалтуудын талаар ХЭҮК-ын өмнөх илтгэлүүдэд тодорхой дурдаж, санал дэвшүүлж байсан /Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, 2002 он, 14-15 дугаар хуудас, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2003 он, 49-50 дугаар хуудас/.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зүгээс байцаан шийтгэх хуулийн энэхүү заалтыг ашиглан сэжигтэн, яллагдагчийг хорьж, цагдахаар далайлган мэдүүлэг авах, дарамтлах боломж нээлттэй байдаг.

Түүнээс гадна баривчлах үйл ажиллагаа үнэн хэрэгтээ хуулийг зөрчин шүүхийн хяналт, зөвшөөрлийн гадна явагдаж байгаа нь далайлган сүрдүүлэлт, дарамтлалын нэг гол хэрэгсэл болж байгаа нь нууц биш болжээ. ХЭҮК-оос ШШГЕГ-ын харьяа 0461 дүгээр анги /Ганц худаг/-ийн Баривчлах байранд шалгалт хийхэд 2005 оны эхний 6 сарын байдлаар нийтдээ 978 хүнийг хорьсноос 93.9 хувийг /919 хүн/ нь хойшлуулшгүй тохиолдол /ЭБШХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.5-д хойшлуулшгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж, 24 цагийн

дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлнэ гэж заасан/ гэсэн үндэслэлээр, үүнээсээ дөнгөж 6.1 хувь /59 хүн/-ийг шүүхээр тогтоолыг батлуулж, баривчилсан байв. Энэ нь хуулийн агуулга, заалтыг хуулийн ажилтнууд хэрхэн дураараа зөрчиж буйн үзүүлэлт юм.

2.1.8.2. Урьдчилан хорих хугацаа.

Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенци болон эрүү шүүлтийн талаархи Тусгай илтгэгч, шинжээчдийн илтгэл дүгнэлтэд шүүхийн өмнөх шатанд удаан хугацаагаар хорихыг хориглож, тийм тогтолцоо, практикийг эрүү шүүлт, хэрцгий хүнлэг бус харьцааны нэг илрэл гэж үздэг. 2005 онд Монгол улсад айлчилсан НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх асуудлыг судлах Тусгай илтгэгч Манфрэд Новакийн илтгэлд цагдан хорих дээд хугацаа хэт өндөр байгаа, практик дээр цагдан хорих явдал нь ердийн жишиг, журам болсныг буруушааж, энэ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын холбогдох заалтуудтай зөрчилдөж байгааг тэмдэглэсэн /Тусгай Илтгэгчийн илтгэлээс/.

Монгол улсын ЭБШХ-д зааснаар /69 дүгээр зүйл/ хорьж мөрдөх хугацаа 24 сар, зарим онц хүнд хэрэгт холбогдогчдын хувьд 30 сар байна. Насанд хүрээгүй хүнийг хорьж мөрдөх дээд хугацаа нь 18 сар байна /ЭБШХ-ийн 366 дугаар зүйл/.

Гэм буруутай эсэх нь хожим шүүх дээр хэлэлцэгдэх, гэмт хэрэгт зөвхөн сэжиглэгдэн буруутгагдаж байгаа хүнийг ийм удаан хугацаагаар хүнд хатуу нөхцөлд хорих нь хоригдогсдын амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд ноцтой хор хөнөөл учруулж, улмаар эрүү шүүлт, хэрцгий арга ажиллагааны нэг хэлбэр болж байгааг тус Комиссын өмнөх илтгэлүүд, шаардлага, зөвлөмжүүдэд нэг бус удаа тэмдэглэж байсан.

Хуульд ийм удаан хугацаагаар /24-30 сар/ хорих боломж олгосон явдал нь үнэн хэрэгтэй хүнийг залхаан цээрлүүлэх, хэрэг тулгаж хүлээлгэхийг өөгшүүлж, дэмжсэнтэй агаар нэг юм. Практик дээр хуулийн байгууллагын ажилтнууд хуульд заасан энэхүү 24 ба 30 сарын урт хугацааг ч “сунгаж”, хэтрүүлэн хорьдог ба түүндээ “тайлбартай” болсон байна.

ШШГЕГ-ын харьяа 0461 дүгээр ангийн /Ганц худаг/ 2005 оны 11 дүгээр сарын мэдээгээр ЭБШХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.3-д заасан 24 сарын хугацаанаас 10-30 хоногоор хэтрүүлэн хорьж байгаа дөрвөн хүн байв. Яагаад хуульд заасан 24 сараас хэтрүүлэн хорьж буйг лавлахад эдгээр хүмүүсийн хэргүүд нь ихэвчлэн шүүхэд шилжиж, нэмэлт мөрдөн байцаалтад буцаж байсан бөгөөд шүүх дээр байсан хугацаан нь 24 сарын хугацаанд оруулж тооцохгүй гэж прокуророос мэдэгдсэн болно гэж хариулж байлаа. Шүүхэд шилжсэн үеэс “шүүгдэгч” болдог учраас ЭБШХ-д заасан /69 дүгээр зүйл/ “яллагдагчийг” хорьж мөрдөх хугацаанд шүүх дээр хоригдож байсныг оруулахгүй гэсэн “тайлбарыг” хуулийн

байгууллагын ажилтнууд хийж, өөрсдийн хууль бус арга ажиллагааг зөвтгөж байна. Ингэж удаан хугацаагаар хорих үндэслэл нь мөрдөн байцаалтын зайлшгүй, гарцаагүй шалтгаан, үндэслэлтэй байх ёстой атал практик дээр үнэн хэрэгтэй хорих зөвшөөрлийг сунгуулсан хугацаандаа мөрдөн шалгалтын ямар ч арга ажиллагаа явуулалгүйгээр, хоригдож байгаа хүнтэйгээ ч уулзаж, байцаалт авалгүйгээр хугацааг дуусгаж байгаад хоригдож буй хүмүүс ихээр гомдоллож байдаг.

Ганц худаг, бусад 7 аймагт хийсэн судалгаагаар тэнд хоригдож байсан 1338 хүний 17.1 хувь нь 6 сараас 1 жилийн хугацаагаар, 109 хүн буюу 8.1 хувь нь 1-2 жилийн хугацаагаар, 17 хүн буюу 1.2 хувь нь 2 жилээс дээш хугацаагаар хоригдож байв /ХЭҮК-ийн судалгаанаас/.

Хүнд хатуу нөхцөлд удаан хоригдсоноос жингээ алдаж, тураалд орох, эрүүл мэнд нь муудах, халдварт өвчин, сүрьеэ тусах, улмаар амь насаа алдах явдал ч гарсаар байгаа боловч энэ нь байж болох зүйл мэтээр хандах хандлага тогтсон байна.

Өнгөрсөн оны 7 дугаар сард Ганц худгийн цагдан хорих төвд шалгалт хийж үзэхэд 43 хоригдогч жингээ алдаж, тураалд орсон /зарим нь бүр 15 кг-аар жингээ алдсан/, 8 хоригдол хоригдож байх хугацаандаа сүрьеэ өвчин туссан байна.

- Өнгөрсөн жил хүн амины хэрэгт сэжиглэгдэн Ганц худагт хоёр жил шахам хугацаагаар хоригдон мөрдөгдөж байсан 30 гаруй настай “Б” тураалд орж, амь насаа алддагийн даваан дээр түүнийг Баянзүрх дүүргийн “Энэрэл” хэмээх халамжийн эмнэлэгт аваачиж орхисон байна. Гэтэл тэрээр сүрьеэ тусч тэр нь эцсийн шатандаа ортол хүндэрсэн болох нь тогтоогдож, сүрьеэгийн эмнэлэгт шилжсэн боловч эмчилгээ авалгүй нас барж байсан.

2.1.9. Урьдчилан хорих байранд хоригдогсдыг удаан хугацаагаар гавлах, дөнгөлөх явдал гарч байгааг хэрцгий, хүнлэг бус арга ажиллагааны нэг илрэл гэж үзэж байна. “Суга, гуяыг чинь ногооруулна” гэсэн заналхийллийг зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гаргадаг байна.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулинд хоригдсон этгээд хорих байрны хамгаалалтын болон дэг журам сахиулах үүрэг бүхий ажилтан бусад хүмүүс рүү хүч хэрэглэн довтолсон, хорих байрны дотоод журмыг бүлэглэн зөрчсөн, олныг хамарсан үймээн гаргасан, хүн, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл барьцаалсан, хоригдсон этгээд оргох, өөртөө гэмтэл учруулхыг завдсан тохиолдолд хорих байрны ажилтан тусгай хэрэгслэл хэрэглэж болохоор заасан байна. Энэ хуульд олон төрлийн тусгай хэрэгслэлийг нэрлэн заасан боловч хорих байруудад нийтлэг хэрэглэгддэг тусгай хэрэгслэл нь

бороохой болон гав байна. Гэвч хорих байрны ажилтнуудаас онцын шаардлагагүй тохиолдолд тусгай хэрэгслэл хэрэглэхийг урьтал болгох, гавыг хэт удаан хугацаагаар хэрэглэх байдал ажиглагдаж байна. Тухайлбал, хувцсаа тайлсангүй, тавьсан шаардлага биелүүлсэнгүй, хэгжүүн зан гаргалаа хэмээн бороохойдох, биеийн хориотой газар нь бороохойдох болон хөл, гарт нь зэрэг гав гинж хэрэглэх, гав гинжийг хэт удаан хугацаагаар хэрэглэх зэрэг хэрцгий хандах байдал хорих байрны үйл ажиллагаанд байсаар байна. Гав гинж болон тусгай хэрэгслэл хэрэглэж байгаа байдалд тавих прокурорын болон захиргааны хяналтыг сайжруулах, тусгай хэрэгслэл хэрэглэсэн тухай дэлгэрэнгүй тэмдэглэлийг нь цаг тухайд нь хөтөлж түүнийг хянан үзэж зөв бурууг нь үнэлж дүгнэдэг байх шаардлагатай байна.

2.2. Хөдөө орон нутаг, сумдад хэсгийн байцаагч, хэв журам сахиулах цагдаа гэсэн цагдаагийн албан хаагч ажиллаж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах, урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэх үйл ажиллагааг явуулж байна. Энэ үйл ажиллагааны явцад иргэдтэй хэрцгий, хүнлэг бус харьцах, хүч хэрэглэх зэрэг хүний эрхийн зөрчил гарч байгаа нь хяналт шалгалтын ажлын явцад илэрч байна. Ийм нөхцөл байдал Увс аймагт хийсэн шалгалтын явцад анхаарал татсан. Энэ аймагт хэсгийн байцаагч, цагдаа нараас орон нутгийн иргэдтэй харгис, хэрцгий хандаж, зодож цохьдог тухай гомдол аймгийн хууль хяналтын болон прокурорын байгууллагад 12 удаа гарч байсан байна.

- Увс аймгийн Наранбулаг сумын цагдаа “Э” гэгчийн талаар тус сумын 60 орчим иргэний гарын үсэгтэй өргөдөл прокурор, цагдаагийн байгууллагад ирсэн байв. Энэхүү өргөдөл: цагдаа “Э” нь бусдыг архи уулаа гэж цастай өвлийн хүйтэнд шонгийн модноос гавалж зодсон, сумын Засаг даргын Тамгын газрын конторын үүдэнд зогсоож хөлийн тавгийг нь хөлдөөсөн, архи уусан гэж 5 хоног ажил хийлгэж гавалж байгаад зодож ухаан алдуулах зэргээр дэндүү харгис хэрцгий хандаж байгаа тухай бичсэн байна. Эдгээр 60 орчим иргэдийн өргөдөл, гомдлыг олигтой лавшруулж шалгахгүй “нотлогдоогүй” гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгосны дараа төлөөлөгч “Э” нь бүүр гаарч эцэст нь шүүхээр шийтгүүлсэн байна.
- Увс аймгийн Өмнөговь сумын хэсгийн байцаагч “Б” иргэн “Т”-г халамцуу явлаа гэж өрөөндөө аваачиж, зодож цохин, эрүүг нь хугалж, шүдийг нь унагасан байна.
- Архангай аймгийн Эрдэнэмандал сумын хэсгийн байцаагч “Б” иргэн “Г”-г хэрэгт сэжиглэн, албадан саатуулж, сумын захиргааны конторын паарнаас гавалж, зодсоны улмаас тархийг нь хүнд гэмтээж амь насыг нь хохироосон байна. Сум орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудаас иймэрхүү байдлаар ард иргэдтэй харьцаж байгаа жишээ

олныг дурдаж болох байна. Энэ бол төрийн албан үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдаас иргэдтэй харгис хэрцгийг балмад харьцаж байгаа хүний эрхийн хамгийн бүдүүлэг зөрчил, гэмт хэрэг мөн. Ийм ноцтой зөрчил гарахад тухайн ажилтны сахилга хариуцлагаас гадна олон хүчин зүйл нөлөөлж байна.

Засаг захиргааны анхан шатны нэгж болох сумдад хүний эрхийг хангах, хамгаалах, хяналт тавих ямар ч тогтолцоо өнөөдөр байхгүй. Ялангуяа, сумдад төрийн болон цагдаагийн байгууллагын албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий шүүх, прокурорын байгууллага байхгүй байгаа нь ийм нөхцөл байдал гарахад шууд нөлөөлдөг. Иргэд эрхээ зөрчигдсөн тухай бүр нь өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх ямар ч боломж алга байна.

2.3. Иргэдийн амь нас, эрүүл мэндийг нь хамгаалах, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос нь урьдчилан сэргийлэх зорилгоор Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль гарч мөрдөгдөөд багагүй хугацаа өнгөрсөн. ХЭҮК байгуулагдсан эхний жилдээ эрүүлжүүлэх байруудад үзлэг хийж, эдгээр байруудын ахуй нөхцөл, эрүүлжүүлэх үйл ажиллагаанд нь дүгнэлт хийж зарим байрыг хаах тухай шаардлага тавьж, 2002 оны ХЭҮК-ын илтгэлдээ нэг бүлэг болгон тусгаж, тодорхой саналыг тавьж байсан. Гэвч эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хүний эрхийн үүднээс анхаарал татаж буй зүйл их байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх, эрүүлжүүлэх явцад шаардлагагүй тохиолдолд хүч хэрэглэх, хэрцгийг хүнлэг бус харьцах, бие эрхтэнд нь гэмтэл учруулах, улмаар амь насыг нь хохироох гэмт хэрэг, зөрчил хот хөдөөгүй гарсаар байна.

Иргэдийг эрүүлжүүлэх явцад зүй бус харьцаж, бие эрхтэнд нь гэмтэл учруулсан хүч хэрэглэсэн тухай өргөдөл, гомдол Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд багагүй ирж, ихэнхи нь эрүү үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгох зэргээр дуусгавар болдог. Нийслэлийн болон зургаан дүүргийн прокурорын газрууд дээр мөрдөн байцаах албанд мөрдөгдөн шийдвэрлэгдсэн хэргүүдийг судалж үзэхэд 2005 онд эрүүлжүүлэх байрны ажилтнуудын үйл ажиллагаатай холбоотой 11 хэрэг шалгагдаж, 6 хэрэг нь нотлогдоогүй буюу эвлэрсэн гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгогдож, 5 хэрэгт ялах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжсэн байна.

- 2005 онд Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа Эргүүл хамгаалалтын газрын цагдаа “Г” гэгч иргэн “Б”-г эрүүлжүүлэхээр авч явахдаа хоёр гарыг нь гавлаж, гавтай гаранд нь хөлийг нь углаж, толгой биед нь хэд хэдэн удаа цохиж зодсоны улмаас хохирогч гавал тархины битүү гэмтэл авч бөөрөнд нь цус хурсны улмаас нас барсан байна /Баянзүрх дүүргийн прокурорын газарт хийсэн судалгааны дүнгээс/.

- Хан-Уул дүүргийн эрүүлжүүлэх байрны цагдаа “Б” иргэн “Т”-г эрүүлжүүлэх явцдаа паар мөргүүлэн зодож хөнгөн гэмтэл учруулсан, Чингэлтэй дүүргийн эрүүлжүүлэх байрны цагдаа “Ч” иргэн “Г”-г хувцсаа тайлсангүй гэж “төгцөг минь яаж хувцсаа тайлдгийг үзүүлж өгнө” хэмээн хөл рүү нь өшиглөж, гарыг нь мушгин зодож хүндэвтэр гэмтэл учруулсан, Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны цагдаа “Б” иргэн “Б”-г хоёр чих рүү нь ээлжлэн цохиж чихнийх нь хэнгэргийг хагалсан зэрэг баримтуудыг дурьдаж болох байна. Энэ мэтээр эрүүлжүүлэх байрны ажилтнууд бусадтай хэрцгий, хүнлэг бус харьцах явдал бусад аймгийн эрүүлжүүлэх үйл ажиллагааны явцад ч гарч байна /ХЭҮК-ын 2005 оны шалгалтын материалаас/.

Бусад аймагт ч нэгэн адил эрүүлжүүлэх үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол багагүй гарч байна. Тухайлбал, 2005 онд Орхон аймгийн цагдаагийн газрын эрүүлжүүлэх байрны цагдаа “Д” гэгч эрүүлжигдэж байсан иргэн “И”-г “ам цангаад байна ус ууя” гэхэд нь “ямар даварсан амьтан бэ” гэж зодож, хамарны ясыг нь мурийлгаж, хурууг нь хугалж, нүд рүү нь цохиж хүндэвтэр гэмтэл учруулж, хэрцгий хандсан боловч 100 мянган төгрөг төлж, эвлэрсэн гэдэг үндэслэлээр хэрэг нь хэрэгсэхгүй болгогдож байжээ.

Хуульд өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болтлоо согтсоны улмаас гэр бүлийн буюу бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, хаана байгаа болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасны улмаас хэрэг зөрчилд орж болзошгүй болсон иргэдийг албадан эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлж байхаар заажээ /Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйл/. Гэтэл архи уусан, архи үнэртүүлсэн болгоныг ялгаж салгахгүйгээр эрүүлжүүлэх байранд хүргэж эрүүлжүүлэх шаардлага тавьж, үүнээс шалтгаалан маргаан үүсэж, хүч хэрэглэх, улмаар хэрцгий, хүнлэг бусаар харьцах байдал хүрдэг байна. Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх алба нь архи уусан этгээдийн согтолтын зэрэглэлийг тогтоох, уусан уугаагүйг тогтоох ямар ч багаж техникгүй учраас ихэнхи тохиолдолд амыг нь үнэрлэх, хэлийг нь гаргуулж харах зэргээр бүдүүн тоймоор ханддаг. Дорнод, Увс зэрэг аймгуудад оройн цагаар баар цэнгээний газрын үүд хаалгыг сахиж тэндээс гарч ирсэн үйлчлүүлэгчдийг барьж саатуулж эрүүлжүүлдэг тухай гомдол иргэдээс гарч байсан.

Зарим тохиолдолд айлд унтаж байсан хүнийг хүртэл эрүүлжүүлэхэд аваачих шаардлага тавьж, эрх чөлөөнд нь халдаж, хүний амь нас хохирч байсан байна. Иймээс эрүүлжүүлэх үйлчилгээний өнөөгийн тогтолцоо, арга ажиллагааг зайлшгүй авч үзэх шаардлагатай байна.

2.4. Цаазаар авах ял шийтгүүлсэн ялтнуудтай харьцах, цаазаар авах ялыг гүйцэтгэх, эргэлт уулзалт оруулах, цаазаар авах ялын тухай асуудлаар судалгаа дүгнэлт хийж, энэ талаархи олон улсын зохицуулалтыг судалж, авч үзэх шаардлага тавигдаж байна. Манай улсын тухайд цаазаар авахтай холбоотой ихэнхи асуудлыг төрийн нууцад хамааруулж, бүх мэдээлэл хаалттай байгаагаас элдэв цуу яриа тархах, таамаглах, ялыг гүйцэтгэсэн эсэхэд эргэлзэх явдал байдаг. Энэ асуудлаар НҮБ-ын Эрүүдэн шүүлтийн асуудлаархи Тусгай Илтгэгч зориуд авч үзсэн байна. Тэрээр илтгэлдээ: Монгол улсад цаазаар авах ялыг тойрсон бүх асуудлыг төрийн нууц хэмээн үзэж байгаад сэтгэл зовниж байна. Төрийн удирдах дээд албаны хүмүүст удаа дараа хүсэлт тавьсан боловч энэ асуудлаар мэдээлэл өгөөгүй. Цаазаар авах ял шийтгүүлсэн хүнтэй гэр бүлийг нь нэг удаа уулзахыг зөвшөөрдөг бөгөөд тийм хүмүүс байнгын гав, дөнгөтэйгээр цагдан хоригдож, хангалттай хоол хүнс авдаггүй байна. Цаазаар авах ялыг гүйцэтгэсэн огноо, газрыг мэдэгддэггүй, цогцсыг нь гэр бүлийнхэнд нь оршуулахаар хүлээлгэж өгдөггүйгээс гэр бүлийнхнийг нь тодорхой бус байдалд оруулж, хүнлэг бусаар хандаж байна гэжээ. Цаашдаа цаазаар авах ялын тухай асуудлаар мөрдөгдөж буй хууль, журмыг судлан үзэж олон улсын хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцүүлэх шаардлагатай байна.

Гурав. Баривчлах, урьдчилан хорих байрны нөхцөл эрүү шүүлтэй холбогдох нь

Гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй гэм буруу нь шүүхээр эцэслэн тогтоогдоогүй байгаа хүмүүсийг албадан саатуулах, цагдан хорих байрны нөхцөл, стандарт нь тухайн орны хүний эрхийн байдал, хүний эрхэд хандах хандлагыг илэрхийлэх нэг гол үзүүлэлт болж байдаг. Энэ нь ийм газарт хоригдож байгаа хүмүүс гэм буруутай болох нь эцэслэн тогтоогдоогүй байдаг учраас эцэстээ хүний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчих эрсдэл магадлалыг агуулж байдагтай холбоотой юм.

Хүний эрхийг хамгаалах олон улсын байгууллага, дэлхийн хамтын нийгэмлэгээс ч энэ асуудалд ихээхэн анхаарал тавьсаар ирсэн. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1988 онд Хоригдсон болон цагдан хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд, 1990 онд Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд зэрэг олон баримт бичгийг батлан гаргаж, эдгээрт тэдгээр хүмүүстэй харьцах талаархи улс орнуудын баримтлах зарчим, жишиг хэмжээг тодорхойлж өгсөн.

Монгол улс 1999 онд Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг батлан гаргаж, хорих байрны стандарт, жишгийг тогтоосон ба баривчлах, цагдан хорих байрыг цагдаагийн байгууллагын харьяаллаас гаргаж, Шүүхийн шийдвэр

биелүүлэх байгууллагын харьяалалд шилжүүлсэн нь зарчмын ач холбогдолтой арга хэмжээ болсон.

1999 онд батлагдсан энэхүү хуулиар баривчлах, цагдан хорих байрыг зөвхөн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр байгуулж, хорих байр нь зохих шаардлагыг хангасан байхаар тогтоосон. Энэхүү хуульд: ...хорих өрөө нь төмөр хаалгатай, онгойлгох хязгаарлагчтай, хяналтын шагайвартай, гадна талдаа цоожтой, цонх нь төмөр сараалжтай, агааржуулах салхивчтай, агааржуулах төхөөрөмжтэй, модон шалтай, эсвэл модон наартай, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлтэй байх бөгөөд чийглэг нь 55-60 хувь, өвлийн улиралд 18 градусуас багагүй дулаантай байна /Хуулийн 13 дугаар зүйл/ гэж заасан.

Сүүлийн жилүүдэд цагдан хорих байрны ахуй нөхцөлийн талаар байнга шүүмжлэгдэж, багагүй яригдаж байгаа ч өнгө будгийн шинжтэй өнгөц засвар үйлчилгээ хийгдсэнээс бус хуулинд заасан стандарт, тодорхой шаардлагыг хангах, хөрөнгө оруулалтын дорвитой арга хэмжээ авагдаагүй арав шахам жил өнгөрлөө. Өнөөгийн урьдчилан хорих байр нь жинхэнэ эрүү шүүлт, хүнлэг бус, хэргийг харьцааг нөхцөлдүүлж, хэрэг тулган хүлээлгэх, залхаан цээрлүүлэх, сэтгэл зүйн дарамт шахалт үзүүлэхэд зохицсон, хүний эрхийн зөрчлийн халуун цэг болсоор байна.

2004 онд ХЭҮК, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамтай хамтарч улсын бүх урьдчилан хорих байруудад үзлэг, ХЭҮК өнгөрсөн онд Ганц худаг болон Төв, Дорнод, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Орхон, Дархан-Уул зэрэг аймгуудийн урьдчилан хорих байруудад шалгалт хийж, хорих байрны нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргасан. Энэ дүнгээс харахад хуульд заасан үндсэн шаардлага, стандартыг хангасан нэг ч цагдан хорих байр байхгүй байна. Цагдан хорих байрууд нь гадагш харсан цонхгүй, голдуу бетонон ханатай, төмөр хаалгатай, байгалийн нарны гэрэл тусах, агаарын солилцоо явагдах ямар ч боломжгүй, төмөр хаалга нь дээд хэсгээрээ төмөр сараалжтай, тэр хэсгээр нь гэрэл тусгасан /тэр гэрэл нь мэдээж байнга асдаггүй, шаардлагатай үед асаана, бусад үед харанхуй/, дотроо цэвэр усны хангамжгүй, байнгын агаарын болон гэрлийн дутагдалтай, чийгшил ихтэй байдаг.

Хорих байруудад улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулахад агаарын болон орчны бохирдол, чийглэг нь зөвшөөрөгдөх хэмжээнээс байнга их, ихэнх нь өвлийн цагт маш хүйтэн байдаг байна.

- 2004 онд хийгдсэн үзлэгийн үеэр Ганц худгийн зарим өрөөний агаарт нянгийн шинжилгээ хийж үзэхэд 1 м³ агаарт байх нянгийн тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.5-2 дахин их, Дорноговь аймгийн цагдан хорих байранд зөвшөөрөгдөх хэмжээнээс бүр 3-10 дахин их гарч байсан /Үзлэгийн дүнгээс/.

Урьдчилан хорих байрны нөхцөл нь хорих ял шийтгүүлсэн хүмүүсийг хорих газар газраас дооргүй байх ёстой гэж олон улсын хэмжээнд үздэг ч манайд нөхцөл байдал эсрэг байна.

- Улсын хэмжээний 22 цагдан хорих байрны 8 нь газар дор байрлалтай, 3 нь хагас газар дор байрлалтай, 11 нь газар дээр байрлалтай байгаа ба нийт 431 хорих өрөөний дөнгөж 41 өрөө нь гадагш харсан цонхтой боловч тэдгээр нь салхивчгүй байна. Ганц худаг болон бусад 5 аймгийн цагдан хорих байр агааржуулах тоног төхөөрөмж суурилуулсан гэх боловч тэр нь байнга ажилладаггүй.

Байнгын нар салхи, цэвэр агаар, гэрлийн дутагдал, чийгшил, нянгийн бохирдол зэрэг нь удаан хугацаагаар хоригдож буй хүмүүс амьсгалын замын халдварт өвчин, ялангуяа сүрьеэгээр өвчлөх, хараа нь муудах, булчин сулрах, ядаргаанд орох зэргээр эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлдөг тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч байсан.

Цагдан хорих байрнуудын анхаарал татсан нэг асуудал бол хорих байрны багтаамжийн тухай асуудал мөн.

- 2005 оны 7 дугаар сард Ганц худгийн цагдан хорих төвд шалгалт хийж үзэхэд тус төв 650-670 хүн хүлээн авах багтаамжтай боловч тухайн үед 1009 хүн хоригдож байв. Зарим өрөөнд 10-12 хүн хоригдож, хуульд зааснаар нэг хүнд 2.5 м² талбай оногдох ёстой байхад нэг хүнд 0.8 м² талбай оногдож байсан. Бусад аймгуудын цагдан хорих байрууд ч ачаалал ихтэй үедээ нэг өрөөнд олон хүмүүсийг бөөнөөр нь хорихоос өөр аргагүйд хүрдэг. Агаар болон нарны гэрлийн байнгын дутагдалтай, чийглэг ихтэй өрөөнд олноор нь хорих нь нөхцөл байдлыг улам дордуулж байна. Иймээс хоригдож буй хүнийхээ тоонд тохируулж байраа томсгосоор байх уу, аль эсвэл цагдан хорих арга хэмжээг аль болох гарцаагүй тохиолдолд бага хэрэглэж, богино хугацаагаар хорьж байх уу гэдэгт дүгнэлт хийх шаардлагатай байна.

Хорих өрөөнүүд нь цэвэр усны хангамжгүйн дээр ихэнхи хорих байрнууд төлбөртэй үйлчилгээ /хүнсний эд зүйлс, ахуйн хэрэглээний бараа захиалж худалдан авах/ явуулах боломжгүй байна. Ийм хүнд хатуу нөхцөлд хоригдож буй хүмүүст цувдай, шар будаагаар хийсэн хоол ихэвчлэн өгдөг. Энэ хоолыг хорихын албаны хүмүүс хамгийн илчлэгтэй, ийм нөхцөлд зохицсон чанартай хоол гэж ярьж, танилцуулах дуртай байдаг. Учир нь энэ нь хамгийн хямд төсөр хоол.

Ер нь баривчлах, цагдан хорих байрууд ялангуяа, Ганц худгийн /0461 дүгээр/ цагдан хорих төв нь сүрьеэгийн халдварт өвчний голомт болсоор байгаа нь тэнд хоригдож буй хүмүүсийн эрүүл мэндэд бодитой аюулыг учруулаад зогсохгүй, сэтгэл зүйн том дарамт болдог.

- Ганц худгийн 0461 дүгээр анги цагдан хорих төвд 2004 онд сүрьеэгийн сэжигтэй 142 хүн байснаас 32 хүн өвдөж, 2 хүн нас барсан, 2005 онд сэжигтэй 72 хүнээс 25 хүн өвдсөний 8 хүн нь хоригдох хугацаандаа өвчилсөн байсан /Ганц худгийн эмнэлгийн мэдээ тайлангаас/.

Дөрөв. Эрүүдэн шүүх болон хэргийг, хүнлэг бусаар харьцах шийтгэхээс урьдчилан сэргийлэхэд нөлөөлөх хүчин зүйлс

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нэгдэн орсон улс орон бүр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үүргийг /Конвенцын 16 дугаар зүйл/ хүлээдэг.

Эрүүдэн шүүх, хэргийг хүнлэг бус хандах, хэрэг тулган хүлээлгэх, дарамтлах зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гол нөхцөл нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн хуульд заасан эрхүүдийг ямар нэг алагчлалгүйгээр, хэн нэгэн албан тушаалтны дур зоргоос үл хамааруулан эдлүүлж хэвшүүлэх, ялангуяа эрх зүйн туслалцаа авах, өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, эргэлт авах, ар гэрийнхэнтэйгээ уулзах боломжоор хангагдах явдал мөн. Сүүлийн жилүүдэд өмгөөлөгчдийн сонгон шалгаруулалт хэд хэдэн удаа явагдаж өмгөөлөгчдийн тоо, хүрэлцээ харьцангуй сайжирч байна. Ялангуяа, нийслэл Улаанбаатар хотод өмгөөлөгчдийн тоо боломжийн түвшинд хүрсэн. Улсын хэмжээгээр бүгд 800 гаруй хүн өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсны 500 гаруй нь Улаанбаатар хотод өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байна. Харин зарим аймгуудад өмгөөлөгчдийн тоо тийм ч хангалттай түвшинд байж чадахгүй байна.

4.1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо чанартай, сайн байх тусам эрүүдэн шүүх, хэргийг хүнлэг бус харьцаа гарах магадлал бага байдаг.

2005 онд хяналт шалгалтанд хамрагдсан 8 аймгийн урьдчилан хорих байранд хоригдож байсан хүмүүсийн дунд судалгаа хийж үзэхэд нийт 1338 хүний 31.1 хувь нь өмгөөлөгч аваагүй гэж, 22.3 хувь нь өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулздаггүй хэмээн хариулсан байна. Зарим аймагт, тухайлбал Дархан-Уул аймагт нийт хоригдож буй хүмүүсийн 61.2 хувь нь өмгөөлөгч аваагүй байв. Яагаад өмгөөлөгч аваагүй болон өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбогдуулан хэрэгт холбогдогчид дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд:

- ◆ мөнгөгүйгээс өмгөөлөгч авч чаддаггүй
- ◆ өмгөөлөгч яаж авахаа мэддэггүй
- ◆ өмгөөлөх чадвар нь муу, өмгөөллийн хөлс нь өндөр байдаг

- ◆ өмгөөлөгчийг тулган нэр зааж өгдөг
- ◆ ганцаарчлан уулзах боломж муу, нэг өрөөнд бүх хүн уулздаг
- ◆ байцаагчтай хамт ирж уулздаг, уулзах байрны боломж муу байдаг гэсэн санал нийтлэг гаргасан байна.

4.2. Анхаарал татсан асуудлын нэг бол төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн тухай асуудал байсаар байна. Зарим дүүрэг, аймгуудад гадны байгууллагын санхүүжилтээр төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг төвүүдийг нээн ажиллуулж буй нь зөв алхам болсон. Гэсэн хэдий ч хэрэгт холбогдож буй хүмүүсийн ихэнхи нь төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой иргэд байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан өмгөөллийн хөлсийг төрөөс санхүүжүүлж, Монголын Өмгөөлөгчдийн Холбоогоор дамжуулан олгож байгаа ч энэ нь хэмжээний хувьд бага, үйлчилгээний хөлс олголт нь удаашралтай байдаг учраас төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлэхээр томилогдсон өмгөөлөгчид үйлчлүүлэгчийнхээ төлөө идэвхитэй ажилладаггүй, ийм хүмүүст өмгөөлөгчөөр томилогдон ажиллах сонирхол тэр бүр байдаггүй гэсэн шүүмжлэл гарсаар байна. Цагдан хоригдож буй хүмүүсийн дунд хийсэн судалгааны дүнгээс харахад өмгөөлөгч аваагүй байгаа хүмүүсийн ихэнх нь төлбөрийн чадвар муутай иргэд байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгч томилон оролцуулж, тогтоосон жишгээр урамшуулал олгодог журам хэрэгжээд нилээд хэдэн жил болсон ч энэ нь төдийлэн үр дүнтэй байж чадахгүй байна. Иймээс төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх асуудлыг дагнан эрхэлдэг, төрөөс санхүүждэг /цалинждаг/ өмгөөлөгчдийн багийг аймаг нийслэлийн болон аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн харьяанд ажиллуулах журам тогтоох шаардлагатай байна.

4.3. Нийслэлийн болон орон нутгийн өмгөөлөгчидтэй уулзаж санал хүсэлтийг нь сонсож байхад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гарч байгаа зөрчил дутагдлын талаар тэр бүр бичээд, гомдол гаргаад байх боломж муу байдаг, яагаад гэвэл ихээхэн гомдол санал гаргадаг өмгөөлөгчдөд өширхөх, шахалт дарамт үзүүлэх, янз бүрийн өө сэв хайж шалгуулах, тийм өмгөөлөгчийг аль болох хэрэгт оролцуулахгүй байхыг хичээх, өмгөөлөгчөө солихыг ятгах зэрэг бэрхшээлүүд гардаг гэсэн яриа, шүүмжлэл нийтлэг гарч байна.

Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийн төлөө тууштай ажилладаг зарим өмгөөлөгчдийг дарамтлах, мохоох гэсэн оролдлого гарах болсныг ХЭҮК зориуд тэмдэглэж байна. Ийм үйлдэл Тагнуулын Ерөнхий Газрын үйл ажиллагаанд гарсан. Тагнуулын байгууллагын ажилтнууд “Э” гэгчийг олон улс орны хууль зөрчин Франц улсаас хулгайгаар баривчилж онгоцоор Монгол улсад авчирч, нууц газар 7 хоногийн хугацаагаар хорьж, эрүү шүүлт тулган байцааж, дарамт шахалтанд оруулан хууль бус аргаар

мэдүүлэг авсны эцэст, Алтанбулаг боомтоор машинаар оруулж ирсэн мэтээр цагдаагийн байгууллагад хүлээлгэж өгсөн байдаг. Өмгөөлөгч “С”-г эрх нь ноштойгоор зөрчигдсэн “Э”-ыг тууштай өмгөөлж, ТЕГ-ын энэ хууль бус үйл ажиллагааг олон нийтэд мэдээлснийх нь төлөө түүнийг улсын нууц задруулсан гэж ТЕГ мөрдөн байцаалт явуулж, энэ үйлдэлд ял шийтгүүлсэн нь хүний эрхийн байгууллагуудын төдийгүй олон улсын анхаарлыг татсан хүний эрхийн том асуудал болсон билээ. “Э” болон түүний өмгөөлөгч ХЭҮК-т хандсаны дагуу ТЕГ-аас тайлбар шаардахад “гүйцэтгэх ажлын нууцтай холбоотой учир тайлбар өгөхгүй” гэсэн тул шалгах боломж олдоогүй. Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба ч харьяаллын биш асуудал хэмээн шалгахаас татгалзсан байна. ХЭҮК-оос Улсын Их Хурлын Тусгай хяналтын Дэд хороонд хоёр удаа хандаж шалгуулах хүсэлт тавьсан боловч яаж шийдвэрлэсэн талаар одоо хүртэл хариу ирүүлээгүй.

Ер нь гадаад улсаас хүн хулгайлан баривчилж авчрахыг олон улсын хэмжээнд эрүү шүүлтийн нэг хэлбэр гэж үздэг. Яагаад гэвэл хулгайлагдсан хүнийг хил давуулахын тулд хүчээр унтуулах, эсэргүүцлийг дарах, нууж даллах гээд хүч хэрэглэсэн үйлдлийг байнга хийдэгтэй холбоотой байдаг. “Э” нь ухаан самууруулах тариа байнга хийж, унтаа байдалд оруулж Европын хэд хэдэн улсын хилийг хэрхэн нэвтэрснээ мэдээгүй гэж ярьдаг.

“Тан-луу” хэмээх компаний хятад иргэдтэй холбоотой хэргийн өмгөөлөгч ТЕГ-ын ажилтнууд хятад иргэдийг зодож дарамталсан зүй бус харьцсан тухай гомдол тус Комисст гаргаж байсан.

Тагнуулын байгууллагын тухай хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тагнуулын байгууллагын ажилтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг тухайн байгууллага өөрөө шалгахаар хуульчлагдсан нь тус байгууллагад гарч буй хууль бус ажиллагаа үнэн зөвөөр шалгагдаж, хохирсон иргэдийн эрхийг шударгаар хамгаалах боломжгүй байдалд хүргэж байна. Тагнуулын байгууллага өөрөө өөрийнхөө хууль зөрчсөн үйл ажиллагааг үнэн зөв шалгаж хохирсон иргэний эрхийг хамгаална гэх ямар ч баталгаа байхгүй. Иймээс тагнуулын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэргийг УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба хянан шийдвэрлэдэг байх шаардлагатай байна.

4.4. Сэжигтэн, яллагдагч нь өмгөөлөгчтэйгээ хэний ч хяналтгүйгээр ганцаарчлан уулзах эрхтэй. Баривчлагдсан болон цагдан хоригдсон хүмүүс нь хэний ч хяналт, оролцоогүйгээр өмгөөлөгчтэйгээ чөлөөтэй уулзах боломж, нөхцөлөөр хангагдсан байх ёстой. Гэтэл ийм нөхцөл боломж урьдчилан хорих байруудад байхгүй байна. Ялангуяа, тогтмол мянга шахам хүн хоригддог Ганц худгийн цагдан хорих төвд сэжигтэн, яллагдагч өмгөөлөгчтэйгөө уулзахад зориулсан 2.7 м² талбай бүхий ганцхан өрөө байдаг. Иймээс энэхүү умгар ганц өрөөнд олон тооны

хүмүүс зэрэгцэн өмгөөлөгчтэйгээ уулздаг учраас өмгөөлөгчтэйгээ санасан бодсоноо илэн, далангүй чөлөөтэй ярилцах боломж хомс байдаг тухай өмгөөлөгчид болон тэнд хоригдогсдын гомдол нь үндэслэлтэй. Мөн зарим аймгийн цагдан хорих төвүүд өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзахад зориулсан тусгай өрөө байхгүй, зарим хорих төвд өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ коридорт уулздаг зэрэг нь тавигдаж буй шаардлагыг хангахгүй байна. Цаашид өмгөөлөгчдийг үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан, чөлөөтэй уулзах боломж, нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

4.5. Эрүүдэн шүүх болон хэргий, хүнлэг бусаар харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх нэг баталгаа нь аливаа хэлбэрээр саатуулагдсан хоригдсон этгээд гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсөдтэйгээ уулзах боломжтой байх явдал мөн. Эргэлт уулзалтын ач холбогдол, зорилгын нэг тал нь эрх чөлөөгөө хасуулсан этгээдтэй яаж харьцаж байгааг ар гэрийнхэн нь хянах явдал байдаг.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд хоригдсон этгээд нь төрөл садан буюу бусад хүмүүстэй уулзах эрхтэй бөгөөд хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны буюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл садан бусад хүмүүстэй уулзуулж болно хэмээн заасан байна. Түүнчлэн Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2005 оны 15-р тушаалаар баталсан цагдан хорих байрны дотоод журамд хоригдсон этгээдийг эргэх, түүнтэй уулзах уулзалтыг долоо хоногт хоёр удаа 10-17 цагийн хооронд зохион байгуулж байхыг даалгасан байна. Энэхүү журмаас харвал эргэлт гэж тусдаа, уулзалт гэж тусдаа байхаар тусгагджээ. Тухайлбал, нэг удаа уулзахдаа 4-өөс илүүгүй хүн 30 минутаас дээшгүй хугацаагаар уулзах ба уулзалтын үед хувцас солиулах, хүнсний бүтээгдэхүүн, бусад зүйл дамжуулахыг хориглодог байна. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19-р зүйлд сэжигтэн, яллагдагч нь цагдан хорих шийдвэр гаргасан этгээдийн бичгээр олгосон шийдвэрийг үндэслэн төрөл садан бусад хүмүүстэй уулзах ба уулзалтын үеэр хорих байрны харуул хамгаалалтын ажилтан байлцаж, хориглосон хүнсний болон бусад зүйл, эсхүл гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах буюу гэмт хэрэг үйлдэхэд хүргэх мэдээлэл дамжуулахыг оролдсон тохиолдолд уулзалтыг нэн даруй зогсооно гэж заажээ. Үүнээс үзвэл эргэлт уулзалт гэсэн хоёр төрлийн ойлголт байх ёсгүй бөгөөд уулзалтын үеэр уулзагсад харилцан ярилцах, хориглоогүй хоол хүнс болон бусад зүйл дамжуулах эрхтэй байхаар байна. Хуулийн энэхүү заалттай Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын баталсан цагдан хорих байрны дотоод журмын эргэлт уулзалт гэсэн заалт зөрчилдөж байна. Хуулиар зохицуулан тодорхойлсон харилцааг дүрэм журам гаргаж өөрчлөх, хязгаарлах нь хууль дээдлэх зарчимд үл нийцнэ.

Цагдан хорих байрны дотоод журмын энэхүү хууль зөрчсөн заалтаас үндэслэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч уулзалтын зөвшөөрөл олгохдоо “эргэлт” эсвэл “зөвхөн уулзалт” гэж цохдог ба хэргээ хүлээгээгүй хүн уулзалт авах эрх нь хязгаарлагддаг болох нь харагдаж байна.

Зарим аймагт дээрхээс ч илүү хязгаарлалт тогтоосон байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн цагдан хорих төв долоо хоногт зөвхөн ганц өдөр, Дархан-Уул аймаг 10-16 цагийн хооронд, Увс аймгийн цагдан хорих төв Лхагва гаригийг шүүхээр таслагдсан хүмүүстэй, Баасан гаригийг сэжигтэн яллагдагчтай уулзах өдөр болсон дээрх журмаас илүү хатуу журам тогтоон мөрдөж байгааг нэн даруй өөрчлөх хэрэгтэй байна.

Хяналт шалгалтанд хамрагдсан 8 аймагт хоригдож байсан 1338 хоригдогсдын дунд хийгдсэн судалгаагаар нийт хоригдогсдын 63.6 хувь нь эргэлт уулзалт авдаг гэж, 36.4 хувь нь эргэлт уулзалт авдаггүй гэж тус тус хариулсан байна. Ганц худгийн цагдан хорих төвийн тухайд 44.2 хувь нь эргэлт уулзалт авдаггүй гэж хариулсан нь бусад газруудаас илүү өндөр байгаа нь анхаарал татаж байна.

Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын баталсан цагдан хорих байрны дотоод журмаар долоо хоногт зөвхөн хоёр өдөр эргэлт уулзалт зохион байгуулахаар заасан нь ч зохимжгүй байна. Ялангуяа, нийслэл хотын Ганц худгийн цагдан хорих төвд энэ журам огт нийцэхгүй байна. Байнга мянга шахам хүн хоригдож байдаг энэ цагдан хорих төвд хоёрхон өдөр эргэлт уулзалт оруулж байгаагаас байнгын дараалал үүсч, эргэлт уулзалтаар очсон хүмүүс чөлөөтэй уулзах боломж хомсдож, зарим нь уулзаж чадахгүйд хүрч, хүмүүсийн эрх зөрчигдөж байна.

Сэжигтэн, яллагдагчтай эргэлт уулзалт авах хууль зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Цагдан хорих байрны дотоод журмыг хянан үзэж эргэлт уулзалтын зөвшөөрөл олгож байгаа тогтолцоог өөрчлөх, эргэлт, уулзалт гэж хоёр ангилж, элдэв хууль бус хязгаар тавьдгийг болиулах зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна.

4.6. Эрүүдэн шүүх болон хэргийг хүнлэг бус харьцаанаас сэргийлэх бас нэг арга зам нь хоригдогсдыг байцаалтанд явуулах, өөр газар шилжүүлэх, байцаан шийтгэх зарим үйл ажиллагаанд оролцох зэрэг шилжилт хөдөлгөөнд нь хяналт тавих асуудал байдаг.

Сэжигтэн, яллагдагчийг гадагш авч гарах байцаан шийтгэх зарим ажиллагаанд оролцоод ирсний дараагаар эмчийн үзлэгт заавал оруулдаг, бие эрхтэнд нь үзлэг хийж тэмдэглэл үйлддэг байх журмыг сайтар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд тухайн цагдан хорих төвд ажиллаж байгаа эмч мэргэжилтний үйл ажиллагаа онцгой ач холбогдолтой.

Гэвч зарим цагдан хорих байрууд орон тооны эмчгүй байна. Цагдан хорих төвүүдэд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтан, мэргэжилтний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, эрүүдэн шүүгдсэн, зодуулж цохиулсан, бие эрхтэнд гэмтэл шарх сорви илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах ажиллагааг заавал хийж байх шаардлагатай. Цагдан хорих төвүүдэд хоригдож байгаа этгээд нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх хүсэлт гаргасан нөхцөлд энэ хүсэлтийг нь хангаж эмчид үзүүлж, дүгнэлт гаргуулж байх ёстой боловч энэ үйл ажиллагаа бараг хийгддэггүй тухай хоригдогсад болон хорих байрны ажилтнууд ярьж байна. Энэ нь тэднийг энгийн эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ хийлгэх хөрөнгө зардал байдаггүйтэй холбоотой хэмээн тайлбарлаж байна. Иймээс цагдан хорих төвүүдийг эмч мэргэжилтнээр хангах, тэдний мэдлэг боловсрол чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь сайжруулах, хоригдогсдын эрүүл мэнд, бие эрхтэнд тогтмол үзлэг шалгалт хийж хэвшүүлэх шаардлагатай байна.

4.8. Хоригдон шалгагдаж буй хүмүүс хорих байрны болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж буй хүмүүсийн үйл ажиллагааны талаар өргөдөл, гомдол гаргах эрхээр хангагдсан байх нь аливаа хууль бус үйл ажиллагаа гаргахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд хоригдогсдын өргөдөл, гомдол гаргах эрхийг баталгаажуулж, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хорих байрны захиргаагаар дамжуулан гаргана, эдгээр өргөдөл, гомдлыг хорих байрны захиргаа хянан үзэж 3 хоногийн дотор илгээнэ гэж заажээ /Хуулийн 22 дугаар зүйл/. Цагдан хорих байруудад хяналт шалгалт явуулахад хоригдогсад өргөдөл, гомдол гаргахад төвөгтэй, дарамт шахалттай байдаг тухай гомдол нилээд гарч байна. Судалгаанд хамрагдсан 1338 хоригдогсдоос та өргөдөл, гомдол гаргаж байсан уу гэсэн асуултанд 71.3 хувь нь өргөдөл гомдол гаргаж байгаагүй гэж хариулсан байна. Яагаад өргөдөл, гомдол гаргадаггүй юм бэ гэсэн асуултанд өргөдөл гомдол гаргахаасаа айдаг, эргээд шахалт дарамт учруулдаг, өргөдөл, гомдол гаргаад нэмэргүй хүлээж авдаггүй, өргөдөл, гомдол гаргах боломж муу байдаг, хаана өргөдөл гомдол гаргахаа мэддэггүй гэсэн хариултаудыг өгч байсан. Зарим хорих газрууд тухайлбал, Хөвсгөл аймгийн цагдан хорих байр хоригдогсдын өргөдөл, гомдлыг бүртгэж хүлээн авах тэмдэглэл хөтлөх ажил тогтмол хийгддэггүй байна.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд шүүх, прокурор, болон хорих байрны захиргаанд хяналт тавих төрийн бусад байгууллагад явуулах өргөдөл, санал, гомдлыг хорих байрны захиргаа хянаж болохгүй бөгөөд хүлээн авсны дараагийн өдрөөс хэтрүүлэхгүйгээр битүүмжлэн явуулна /Хуулийн 22-р зүйлийн 22.2

дахь хэсэг/ гэж заасан боловч энэ журмыг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Цагдан хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий прокурорын үйл ажиллагааг сайжруулах, тэнд хоригдогсад хуульд заасан эрхээ үүний дотор өргөдөл, гомдол гаргах, эрүү шүүлт, элдэв хууль бус харьцаанаас ангид байх эрхээ хэрхэн эдэлж байгаад нь тавих хяналтыг эрс сайжруулж, гарсан өргөдөл гомдол бүрийг шуурхай чанартай шалгаж цаг тухайд нь арга хэмжээ авч байх шаардлагатай байна.

Тав. Дүгнэлт, үнэлгээ

Энэ сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа, хяналт, шалгалтын дүнгээс харахад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, баривчлах, цагдан хорих, эрүүлжүүлэх явцад цагдаа, тагнуулын болон хорих байрны ажилтнуудын зүгээс сэжигтэн, яллагдагчид, гэрчтэй эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар харьцах хүний эрхийн зөрчил гарсаар байна. Ялангуяа, байцаан шийтгэх ажиллагаанд хорьж байж хэрэг хүлээлгэдэг, хэрэг илрүүлдэг хуучирсан арга барил, цагдан хорих, баривчлах байрны ахуй нөхцөл нь эрүүдэн шүүлтийг байнга нөхцөлдүүлсээр байна.

5.1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа нь ихэвчлэн сэжигтэн, яллагдагчийг байцаах, өөрөөр нь хэргийг нь хүлээлгэж мэдүүлэг авах арга барилд дулдуйдаж байна. Нотлох баримт бүрдүүлэх, бэхжүүлэх арга ажиллагаанд орчин үеийн техник технологи ашиглах, үүнийг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж, хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах албыг ажиллах нөхцөл бололцоо, техник хэрэгслэлээр хангахгүйгээр гарч буй гэмт хэрэг бүрийг илрүүл гэж шахаж шаардах нь эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бус арга ажиллагааг өгшүүлэхэд хүргэж байна.

5.2. Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомж нь эрүү шүүлтийг хориглосон гэрээ, конвенцитай уялдаагүй, хууль журмууд нь эрүүдэн шүүлт болон хүнлэг бус хэрцгий харьцаанаас урьдчилан сэргийлэх найдвартай баталгаа болж чадахгүй байна. Иргэдийн эрх, эрх чөлөөнд халдах, хязгаарлах, хүч хэрэглэх эрх үүрэг бүхий төрийн албан хаагчид эрх хэмжээгээ хэтрүүлж, урвуулан ашиглаж иргэдийн эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан тохиолдол бүрийг шуурхай шалгаж, шударга ял зэмлэл хүртээх тогтолцоо, зохицуулалт, чадавхи хангалтгүй байна.

5.3. Эрүүдэн шүүгдсэн, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж бие эрхтэн, амь нас, сэтгэл санаагаараа хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах, шударга нөхөн төлбөр олгох эрх зүйн орчинг бүрдүүлж, хохирлыг шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх баталгааг бий

болгох шаардлагатай байна. Ялангуяа, эрүүл мэндийн болон сэтгэл санааны хохирлыг хангалттай хэмжээгээр нөхөн төлүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

5.4. Хамгийн анхаарал татсан асуудал бол цагдан хорих байрны нөхцөл, стандарттай холбоотой асуудал хэвээр байна. Монгол улс 1999 онд Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг баталж, цагдан хорих байрны ахуй нөхцөлд тавигдах шаардлагыг баталсан хэдий ч энэ шаардлагыг хангах чиглэлээр ямар ч арга хэмжээ авалгүй, тодорхой шийдвэр гаргалгүй өдий хүрсэн. Цагдан хорих байрны хүнд, хатуу нөхцөл нь тэнд хоригдож буй хүмүүст бие махбодийн болон сэтгэл зүйн асар том дарамт шахалт болсоор, тэнд хоригдогсад бие эрхтэн, эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах явдал гарсаар байна. Цагдан хорих байрны ийм хүнд, хатуу нөхцөлд хоёр жил, зарим хэрэгт хоёр жил 6 сар хүртэл хугацаагаар хорьж мөрдөн байцаалт явуулж болохоор хуульчлагдсан нь хууль тогтоох төрийн бодлого хүнлэг бус, хэрцгий байгааг харуулж байна. Түүгээр ч үл барам практикт энэ хугацаанд зөвхөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд байсан хугацаа хамаарах мэтээр тайлбарлаж, хуульд заасан дээрх урт хугацааг ч хэтрүүлж байгаа нь жинхэнэ залхаан цээрлүүлэлтийг бий болгож байна.

5.5. Хэрэг зөрчилд холбогдон мөрдөгдөж, хоригдож байгаа хүмүүс төрийн байгууллагын ажилтны хууль бус үйл ажиллагаанд гомдол гаргах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх, гарсан өргөдөл, гомдлыг шуурхай шалган шударгаар, хараат бус, сонирхлын зөрчилгүйгээр шийдвэрлүүлэх нөхцөл боломж хязгаарлагдмал, энэ талаар гарсан өргөдөл, гомдлын шалгалт үр дүн багатай байна.

Зургаа. Санал, зөвлөмж

6.1. Монгол улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглох тухай Конвенцийн заалттай үндэсний хууль тогтоомжоо тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хуулийг нийцүүлэх, эрүүдэн шүүсэн, хэрцгий, хүнлэг бус харьцсан төрийн албан хаагчдад хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, эрүү шүүлтийг хориглох, түүнтэй тэмцэх сэдвийг хуулийн байгууллагын ажилтнууд болон эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд оруулах.

6.2. Эрүүдэн шүүгдсэн, хэрцгий хүнлэг бус харьцаанд өртөж бие эрхтэн, эрүүл мэнд, амь насаараа хохирсон тохиолдолд хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох тухай хууль тогтоомжийн заалтыг боловсронгуй

болгож, бодит хохирлын зэрэгцээ эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

6.3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хорьж мөрдөх хугацааг 18 сараас хэтрүүлэхгүйгээр /насанд хүрээгүй хүмүүсийг 6 сараас хэтрүүлэхгүйгээр/ тогтоож, онц хүнд хэргээс бусад гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээд оршин суух тодорхой хаягтай, гэр бүлтэй, үл хөдлөх хөрөнгөтэй, эрхэлсэн ажил албатай, оргон зугатахаар завдаж байгаагүй тохиолдолд баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг аль болох хэрэглэхгүй байх, хэрэглэсэн тохиолдолд суллахыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарт үүрэг болгосон заалтыг оруулах. Түүнээс гадна хуульд заасан цагдан хорих хугацааг дуусмагц хоригдогчийг нэн даруй суллах журмыг хуульчлах шаардлагатай.

6.4. Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бус харьцах явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход хуулийн байгууллагын ажилтнуудын ажлыг үнэлэх дүгнэх, албан тушаал ахиулах, алдар цол олгох шалгуур үзүүлэлтүүд, заавар, журмыг хянан үзэж, хуулийн байгууллагын ажилд ялангуяа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэж болзошгүй аливаа үзүүлэлтийг оруулахгүй байх арга хэмжээг авах.

6.5. Эрүүдэн шүүсэн болон хэрцгий, хүнлэг бусаар харьцсан тухай гомдол мэдээллийг түргэн шуурхай шалгаж, гэм буруутай этгээдэд шударга ял шийтгэл оногдуулах, ийм төрлийн хэргийг албан тушаалын эсрэг гэмт хэрэгт тооцож, тусгайлан зүйлчилж, шийдвэрлэх журмыг боловсронгуй болгох.

6.6. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх, эрүүлжүүлэх үйл ажиллагаанд тавих прокурорын байгууллагын хяналт, үйл ажиллагааг тогтмолжуулж, чанар үр нөлөөг нь дээшлүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгах, хариуцлага тооцох ажлыг эрчимжүүлж илэрсэн зөрчил дутагдлын талаар олон нийтэд ил тод мэдээлж байх, шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтантай холбоотой гэмт хэргийг шалган мөрдөх эрх бүхий Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах албыг бэхжүүлэх, чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь сайжруулах.

6.7. Баривчлах, цагдан хорих болон хорих ангиудад хоригдож байгаа хүмүүстэй эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх, тийм зөрчил гарсан тохиолдолд цаг тухайд нь холбогдох байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж, шуухай шалган шийдвэрлүүлэхэд тэдгээр хүмүүстэй гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд нь уулзах боломжоор хангагдах явдал чухал ач холбогдолтой тул уулзах

зөвшөөрөл олгож буй тогтолцоог өөрчилж, уулзах зөвшөөрлийг хорих зөвшөөрөл олгосон шүүгч өгдөг болгох, түүнчлэн зөвхөн хоёрхон өдөрт уулзалт зохион байгуулж байгаа болон эргэлт, уулзалт хэмээх хоёр тусдаа ойлголт бий болгож журамласныг өөрчлөх.

6.8. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, саатуулах үеэс эхлэн өмгөөлөгч оролцуулах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдаас өмгөөлөгчийн тавьсан санал хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн байдалд тавих прокурорын хяналтыг сайжруулж, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг, улсын төсвөөс санхүүждэг өмгөөлөгч бий болгож ажиллуулах журмыг судалж хэрэгжүүлэх.

6.9. Тагнуулын Ерөнхий Газрын ажилтнуудын гүйцэтгэх болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгож, Тагнуулын байгууллагын үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

6.10. Баривчлах, цагдан хорих байруудыг эмч, мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангаж, эдгээр газруудад хоригдогсад бие эрхтэн, эрүүл мэнд, амь насаараа хохирч байгаа ноцтой зөрчлийг таслан зогсоох.

6.11. Албадан саатуулах, эрүүлжүүлэх, цагдан хорих болон хорих газруудын үйл ажиллагаа ихээхэн хаалттай, олон нийтийн хяналтаас хөндий байгаад дүгнэлт хийж, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт зааснаар бүх хэлбэрийн хорих байр газруудын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын зохистой тогтолцоог бий болгох.

6.12. Баривчлах, цагдан хорих байруудыг үе шаттайгаар шинэчлэн өөрчилж, хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлэхэд улсаас тусгайлсан хөрөнгө оруулалт хийх, ялангуяа Ганц худгийн цагдан хорих төвийг тэргүүн ээлжинд өөрчлөн сайжруулахад хөрөнгө оруулалт хийх.

6.13. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.1.12 дахь хэсэгт эрүүлжүүлэх, түр саатуулах, баривчлах, цагдан хорих болон хорих газарт саатуулагдаж буй этгээд нас барвал хэрэг үүсгэн шалгах, тайлагнах үйл ажиллагааг ил тод болгох үүднээс түүнд хүний эрхийн байгууллагуудыг оролцуулах журам тогтоон мөрдөнө хэмээн заасан. Гэсэн хэдий ч эдгээр газруудад хүний амь нас хохирсон тохиолдлыг зөвхөн хуулийн байгууллагын хүрээнд хязгаарлагдмал хүрээнд шалган өнгөрдөг дутагдал хэвээр байна. Эдгээр тохиолдлын учир шалтгааныг тухайлбал, эрүү шүүлтэд өртсөн, хэрцгий хүнлэг бусаар харьцсан зэрэг ноцтой зөрчил байгаа эсэхийг хянах, энэхүү үйл ажиллагааг ил тод болгох үүднээс хөтөлбөрт заасан заалтыг хэрэгжүүлэх журмыг тогтоон мөрдөх.

НҮБ-ЫН ЭРҮҮ ШҮҮЛТИЙН АСУУДЛААРХИ ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАНФРЭД НОВАКИЙН МУ-Д АЖИЛЛАСАН ТУХАЙ ИЛТГЭЛ

ТАНИЛЦУУЛАГА

1. Эрүү шүүлтийн асуудлаархи Тусгай Илтгэгч нь 2005 оны 6 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд Монгол улсад айлчиллаа. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс 2005 онд Эрүү шүүлтийн талаархи олон нийтийн нээлттэй хяналт шалгалтын ажилд Тусгай Илтгэгчийг оролцуулан ажиллуулахыг анхлан санаачилж байсан юм.

Хүний эрхийн зөвлөлийн тусгай үйл ажиллагааг явуулахаар 2004 оны 4 дүгээр сараас хойш урилга ирүүлээд байсан Засгийн газар Тусгай Илтгэгчийг 2005 оны 3 дугаар сард Монгол улсад ирж ажиллахыг урьсан билээ. Айлчлалын хүрээнд Тусгай Илтгэгч эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцах явдалтай холбоотой хууль-эрх зүйн орчин, Засгийн газраас авч байгаа арга хэмжээтэй танилцлаа.

Мөн зөрчил гарсан гэх мэдээллийг Засгийн газрын зүгээс хэрхэн авч үздэг, ялангуяа түүнийг шалгах, шийтгэх, урьдчилан сэргийлэх үүднээс авч хэрэгжүүлдэг хариу арга хэмжээг авч судаллаа. Тусгай Илтгэгч бичгээр авсан мэдээлэл, төрийн албан хаагчид, Төрийн бус байгууллага, хуульчид, хохирогчид, гэрч нартай хийсэн ярилцлага, түүнчлэн хорих газруудад биечлэн очиж хийсэн шалгалтын материалд тулгуурлаж илтгэлээ бэлтгэсэн болно. Үүний дүнд олж тогтоосон зүйлс, дүгнэлт, зөвлөмжөө дараахь байдлаар тайлагнаж байна.

2. Тусгай илтгэгчийн айлчлалын гол зорилго нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх нөхцөл байдалд үнэлгээ өгөх, тэдгээрийг устгах, урьдчилан сэргийлэх механизмд дэмжлэг үзүүлж, Засгийн газартай тогтоох урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлэхэд оршиж байлаа.

3. Тусгай илтгэгчийг айлчлах үед 2005 оны 5 дугаар сард Ерөнхийлөгчийн сонгууль дөнгөж дуусч байсан бөгөөд арав гаруй жилийн өмнө эхлүүлсэн улс төр, эдийн засгийн шинэчлэлтийг бэхжүүлж, төрийн хэт төвлөрсөн тогтолцооноос парламентийн ардчилалд шилжих хүнд хүчир замыг туулахын төлөө Монгол улс нь чармайн ажиллаж байгааг тэмдэглэж байна.

4. Айлчлалын үеэр Тусгай Илтгэгч Ерөнхийлөгч Н.Багабандид бараалхаж, Гадаад хэргийн дэд сайд А.Баттөр, Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүй газрын орлогч захирал О.Очиржав, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Алтангэрэл, тус яамны мэргэжилтэн Ж.Хунан нартай уулзсан юм. Түүнчлэн Ерөнхий прокурор М.Алтанхуяг, Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав, прокурор Т.Сүхбаатар, Дээд шүүхийн шүүгч Д.Батсайхан, УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дарга Б.Галдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ж.Чойжанцан, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын дарга М.Энх-Амгалан нартай уулзлаа.

5. Парисын зарчмын дагуу үүсгэн байгуулагдсан Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/-ын дарга С.Цэрэндорж, ХЭҮК-ын гишүүн Ж.Дашдорж, Г.Далайжамц, АА-ны дарга Б.Хишигсайхан, Өргөдөл, гомдол хариуцсан ахлах референт П.Оюунчимэг, Олон нийттэй харилцах албаны ажилтан Г.Золжаргал, Мэдээлэл харилцааны ажилтан Л.Гэрэл нартай мөн уулзаж ярилцав.

Хүний Эрхийн Үндэсний Комисс нь 2005 оныг Эрүү шүүлтийн асуудлаархи нээлттэй хяналт шалгалтын жил болгон зарлаж ажлаа 2005 оны 1 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд уг ажил 12 дугаар сард нэгдсэн илтгэл гаргаснаар өндөрлөх юм байна.

Уг ажлын хүрээнд Орхон, Дархан-Уул, Төв, Дорнод, Хөвсгөл, Увс, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотыг хамарсан олон талт арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал, дотоодын хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг харьцуулан судлах, шүүх, прокурорын байгууллагын ажилтан, өмгөөлөгчид, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба, Цагдаагийн ерөнхий газрын хяналтын алба болон прокурорын байгууллагад ирсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх, цагдан хорих байр болон хорих ангийн байруудын нөхцөл байдлыг үзэж шалгах, олон нийтэд мэдээлэл, сурталчилгаа явуулах, ял шийтгэлгүй үлдсэн байдалд дүн шинжилгээ хийх зэрэг болно. Судалгааны үеэр олж авсан аливаа мэдээллийг олон нийтээр хэлэлцүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах юм байна. Хүний Эрхийн Үндэсний комиссын санаачилгаар анх удаа хийгдэж буй олон нийтийн нээлттэй хяналт шалгалтын арга хэмжээг Тусгай Илтгэгч талархан сайшааж байна. Тусгай Илтгэгч эрүү шүүлтийн талаархи ХЭҮК-ын дарга, гишүүд, ажилтнуудын хүчин чармайлтыг өндрөөр үнэлж, цаашид тэднийг тууштай дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байна.

6. Тусгай Илтгэгч УИХ-ын гишүүн С.Оюун, Л.Гүндалай, Эмнести интернэйшнл, Хүний эрх ба хөгжил төв, Эрх чөлөөний төв, Монголын

Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хоригдлуудын нийгэмлэг зэрэг хэд хэдэн төрийн бус байгууллагын төлөөлөгчид, мөн өмгөөлөгчидтэй уулзжээ.

7. Тусгай Илтгэгч дипломат корпусын төлөөлөгчид тухайлбал, Францын Элчин сайд Н.Чапиус, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Элчин сайд Р.Остен, АНУ-ын Элчин сайд Памела Слук нартай уулзсан юм. Мөн Монгол дахь НҮБ-ын орон нутгийн ажилтнууд, тухайлбал НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, Дүрвэгсдийн Дээд Комиссариатын ажилтнуудтай мөн уулзаж ярилцсан байна.

8. 2005 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд Тусгай Илтгэгч дараахь хорих байруудаар орж хоригдож байгаа хүмүүс болон албан хаагчидтай уулзаж ярилцсан юм. Үүнд: Жирийн дэглэмтэй хорих 0421 дүгээр анги /Амгалан/, Албадан саатуулах газар, Ганц худаг дахь 0461 дүгээр Цагдан хорих анги, чанга дэглэмтэй хорих 0413 дугаар анги /Зүүнхараа/, чанга дэглэмтэй хорих 0429 дүгээр анги /Тахир соёот/, Сүрьеэгийн эмнэлэг, жирийн болон чанга, онцгой дэглэмтэй хорих 0405 дугаар анги /Тахир соёот/, Цагдан хорих төв /Зуунмод хот/ зэрэг болно.

9. Тусгай Илтгэгч урилга ирүүлсэн явдалд Монгол улсын Засгийн газарт талархлаа илэрхийлж байна. Айлчлалын үеэр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Гадаад хэргийн дэд сайд нар бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. Харин шинээр сонгогдсон Ерөнхийлөгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад хэргийн сайд нартай уулзаж чадаагүй ажээ.

Засгийн газрын зарим байгууллагуудын зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлээгүй явдал нь түүний айлчлалын хүрээн дэх удирдамжийг ноштойгоор зөрчсөн явдал болов.

Хэдийгээр Тусгай Илтгэгчид холбогдох бүх мэдээллийг өгөх, хорих ангийн байранд нэвтрүүлэх, хоригдож байгаа хэнтэй ч уулзаж ярилцах зөвшөөрөл олгохоор тохиролцсон боловч цаазаар авах ялтай холбогдолтой аливаа мэдээлэл болон цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялантай уулзах хүсэлтийг удаа дараа тавьсан боловч зөвшөөрсөнгүй. Иймд цаазаар авах ялаар шийтгэх нөхцөл байдалтай холбогдсон асуудлаар гаргасан дүгнэлтийг зөвхөн гэрч, гэр бүлийн гишүүд болон төрийн бус байгууллагаас өгсөн мэдээлэл дээр үндэслэж гаргахаас өөр арга байсангүй.

10. Мөн НҮБ-ын Суурин төлөөлөгч, хатагтай П.Мета, Людвиг Болцманны Хүний эрхийн хүрээлэнгийн хатагтай Е. Мак Артур, Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын Ё.Бэрри, С.Сизд нарт туслалцаа дэмжлэг үзүүлсэн явдалд талархлаа илэрхийлж байна.

I. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Олон Улсын түвшинд

11. Монгол улс нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцахыг хориглосон НҮБ-ын хүний эрхийн гол гэрээ, конвенци болох Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци, Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэгдүгээр нэмэлт Протоколыг ингэж соёрхон баталснаар иргэний болон улс төрийн эрхийг зөрчсөн тухай иргэний өргөдлийг Хүний эрхийн хороо хүлээн авч хянан үзэх эрх (бүрэн эрх)-ийг хүлээн зөвшөөрсөн юм. Гэхдээ Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлд заасан Эрүүдэн шүүхийн эсрэг хороог хүлээн зөвшөөрөөгүй байна. Түүнчлэн Монгол улс нь Женевын 1949 оны Конвенц, Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм зэрэг холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн оржээ. Монгол улс нь Пактын 2 дахь нэмэлт протоколд нэгдэн ороогүй байна.

Үндэсний хэмжээнд

а/ Хүний эрхийн Үндсэн хуулийн хамгаалалт

12. 1992 оны Үндсэн хуулийн 10.1-д: “олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж ...”, 10.2-т: “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасан байдаг. Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг нь “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн нэртэй бөгөөд 16 дугаар зүйлд: “хүний үндсэн эрх (үүд), тухайлбал амьд явах эрх; өргөдөл, гомдол гаргах эрх; эрх чөлөөтэй аюулгүй байх эрх, шударга шүүхээр шүүгдэх эрхийн талаар заасан байна. Үндсэн хуульд улс төрийн орогнол хүсэгч болон гадаадын иргэний тодорхой эрхийг тусгасан заалт бий.

13. Үндсэн хуулийн 16.13-т: “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан байна.

б/ Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг хориглосон.

14. 2002 онд шинэчилсэн Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлд эрүүдэн шүүх гэдгийг бие махбодид хүнд, хүндэвтэр **гэмтэл учруулахгүйгээр** байнга зодох буюу тарчлаах шинжтэй бусад үйлдэл хийсэн эрүүдэн

шүүсэн гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. Түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэргээр хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадвал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна /251.1 дүгээр зүйл/.

15. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10.4 дүгээр зүйлд: “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэргийг хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан. Мөн Эрүүгийн байцаан тухай хуульд “Сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэргийг харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглоно” гэж заасан байна /81.2 дугаар зүйл/.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 оны хуулийн 3 дугаар зүйлд: “Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно” гэж заасан. Цагдаагийн тухай 1992 оны хуулийн 29 дүгээр зүйлд: “Цагдаагийн албан хаагч хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэн, хүнлэг харилцах үүрэгтэй” гэж заасан.

16. Хэдийгээр “эрүү шүүлтийн” талаар хууль тогтоомжид олон заалт байгаа боловч Монголын хуулинд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “өвтгөн зовоож, хүнд дарамт шахалт үзүүлдэг”, “бие махбодь болон сэтгэл санааны хүчтэй шаналал учруулах”, “аливаа үйлдлийг тодорхой зорилгоор үйлдэх”, “санаатайгаар хийсэн, мөн албан тушаалтны санаачилга, зөвшөөрөл эсвэл мэдэж байснаар” гэсэн гол хэсгийг тусгаж өгөөгүй байна.

Түүнээс гадна Эрүүгийн хуульд эрүү шүүлтийн талаархи гол заалт болох 100.1 дүгээр зүйлээр оногдуулах ял шийтгэлийн хэмжээ нь харьцангуй бага буюу 2 жил хүртэл хугацаагаар хорино гэж заасан байна.

17. Конвенцийн агуулгад нийцэхүйц хэд хэдэн үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцон хуульчилсан бөгөөд дараахь ял шийтгэлийг оногдуулж байна. Үүнд: тохуурхан даажигнаж, зовоон тарчлаах замаар бие махбодид санаатайгаар хүнд гэмтэл учруулсан /96.2.8 дугаар зүйл/ бол 7-10 жилийн хорих ялаар, хохирогчийг зовоон тарчлааж хөнгөн гэмтэл учруулсан /98.2 дугаар зүйл/ бол 3-5 жилийн хорих ялаар, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар /251.1 дүгээр зүйл/ эсхүл энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол таваас дээш

арван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, санамсаргүйгээр бусдын амийг хөнөөсөн /94 дүгээр зүйл/ бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ялаар, харгис, хэрцгий харьцсан буюу байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон /95 дугаар зүйл/ бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулсан /97 дугаар зүйл/ бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар, бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан /99 дүгээр зүйл/ бол гурваас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ялаар, өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлээгүй /106 дугаар зүйл/ бол гурваас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ялаар, бусдыг амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь яаралтай тусламж үзүүлээгүй /107 дугаар зүйл/ бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс үлэмж хэмжээний хохирол учирсан /264.2 дугаар зүйл/ бол таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, албан тушаалтан албан үүргээ биелүүлээгүйн улмаас хүнд хор уршиг учирсан бол 3 жил хүртэл хорих ялаар тус тус шийтгэнэ гэж заасан байна.

18. Эрүү шүүлтийн талаархи захиргааны хариуцлагын тухайд цалингаас хасах, тушаал бууруулах, ажлаас халах зэрэг захиргааны хариуцлага тооцдог цагдаагийн сахилгын хороо байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бас хорих байгууллагын ажилтанд ийм төрлийн арга хэмжээ авдаг байна.

в) Баривчлах, цагдан хорих үед эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус харьцахаас хамгаалах нь

19. Баривчлах, цагдан хорихтой холбогдсон хууль гэж Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль болон Цагдаагийн тухай хууль /1993 он/-ийг үзэж болно.

Баривчлах, урьдчилан хорих болон мөрдөн байцаах

20. Баривчлагдсан, цагдан хоригдож буй этгээдийг хамгаалах Үндсэн хуулийн хамгаалалтын асуудлаар 16 дугаар зүйлд: Баривчилсан шалтгаан, үндэслэлийн талаар баривчлагдсан этгээд, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэх /16.13 дугаар зүйл/, өөрийгөө өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах /16.14 дүгээр зүйл/ эрхийн талаар заасан байна.

21. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтэнг баривчлах үеийн эрх хэмжээг тогтоосон байна. Хуулийн 35.2 дугаар зүйлийн дагуу сэжигтэн этгээд дараахь эрхтэй байна. Үүнд: ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаар

мэдэх, өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан тогтоолтой танилцах, өөрийгөө өмгөөлүүлэх, өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах зэрэг болно.

22. Монгол улсад хүний эрх, эрх чөлөөг олон байгууллага хаа сайгүй хязгаарлах бололцоотой. Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Тагнуулын Ерөнхий газар, Батлан хамгаалах, Эрүүл мэндийн яамны харьяа газрууд үүнд багтаж байна.

Ерөнхийдөө, хорих газруудыг түр саатуулах байр /72 цаг хүртэл/, урьдчилан хорих байр /30 сар хүртэл/, жирийн болон чанга дэглэмтэй, урт хугацааны /6 сар буюу түүнээс дээш хугацаагаар/ ял эдлэх хорих ангиуд, гол төлөв захиргааны шинжтэй арга хэмжээг авч эдлүүлэх зорилготой /эрүүлжүүлэх байр/ тусгаарласан төвүүд гэж ангилж болно. Хорих эрх, үүрэг гүйцэтгэдэг /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар/, мөрдөн байцаах ажиллагаа явуулах /Цагдаагийн ерөнхий газар/ байгууллагууд нь нэг яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа бөгөөд ижил төрлийн, тухайлбал цагдаагийн түр саатуулах байр болон цагдан хорих байр /Ганц худаг дахь 0461 дүгээр анги/, хорих анги /тусгай дэглэмтэй цаазаар авах ялтанг байлгадаг шоронг хүртэл/-ийг нийтэд нь удирддаг байна.

23. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд цагдан хорих хугацааг заасан байдаг. Хуулийн 59.5, 59.6 дугаар зүйлд заасны дагуу шүүх цагдан хорих зөвшөөрөл олгох эсхүл суллах шийдвэр гаргахаас өмнө сэжигтнийг 72 цаг хүртэл хугацаагаар саатуулах боломжтой /өөрөөр хэлбэл цагдаагийн ажилтан баривчлах тогтоол авахаас өмнө 24 цаг саатуулж болох бөгөөд шүүгчээс тогтоол авснаас 48 цагийн дотор цагдан хорих эсхүл суллах үүрэгтэй/ 72 цагийн дараа шүүхийн шийдвэр гараагүй бол шууд суллах үүрэгтэй. 61 дүгээр зүйлд заасны дагуу саатуулагдсан этгээдийн гэр бүлийнхэн болон өмгөөлөгчид 24 цагийн дотор саатуулсан болон баривчилсан тухай мэдэгдэх ёстой.

24. Сэжигтэн, ялагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 оны хуулийн 6.4 дүгээр зүйлд: Төв, суурин газраас алслагдсан нутаг дэвсгэрт байгаа цэргийн анги, салбарын сахилгын хорих байранд сэжигтнээр 14 хоног хүртэл хугацаагаар цагдан хорьж болно; Цагдаагийн тухай 1993 оны хуулийн 24.3 дугаар зүйлд: Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн этгээдийн нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд уул этгээдийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно; Захиргааны хариуцлагын тухай 1992 оны хуулийн 13 дугаар зүйлд: Зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэх

үед шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийг сумын Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах захиргааны журмаар албадан саатуулж болно. Зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар түр саатуулах хугацаа 6 цагаас илүү байж болохгүй; Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай 1994 оны хуулийн 1 дүгээр зүйлд: Хараа хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 16 хүртэлхи насны хаяг, эцэг эх, харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхдийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан 7 хоног хүртэл хугацаагаар түр саатуулж болно; Тагнуулын байгууллагын тухай 1999 оны хуулийн 12.1.5 дугаар зүйлд: Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэргийн сэжиг бүхий этгээдийг түр албадан саатуулах, шалгах; Хилийн тухай 1993 оны хуулийн 33 дугаар зүйлд: Хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг тэмдэглэл үйлдэх зорилгоор гурван цаг хүртэл албадан саатуулж болно гэж тус тус заасан байна.

Үүнээс үзэхэд хэд хэдэн байгууллагын албан хаагчид өөрсдийн эрх мэдлийн хүрээнд иргэдийг 3-72 цаг хүртэл хугацаагаар барьж саатуулах эрхтэй байгаагаас гадна Тагнуулын байгууллагын тухай хуульд заасны дагуу тагнуулын ажилтан тодорхой бус хугацаагаар саатуулах эрхтэй байна.

25. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3.1 дүгээр зүйлд “өмгөөлөгчийг байлцуулах эрхтэй”, 35.2.5 дугаар зүйлд “хэлмэрч авах эрхтэй”-г заасан байна. 79.4 дүгээр зүйлд “Нотлох баримт цуглуулах, баримтжуулах талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Цагдан хорих

26. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36.3 дугаар зүйлээр яллагдагчид сэжигтэнтэй төстэй хамгаалалтыг олгосон байна. Таслан сэргийлэх арга хэмжээнд оршин суугаа газраасаа гадагш явахгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө барьцаалах, цагдан хорих зэрэг багтана /62 дугаар зүйл/.

27. 68 дугаар зүйлд хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно. Хүндэвтэр гэмт хэргийн оролцогч этгээдийг өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, оргон зайлж болзошгүй бол цагдан хорьж болно.

28. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69.1-69.4 дүгээр зүйлд цагдан хорьж мөрдөх хугацааг 14-30 сар хүртэл байхаар заасан. 18 насанд хүрээгүй сэжигтнийг 18 сар хүртэл хугацаагаар цагдан хорьж болно /366.4 дүгээр зүйл/.

29. Тусгай Илтгэгч нь цагдан хорих дээд хугацаа хэт урт байгаа, практикт цагдан хорих явдал ердийн жишиг болгон хэрэглэж байгаа болон цагдан хорих, хорих ялнаас онцын ялгаатай зүйл алга байна. Сэжигтэнг ялантай цуг байлгаж болохоор байна гэдгийг цохон тэмдэглэжээ. Тусгай Илтгэгч цагдан хорихын энэхүү байдал нь олон улсын эрх зүйн /Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэг/ гэм буруугүйг нотлох зарчим болон эрх чөлөөг хязгаарлах тусгай журамтай зөрчилдөж байна. Хүүхдийн эрхийн хороо нь хүүхдийг урт хугацаагаар цагдан хорьж байгаа практик ажиллагаа, хөнгөн төрлийн гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүүхдэд хорих ял оногдуулж байгаа байдал, хүүхдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулахад хүндрэл учирч байгаа зэрэгт сэтгэл гүнээ зовниж байгаагаа илэрхийлсэн байна.

Ялтныг хорих

30. Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлд: “Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид, хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлнэ” гэж заасан. 53 дугаар зүйлд: “Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино” гэж заасан байх бөгөөд эдгээр хүмүүс Хорих 0405 дугаар ангид ганцаар тусгаарлагдан ялаа эдэлж байна.

Хорих ангид очсон талаар

31. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 оны хуулийн 45 дугаар зүйлд ганцхан цагдан хорих байранд хяналт шинжилгээ хийх тухай заасан байна. Үүнд, цагдан хорих байрны үйл ажиллагаа, нөхцөл, журам нь энэ хуульд хэрхэн нийцэж байгаад прокурорууд хяналт тавина гэж заасан. Системтэйгээр хараат бус хяналт шалгалтын талаар заалт алга. Хэдийгээр Хүний Эрхийн Үндэсний Комисс аливаа хязгаарлалтгүйгээр шууд нэвтрэн орох эрхтэй

боловч төрийн бус байгууллагуудын эрх хязгаарлагдмал байгаа бөгөөд зөвшөөрлийг хааяа олгодог байна.

г/ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэж байгаа байдалд хийсэн шалгалт

д/ Гомдол болон мөрдөн байцаалт

32. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 20, 35.2, 36.3 болон 106 дугаар зүйлд: Сэжигтэн, ялагдагч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, цагдан хорих байрны үйл ажиллагааны талаар гомдол гаргаж болно. Шинэхэн байгуулагдсан УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна /ЭБШХ-ийн 27.2 дугаар зүйл, Прокурорын байгууллагын 2002 оны хуулийн 10 дугаар зүйл/.

33. Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн, хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татахгүй.

34. Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай 2000 оны хуулийн 9 дүгээр зүйлд: “Хүний Эрхийн Үндэсний Комисст гомдол гаргаж болно” гэж заасан. Уг хуулиар Комисст хүмүүсийг дуудан ирүүлэх, хорих байранд чөлөөтэй нэвтрэх, баримт материал авах, шинжээч томилох зэрэг эрхийг олгожээ. Мөн Комисст шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүх хуралдаанд оролцох эрхийг энэ хуулиар олгосон байна. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Хүний Эрхийн Үндэсний Комисст гомдол гаргагч нь гомдлыг эрх нь зөрчигдсөн өдрөөс эсхүл тийнхүү зөрчигдсөн тухайгаа мэдсэнээс хойш 1 жилийн дотор гаргах ёстой.

Нөхөн олговор

35. Үндсэн хуульд бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн тухай заажээ /16.4 дүгээр зүйл/. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35.2, 36.3 дугаар зүйлд төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг төлүүлэх эрхийн тухай заасан. ЭБШХ-ийн 44 дүгээр бүлгийн 388-397 дугаар зүйлд уг эрхийн асуудлыг нарийвчлан зохицуулсан байна. Гэхдээ, нөхөн олговор олгох үндэслэлд /389 дүгээр зүйл/ хууль бусаар баривчлах, яллах, хорих гэж заасан байх бөгөөд эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах талаар заагаагүй байна.

ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ТАЛААРХИ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

36. Өнгөрсөн хугацаанд Тусгай Илтгэгч нь Монгол улс дахь эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах талаар хэд хэдэн гомдол, мэдээлэл хүлээн авсан. Гэхдээ өмнө дурьдсанчлан эрүү шүүлт гарч байгаа талаар ирсэн гомдлын тоо нь тус улсад эрүүдэн шүүлт түгээмэл байна гэсэн үг биш. Харин ч хувь хүмүүс, өмгөөлөгчид, иргэний нийгэм эрүү шүүлт гэж юу болох, түүнчлэн гомдол мэдээлэлд хариу арга хэмжээ авдаг олон улсын механизмын талаархи олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны түвшинг илтгэх үзүүлэлт байж болох юм. Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар олон нийтийн дундах эрүү шүүлтийн талаархи ойлголт хомс, гэмт хэргийн сэжигтэн этгээдүүдийн эсрэг тодорхой хүч хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн зан үйлийн хандлага байгаа нь харагдсан. Энэ нь яллахын тулд сэжигтэн, ялагдагчийн гэм бурууг нь хүлээлгэхийг зорьдог эрүүгийн эрх зүйн тогтолцоо давамгайлсан байдалтай хавсраад эрүү шүүлтийг бодит практик болгох эрсдлийг бий болгож байна.

37. Хоригдож байгаа этгээдүүдтэй хийсэн уулзалт ярилцлага болон айлчлалын үеэр ирсэн гомдол, мэдээлэл /зарим хэсгийг хавсралтад байгаа/, түүнчлэн төрийн зарим өндөр албан тушаалтан, Хүний Эрхийн Үндэсний Комисс, өмгөөлөгч нартай уулзсан уулзалт, төрийн бус байгууллагаас авсан мэдээ, хөндлөнгийн шүүх эмнэлгээс гаргасан нотлох баримтад үндэслэн Тусгай Илтгэгч хууль сахиулах байгууллагын албан хаагчаас эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдал, ялангуяа цагдаагийн албадан саатуулах байр, урьдчилан хорих байр, чанга, онцгой дэглэмтэй хорих анги /тухайлбал, цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүс/-д оршин байна гэсэн дүгнэлтийг хийж байна.

38. Ихэнхи хэргүүдэд хэрэглэсэн эрүүдэн шүүх нийтлэг арга нь хэрэг хүлээлгэхийн тулд шанаадах, бороохойдон зоддог болохыг Тусгай Илтгэгч олж тогтоосон юм. Тусгай Илтгэгч Монголд ирэхийн өмнөхөн Баатарын Мөнхбаярын /хэргийн тухай хавсралтад дурдсан/ баривчлах төвд хэрцгийгээр зодуулж гэмтлийн улмаас амь насаа алдсан тухай мэдээллийг тэрээр авч байсан. Өөр хэрэглэдэг аргын төрөлд нь “агаарт нисгэх” /сандал дээр зогсоож байгаад сандлыг нь түлхэж унагаах/, хурууны хумсны завсраар зүү шаах, цахилгаан гүйдэлд цохиулах /өрөөний таазны гэрэлд холбосон цахилгааны утсыг хувинтай усанд хийх замаар/, тамхины цогоор түлэх, удаан хугацаагаар гав, дөнгөтэй байлгах /тасралтгүй 3 жилийн турш гавтай байлгасан тохиолдол бий/, харуулаас хүчирхийлэх, дэмжлэг авсан гэмт этгээдийн өрөөнд сэжигтнийг цуг хорьж, хүч хэрэглэн хэрэг хүлээлгэх, өмгөөлөгч, гэр бүлийн хүмүүсээс зайтай байлгах

зорилгоор газар зүйн хувьд алслагдмал орших цагдан хорих байранд сэжигтнийг хорих зэрэг орно. Хоригдогчийн аюулгүй байдлыг хангах явдлыг /дээрх 20 дугаар хэсэг/, тухайлбал өмгөөлөгч, гэр бүлийн гишүүдэд мэдэгдэх зэргийг удаа дараа үл хайхрах явдал гарсаар байна.

Мөрдөн байцаалтыг дутмаг явуулах болон ял шийтгэлгүй үлдэх байдал

39. Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар ял шийтгэлгүй үлдэх байдал нь эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрсгий байдлаар харьцах явдал оршиж байгаагийн гол шалтгаан бөгөөд тодорхой, үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол цаашид Монголд ял шийтгэлгүй үлдэх хэв маягийг улам даамжруулах болно. Эрүүгийн хуульд эрүү шүүлтийн нэр томъёог Конвенцитай нийцүүлэн тодорхойлоогүй, гомдлыг хүлээн авч мөрдөн шалгах ядмаг тогтолцоо оршиж байгаа нь гэмт этгээдүүдийг халхавчилж байна. Хэдийгээр ийм тодорхойлолт байхгүй ч гэсэн уг зүйл заалтаар одоо болтол хууль сахиулах байгууллагын нэг ч ажилтанд прокуророос ял тулгаж шийтгээгүй байгаа нь гэм буруугаас зайлсхийж байгааг тодорхой харуулж байна.

40. Тусгай Илтгэгч хохирогч, хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурор, өмгөөлөгч, шүүхийн байгууллагын хүмүүстэй уулзаж ярилцаж байхад эрүү шүүлтийг хориглох явдалтай холбоотой олон улсын стандартын талаархи ойлголт, сурталчилгаа дутмаг болох нь ажиглагдаж байсан. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос санаачлан явуулсан олон нийтийн нээлттэй хяналт шалгалтаас өөр Засгийн газрын зүгээс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн талаархи сурталчилгааг олон нийт, хууль хяналтын байгууллага, хуулийн мэргэжилтэн, шүүхийн албан хаагчдын дунд явуулаагүй байна. Цагдаагийн академийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн сэдвээр 2 өдрийн хичээл оруулахаар тохиролцсон боловч одоогийн байгаа бие бүрэлдхүүний дөрөвний гурав нь хүний эрхийн тухай сургалтад хамрагдаагүй тухай мэдээ байна.

41. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулинд хохирогч гомдол гаргаж шийдвэрлүүлэх талаар заалт байгаа бөгөөд энэ нь практикт хэрэгжихгүй байна. Хэдийгээр УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албыг байгуулан ажиллуулж байгаа боловч энэ байгууллага нь өөрийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах чадавхигүй байна. Тусгай Илтгэгч 2005 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Мөрдөн байцаах албаны дарга Б.Галдаатай уулзаж ярилцсан бөгөөд тэрээр үйл ажиллагаа дутагдалтай явагдаж байгаа тухай дурдсан байна. Тухайлбал, ажлын байр дутмаг, тоног төхөөрөмж хангалтгүй, байгууллагын 24 ажилтны 80 хувь нь дөнгөж сургууль төгссөн мөрдөн шалгах туршлагагүй хүмүүс байна. Цаашилбал, Мөрдөн байцаах алба нь хэргийг зөвхөн прокуророос шилжүүлсэн тохиолдолд шалгаж байгаа бөгөөд өөрсдөө санаачлан мөрдөн байцаах ажиллагаа явуулах

боломжгүй юм. Тусгай Илтгэгч гаргасан гомдлыг нь барагдуулна гэдэгт итгэл муутай байдаг болохоор хохирогч хариу өшөө авалтаас эмээж гомдол бараг гаргадаггүй болохыг ажигласан байна.

42. Дээр дурдсан зүйлүүдээс харахад эрүүдэн шүүгдэж, хүнлэг бусаар хандах явдалд өртсөн хохирогчийг хамгаалсан эрх зүйн хамгаалалт, түүнчлэн хохирлыг нөхөн олгох болон сэтгэл зүйн хохирлыг нөхөн сэргээх байдал хангалтгүй, үр дүнгүй байна.

II. ХОРИХ БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

43. Тусгай Илтгэгч жирийн дэглэмтэй 0421 дүгээр хорих анги (Амгалан), чанга дэглэмтэй хорих 0413 дугаар хорих анги (Зүүнхараа)-ийн байранд очиход нөхцөл байдал нь олон улсын стандартад ерөнхийдөө нийцсэн байлаа. Эдгээр анги нь нээлттэй, нийтийн байрны хэлбэртэй байртай байсан бөгөөд харьцангуй сайн зохион байгуулагдсан байсан бөгөөд Тусгай Илтгэгч тэнд хүнлэг бусаар харьцсан тухай аливаа гомдол, мэдээллийг ял эдэлж байгаа хоригдлуудаас хүлээн аваагүй байна.

44. Улаанбаатар хот дахь цагдаагийн саатуулах байранд очсон өдөр 97 хүн хүлээн авах багтаамжтай байранд 7-30 хоног баривчлах ялтай 217 хүн байсан бөгөөд 72 цаг саатуулах байранд 48 хүн байлаа. Хоригдож байгаа хүмүүсийн талаас илүү хувийг газар унтуулж байлаа. Төвийн дарга Б.Очирбатын ярьж байснаар 8х6м хэмжээтэй уулзалтын нэг өрөөг 100 гаруй хүнд унтуулах газар болгон хэрэглэж байлаа. Оройн цагаар унтах дэвсгэр, хөнжлийг өгдөг бөгөөд өрөө нь хүйтэн, халаалт байхгүй байсан. 8-10 хүн хүлээн авах багтаамжтай 8 камер байсан бөгөөд тэдгээрийн нэг нь эмэгтэйчүүдийн камер байсан юм. Бие засах суултуур, угаалтуур зэрэг нь муу нөхцөлтэй байсан хэдий ч байр нь харьцангуй цэвэрхэн байлаа. Хүнлэг бусаар харьцсан тухай мэдээлэл байхгүй байсан боловч ихэнх нь хэт их хүнтэй, ялангуяа унтах бололцоо муу, оройн 7-11 цагийн хооронд задгай талбайд чимээгүй байхаас өөр ямар ч хийх ажилгүй нэг л хэвийн өдрийн хуваарьтай байна гэсэн гомдол гарчээ.

45. 0461 дүгээр Цагдан хорих анги (Ганц худаг), Цагдан хорих байр (Зуунмод)-д Тусгай Илтгэгч камерт хоригдож байгаа хүмүүсийн тоо хэт их байгаад сэтгэл зовниж байгаагийн дээр сэжигтэн, яллагдагчийг цуг хорьж байгаа нь Конвенцийн 10.2 (а)-г зөрчиж байна.

46. Гэхдээ Тусгай Илтгэгчийн хамгийн их сэтгэл зовниж байгаа асуудал бол 0405 дугаар хорих анги дахь гяндан (Тахир соёот), Цагдан

хорих байранд, тухайлбал Ганц худаг, Зуунмодод цаазаар авах ялыг гүйцэтгэхийг хүлээж байгаа ялтны нөхцөл байдал юм.

Үрт хугацааны хорих ялтай хоригдлуудад зориулсан онцгой дэглэм

47. Тусгай Илтгэгч 0405 дугаар хорих ангид 2005 оны 6 дугаар сарын 8-ны өдөр очсон байна. Энэ нь тус улс дахь ялтныг зөвхөн камерт нь байлгах зориулалт бүхий байр юм. Очсон өдрийн байдлаар 64 ялтан байсан бөгөөд тэдгээрийн 55 нь 2-5 жилийн хорих ялтай байсан бөгөөд 9 нь 30 жилийн хорих ялыг ганцаарчилсан байдалд эдэлж байна. Тэдгээр нь урьд нь цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүс байлаа. Ганцаарчлан хоригдож байгаа ялтнууд хоёр давхрын залгаа 9 камерт байсан. Камер тус бүр нь бие засах суултуур, угаалтуур, нэг ор, шалтай бэхэлсэн жижиг ширээ, радиатор, таазан дээр нээлтэй 30см х 2м хэмжээтэй цонх бүхий 3 х 3 талбайтай. Камер бүр нь хаалга болон төмөр сараалжин хаалгатай. Ялтнуудыг дээд тал нь долоон хоногт 2 удаа нэг цагаар гаргадаг ба энэ нь хүйтэн үед богинохон хандлагатай байдаг тухай өөрсдөө ярьж байсан. Тэдэнд жилд 2 удаа эргэлт авахыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд эргэлт бүр нь хэдхэн цаг үргэлжилдэг байна. Тэднийг гадагшаа гаргахдаа гарыг нь гавладаг бөгөөд эргэлтийн үед мөн гавлаж, дөнгөлдөг байна. Ялангуяа 30 жилийн хорих ялаар шийтгэгдсэн эдгээр хүмүүсийг 24 цагийн турш камерт нь чөлөөт цаг өнгөрөөх, боловсрол олох зэрэг сургалт, хүмүүжлийн ажиллагаа явуулахгүйгээр хорьдог байна. Камер тус бүрийн гадна талд суурилуулсан 9 телевизорыг оройн 6-11 цагийн хооронд үзүүлдэг байна. Тэд унших материал авч болно. Тусгай Илтгэгч ганцаарчлан хоригдож байгаа 9 ялтантай уулзаж ярилцсан бөгөөд цуглуулсан мэдээлэл нь ялтнуудын ярьж байгаатай нийцэж байсан юм. Тэнд хөлөндөө шаардлагатай эмчилгээ авч чадаагүй учраас ирснээсээ хойш тэргэнцэртэй байгаа нэг хүнээс өөр яаралтай эмнэлгийн тусламж авах гомдолтой хүн байсангүй. Хэдийгээр өмнө нь зоддог байсан тухай ноштой мэдээлэл Тусгай Илтгэгчид хэд хэд ирж байсан боловч харуул хамгаалалтын хүмүүсийн хүнлэг бусаар харьцаж байгаа тухай мэдээлэл байхгүй байсан. Очих үед хийх ажилгүй хоригдож байгаа хүмүүс илт гутрангуй, цөхөрсөн, амиа хорлох бодол төрдөг тухайгаа илэрхийлж байсан, зарим нь ингэж тусгаарлагдмал байснаас цаазаар авах ялаар шийтгүүлсэн нь дээр гэж ярьж байлаа.

48. Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар тусгаарлан хорих онцгой дэглэмийн талаархи ойлголт (бодлого) нь ялтныг засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн Конвенцийн 10 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгтэй зөрчилдөж байна. Тэдэнд ногдуулж буй ял шийтгэл нь тодорхой хугацаагаар хязгаарлагддаг бөгөөд тэдгээрийг хожим суллагдахад засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшихтэй холбоотой асуудлыг авч үзээгүй байна. Ялтныг байнга тусгаар байлгах нь аюулгүй байдлын шалтгаантай

гэж санагдахгүйгээр үл барам байгаа фактыг авч үзэхэд тусгаарлахын зорилго нь нэмэлт ял шийтгэл ногдуулж, хүнд зовлон шаналалд хүргэх шалтгаан болж байгаа нь харагдаж байна. Иймд Тусгай Илтгэгч энэ дэглэм нь эрүүдэн шүүх бус ч “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенци”-ийн 1 дүгээр зүйлд заасан хэргийг, хүнлэг бусаар харьцах явдал гэж дүгнэн үзэж байна.

49. Гянданд хоригдож байгаа ялтнуудтай холбогдуулан Тусгай Илтгэгч Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10 дугаар зүйлийг хангахаар авсан арга хэмжээ, түүнчлэн олон улсын стандарт тухайлбал, ялтанд үзүүлэх наад захын стандарт хэм хэмжээний талаар мэдээлэл хүссэн юм. 2005 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн албан захидалдаа Засгийн газар 2005 оны 8 дугаар сарын байдлаар Хорих 0405 дугаар ангид 69 ялтан ял эдэлж байгаа бөгөөд тэдгээрийн 9 нь 30 жилийн хорих ялтай, бусад нь 3-5 жилийн хорих ялтай байгаа тухай мэдэгджээ. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 215 тоот тушаалаар батлагдсан Хорих ангийн журмын дагуу эдгээр 9 ялтан байгалийн гэрэлтэй, 9м² талбай бүхий тусгаарласан өрөөнд байрлаж байна. Ялтнуудад шүд, нүд, зүрх судасны болон бусад төрлийн эмчийн үзлэг хийх зэргээр эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг. Мөн төрийн бус байгууллагуудын туслалцаатайгаар сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, урт хугацааны хорих ялтай ялтанд төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр сар бүр 20 ам.долларын тэтгэмж олгож Монголын хорих байгууллагын нийгэмлэг (ТББ)-ын дэмжлэгтэйгээр англи, франц хэлийн сургалтыг бас зохион байгуулдаг. Хорих байрны үйл ажиллагааг Хорих байрны журмын дагуу зохион байгуулж, ялтнаас гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох байгуулагад шилжүүлж шийдвэрлүүлдэг. Ялтныг өрөөнд нь гавладаггүй боловч гэр бүлийн хүмүүстэй нь уулзуулах болон салхинд гаргах үедээ Хорих байрны журмын дагуу гавладаг.

Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтан

50. Тусгай Илтгэгч Монгол улс дахь цаазаар авах ялыг тойрсон бүх нөхцөл байдал, ялангуяа төрийн нууц гэж үзэж байгаа явдалд гүнээ сэтгэл зовниж байна. Ялыг гүйцэтгэх тоо нэмэгдэж байгаа гэсэн мэдээлэл байгаа бөгөөд одоогийн байдлаар жилд 20-30 орчим хүн байгаа гэхдээ энэ нь албан бус статистик мэдээ юм. Ерөнхийлөгч, прокурор, шүүхийн дээд албан тушаалын хүмүүст удаа дараа хүсэлт гаргасан боловч Тусгай Илтгэгчид цаазаар авах ялаар шийтгэгдсэн, уучлагдсан, гүйцэтгэгдсэн хүмүүсийн тоо, нэр, албан ёсны мэдээлэл болон гүйцэтгэх цаг хугацаа, газрын талаархи мэдээллийг өгөөгүй юм. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүний гэр бүлийн нэг гишүүнийг ялтантай нэг удаа уулзахыг зөвшөөрдөг

ч гэр бүлийнхэнд нь ялыг гүйцэтгэх огноо, газрыг мэдэгддэггүй бөгөөд гүйцэтгэгдсэн цогцсыг оршуулахаар хүлээн авдаггүй байна. Ляшкевичийн Беларусын эсрэг хэрэгт: Хүний эрхийн хороо “ялыг гүйцэтгэх огноог тойрсон бүхий л нууцлал, оршуулах газар, цогцсыг оршуулахаар өгөхөөс татгалзаж гэр бүлийн гишүүдийг санаатайгаар тодорхой бус байдалд үлдээн, сэтгэл зүйн дарамтанд оруулах замаар айлган сүрдүүлж, шийтгэхэд хүргэж байгаа ... нь (гэр бүлийн гишүүдэд) хүнлэг бусаар хандаж байна” энэ нь Конвенцийн 7 дугаар зүйлийг зөрчиж байна гэж үзжээ. Тусгай Илтгэгчийн зүгээс Монгол улсад мөн ийм үнэлгээг өгч байна.

51. Тусгай Илтгэгч цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийг тусгаарлан, байнгын гав, дөнгөтэйгээр цагдан хорих байранд хорих, хангалттай хоол хүнс өгөхгүй байгаа тухай ноцтой мэдээллийг хүлээн авсан юм. Цаашилбал, тэрээр Ганц худаг, Зуунмод дахь Цагдан хорих байранд цаазаар авах ялаар шийтгэгдсэн хоригдож байгаа хүмүүстэй тухайлбал, Ганц худаг, Зуунмодын цагдан хорих байранд тус тусдаа хоригдож байгаа Баяржав, Сэдэдийн Батаа нарын талаар тодорхой, нарийвчилсан мэдээллийг олж авсан юм (хэргүүдийг хавсаргасан). Цагдан хорих бүх байруудад саадгүй нэвтрэн орох бүрэн эрхийг Засгийн газраас авсан боловч Ганц худаг, Зуунмодын Цагдан хорих ангийн дарга Сугаржав, Очирбат нар Тусгай Илтгэгчийн мэдээлэл цуглуулах бүрэн эрхийг илт зөрчиж, хоригдож байгаа хүмүүсийг эрүүдэн шүүх, хэргийг хүнлэг бусаар харьцсан тухай мэдээллийг шалгах явдалд санаатайгаар саад учруулсан юм. Тэд Тусгай Илтгэгчийг 2005 оны 6 дугаар сарын 8-9 өдөр очиход цагдан хорих байрны бүртгэлтэй танилцах, хүмүүстэй нь уулзуулахаас татгалзсан.

52. Үүний дараа Тусгай Илтгэгч Засгийн газраас сүүлийн гурван жилийн хугацаанд цаазаар авах ялаар шийтгэгдсэн, давж заалдаад шийдвэр хэвээр батлагдан ял гүйцэтгэхийг хүлээж байгаа хүмүүс, өршөөгдсөн хүмүүс, эдгээр ялтнуудын байрлаж байгаа нарийвчилсан байрлал болон гүйцэтгэгдсэн хүмүүс, тэдгээрийг хаана оршуулсан талаархи мэдээллийг хүссэн юм. Тусгай Илтгэгч цааш нь цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн хоригдож байгаа байрны нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөхийг хүссэн. Цаашилбал, Ганц худаг, Зуунмодын Цагдан хорих байрны дарга нараас хамтран ажиллахаас татгалзсан талаар тайлбар өгөхийг хүссэн юм. Бичиж байх хугацаанд Засгийн газрын зүгээс ямарваа нэг мэдээлэл ирүүлээгүй байна.

53. Засгийн газраас хамтран ажиллах явдал дутагдалтай байсан болохоор Тусгай Илтгэгч гэр бүлийн гишүүд болон төрийн бус байгууллагуудын өгсөн нотлогдсон мэдээлэл дээр тулгуурлан дүгнэлтийг хийсэн болно. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтан хэт тусгаарлагдсан байдалд байнга гав, дөнгөтэй хоригдож, хангалттай хоол хүнсээр

хангагдахгүй байгаа нь нэмэлт ял шийтгэл болж энэ нь “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенци”-ийн 1 дүгээр зүйлд заасан эрүү шүүлт гэж үзэж болохоор байна.

54. Цаашилбал, Тусгай Илтгэгчийн уулзсан цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн нэг болох Сэдэдийн Батаагийн хэргээр (1.7) нөхцөл байдал хир хатуу байгааг тодорхой харуулж байна. Тэрээр дараа нь эрүү шүүлтээс болж нас барсан гэж Тусгай Илтгэгч дүгнэсэн.

III. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

55. Тусгай Илтгэгч Засгийн газар сүүлийн жилүүдэд хүний эрхийн талаархи олон улсын стандартад Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг нийцүүлэхээр нэмэлт өөрчлөлт оруулан тодорхой арга хэмжээ авсан болохыг тэмдэглэж байна. Гэхдээ эдгээр заалтаас үл хамааран гэмт хэргийн сэжигтнүүдийг эрүүдэн шүүх, тэдэнтэй хүнлэг бусаар харьцах явдал байнга гарч, үйлдэгчид шийтгэл хүлээлгэхгүй байх, түүний хохирогчдыг хамгаалах хууль-эрх зүйн хамгаалалт, нөхөн олговор төлөх, нөхөн сэргээх зохистой үр нөлөө бүхий тогтолцоо практикт үгүйлэгдэж байна гэсэн дүгнэлтийг Тусгай Илтгэгч гаргаж байна

Иймд Тусгай Илтгэгч Монгол улсын Засгийн газарт дараахь зүйлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

- a) Өндөр албан тушаалын хүмүүс, ялангуяа хууль сахиулах үйл ажиллагаа явуулдаг албан тушаалын хүмүүст шийтгэл үзүүлдэггүй өнөөгийн практикийг эцэс болгож, төрийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт болон хэрцгий, хүнлэг бус харьцах явдлыг хүлээн зөвшөөрөхгүй, мөрдөн шалгадаг болохыг салаа утгагүйгээр тунхаглан зарлах;
- b) Эрүү шүүлтийн гэмт хэргийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлд заасантай нийцүүлэн тодорхойлж, ял шийтгэл нь эрүүдэн шүүхийн онц хүнд хэлбэртэй дүйцсэн байх;
- c) Хуулийн дагуу баривчлагдсан этгээдийг мөрдөн байцаагчийн хяналтанд шүүхээс цагдан хорих зөвшөөрөл авахын тулд хуульд заасан 48 цагаас хэтрэхгүй хугацаагаар саатуулан хорихгүй байх. Энэ хугацааны дараа тэдгээр хүмүүсийг өөр эрх бүхий байгууллагын хяналтанд цагдан хорих байранд шилжүүлэх ёстой. Тэнд мөрдөн байцаагчтай цаашид хяналтгүй холбоо барих явдлыг зөвшөөрөхгүй байх;

- d) Цагдан хорих бүртгэл хөтлөлтийг нягт хийх явдлыг хангах үүнд, баривчлах цаг хугацаа, газар, цагдаагийн ажилтны нэр, дугаар, цагдан хорих байр, цагдан хорих төвд ирэх үеийн эрүүл мэндийн байдал, гэр бүл, өмгөөлөгчтэй холбоо барих, цагдан хоригдож байгаа этгээд дээр ирсэн цаг хугацааг тэмдэглэх, цагдан хорих төвд авчрах болон шилжүүлэх үед эрүүл мэндийн шаардлагатай үзлэг хийх зэрэгт тэмдэглэл хөтлөх;
- e) Өмгөөлөгчийг байлцуулалгүйгээр цагдан хорих байранд байхдаа хийсэн болон шүүхийн өмнө нотлогдоогүй хэрэгт хэрэг хүлээх явдлыг хэрэг хүлээсэн хүний эсрэг нотлох баримт болгон хүлээн авахгүй байх. Мөрдөн байцаалтын өрөөнд явуулсан байцаан шийтгэх ажиллагааны үеэр бүх хүмүүсийг байлцуулан хийсэн видео болон аудио бичлэгийг давуу байдлаар авч үзэх хэрэгтэй;
- f) Шүүгч, прокурорууд цагдан хорих байрнаас авчирсан хүмүүсээс тэдэнтэй хэрхэн хандаж байсан талаар тогтмол асууж байх, хариуцагчаас албан ёсны гомдол байхгүй үед ч бие даасан эмнэлгийн үзлэг хийж байхыг тушаах;
- g) Эрүүдэн шүүх болон хэргий хүнлэг бусаар харьцсан тухай бүх мэдээллийг шуурхай, няхуур шалгах, хараат бус, эрх бүхий этгээд мэдээлэл өгсөн хохирогчийн эсрэг хэргийг мөрдөн байцаах болон шалгах явдалтай аливаа холбоо хамааралгүй байдлаар мөрдөн шалгаж байх. Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар Хүний Эрхийн Үндэсний Комисст энэ чиг үүргийг даалгаж болох юм;
- h) Төрийн албан хаагчаас хүч хэрэглэх замаар эрүүдэн шүүн ял хүлээлгэх явдал байгаа бөгөөд эрүүдэн шүүн хуйвалдах, нотлох баримтыг үл хайхрах явдалд оролцсон прокурор, шүүгч нарыг шүүх хуралдаан явуулах болон ялах үүргийг даруй түдгэлзүүлэх;
- i) Эрүү шүүлт, хэргий, хүнлэг бус харьцах явдалд өртөж хохирсон хохирогчид бодитой нөхөн олговор болон шаардлагатай эмчилгээ, нөхөн сэргээх нөхцөл бололцоо бүрдүүлэх;
- j) Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлтэй нийцүүлэн Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Конвенцийн заалтыг зөрчсөнөөс хохирсон этгээдээс гаргасан захидал харилцааг хүлээн авч хянан үзэх эрхийг хүлээн зөвшөөрсөн тунхаглалыг гаргах;
- k) Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүх хурлаар хэрэг нь орох гэж байгаа этгээдийг, ялангуяа хүнд биш хэрэг, насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэрэг, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хорих байранд хорьдог нийтлэг журмыг хэрэглэхгүй байж, цагдан хорихгүй батлан даалтад гаргах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх явдлыг нэмэгдүүлэх байдлыг хангах талаар нэмэлт өөрчлөлт оруулах. Шашилбал, цагдан хорих байранд хорих

хамгийн дээд хугацаа, ялангуяа 18 насанд хүрээгүй этгээдэд хэрэглэж байгаа хугацааг багасгах. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хамгийн эцсийн арга хэмжээ болгож, хамгийн богино хугацаагаар шүүгч авч байх;

- l) Удаан хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн ялтанд хэрэглэж байгаа одоогийн онцгой дэглэмийг эцэс болгож, эрх чөлөөгөө хасуулсан бүх этгээдийг Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм, Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10 дугаар зүйлд заасан засан хүмүүжүүлэн, дахин нийгэмшүүлэх зорилготой нийцүүлэн хорьж байх явдлыг хангах;
Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтныг Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн дагуу хорьж, ялангуяа цагдан хорих байранд байх үед нь гавлаж дөнгөлөхгүй байх;
- m) Цаазаар авах ялыг халах үүднээс цаазаар авах ялыг түр хойшлуулан оногдуулж байх болон Засгийн газар Иргэний болон улсын төрийн эрхийн тухай Пактын хоёр дахь нэмэлт Протоколыг соёрхон батлах хэрэгтэй;
- n) Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколыг соёрхон баталж, хараат бус хяналт шинжилгээний механизмыг бүрдүүлж, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс байдаг улсын хэмжээнд байгаа бүх газруудад очиж үзэж байх. Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар энэ механизм нь Хүний Эрхийн Үндэсний Комиссын хүрээнд байж болох юм;
- o) Хууль сахиулах байгууллагад шинээр ажилд орж байгаа хүмүүс хүний эрхийн боловсролтой холбоотой эрчимжүүлсэн, нарийвчилсан сургалтын хөтөлбөрт хамрагдсан байх бөгөөд сургалтад мөрдөн байцаах арга техник, цагдаагийн тоног төхөөрөмжийг зохих журмаар хэрэглэх зэргийг оруулж одоогийн офицерүүдийг үргэлжлүүлэн сургалтад хамруулах;
- p) Системчилсэн сургалтын хөтөлбөр, олон нийтийн мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх компанит ажлыг олон нийт, хууль сахиулах байгууллагын албан хаагчид, хуульч мэргэжилтнүүд болон шүүхийн ажилтнуудад зориулан Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн зарчмуудаар зохион байгуулах;

56. Тусгай Илтгэгч Засгийн газрыг олон улсын холбогдох байгууллага, тухайлбал НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газраас дээр дурдсан зөвлөмжүүдийн талаар цаашид авах арга хэмжээнд туслалцаа дэмжлэг хүсэхийг тус тус зөвлөж байна.

ХАВСРАЛТ

ТОДОРХОЙ ХЭРГҮҮД

Шалгалтын явцад дараахь хүмүүстэй уулзаж ярилцсан бөгөөд тэдгээрийн гомдлыг 2005 оны долдугаар сарын 20 болон наймдугаар сарын 2-ны өдрийн Засгийн газарт хандсан захидлаар хүргүүлсэн билээ. ЗГ 2005 оны есдүгээр сарын 22-ны захидлаараа тэдгээр захианд хариу ирүүлсэн болно.

1. Дамирангийн Энхбат 44 настай /өмнөх гомдол хариу ирээгүй E/CN/4/2004/56/add 1021-р хэсэг/. 2003 оны тавдугаар сарын 15-ны орчимд Францад цагаачлахаар очоод байсан Дамирангийн Энхбатыг Парисийн нэгэн рестораны өмнө ТЕГ-ын хэсэг ажилтан барьж зодоод элчингийн машинд суулган Бельги дэх Элчин сайдын яамаар дамжуулан улмаар Герман улсын ЭСЯ-ны байранд хүргэсэн байна. ЭСЯ-нд нэг хонуулахдаа ТЕГ-ын ажилтнууд түүнийг эрүүдэн шүүсэн бөгөөд маргааш нь дугуйт тэргэнд суулган МИАТ-ийн онгоцоор тавдугаар сарын 18-ны өдөр УБ руу авч одсон байна. Монгол улсын хилээр нэвтрэн орсон тэмдэглэгээ хийгдээгүй бөгөөд хотын гаднах нууц байранд хорьжээ. Ардчиллын удирдагч тухайн үедээ Дэд бүтцийн сайд асан С.Зоригийн аллагад түүнийг ял тулган эрүүдсэн хэдий ч хэрэг хүлээгээгүй байна. Тавдугаар сарын 24-нд түүнийг ТЕГ-ын мэдээлэгч гэж бүртгээд мөн сарын 25-нд хилээр нэвтэрсэн мэтээр бүртгэжээ. Олон цагаар сандал дээр суух, буугаар элгэн тус газар балбах, хуурамчаар цаазаар авах зэрэг арга байдлаар тарчлааж байжээ. 2003 оны 6 дугаар сард 58 настай өмгөөлөгч Лодойсамбуугийн Санжаасүрэн нь Д.Энхбаттай уулзах үеэрээ хэрхэн хулгайлсан, тарчлааж байсан талаар ярилцлага хийн 36 минутын видео бичлэгээр баримтжуулж чаджээ. Үүнийгээ есдүгээр сарын 27-нд Монголын 25 дугаар телевизийн сувгаар цацсан байна. Энэ нь хуучин тагнуулын ажилтан Лодойсамбуугийн Санжаасүрэнгийн эсрэг /эрүүгийн хуулийн 87/1/-ийн дагуу/ төрийн нууц задруулсан гэх хэргийг үүсгэх үндэслэл болжээ. 2004 оны 11 дүгээр сард уг хэргээр 18 сар хорих ял хүлээж Амгалан дахь 0421 дүгээр жирийн дэглэмтэй хориход ялаа эдэлсэн байна. Тусгай Илтгэгч 2005 оны зургадугаар сарын 7-нд зүрхний хүнд өвчтэйгээр эмчлүүлж байхад нь түүнтэй очиж уулзсан болно. Түүний мэдүүлж байгаагаар эмнэлгийн тусламж аваагүйгээс гадна тодорхой эм тариаг авч байгаагүй гэнэ. 2005 оны зургадугаар сарын 7-нд Зүүн хараагийн 0413 дугаар чанга дэглэмтэй хориход төрийн нууц задруулсан хэрэгт 3 жилийн ял эдэлж буй Д.Энхбаттай уулзсан. Хүний амийг санаатайгаар хороосон хэргийг угаас худал байсан тул хэрэгсэхгүй болгожээ. Уулзалтын үеэр хөндлөнгийн

эмчийн үзлэгт оруулахад амьсгал нь хүнд, шээс нь цустай, чичрэх зэрэг шинж тэмдэг нь биеийн байдал тааруухан болохыг илтгэж байна. Иймд яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай байна. Зайсан дахь хорих эмнэлэгт шилжсэн хэдий ч дорвитой эмчилгээ авалгүй эрс муудаж буй эрүүл мэндийн байдлыг эс харгалзан буцаасан байв. Д.Энхбатыг тарчлаан зовоож эрүүдэн шүүсэн гэх гомдлын хариу ирүүлэхийг Илтгэгч шаардаж байна. Энэхүү 2 хоригдол хоёулаа Ерөнхийлөгчид өршөөл хүсэн хандсан бөгөөд Тусгай Илтгэгч тэдгээрийн эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж хүнлэг хандах үүднээс өршөөл үзүүлэхийг Ерөнхийлөгчөөс хүсчээ. Үүний гадна төрийн нууц задруулсан гэх ял нь олон улсын хүний эрхийн талаархи хуулийг зөрчиж байна гэж үзэв. Өмгөөлөгчийн хувьд Л.Санжаасүрэн нь ТЕГ-аас тарчлаасан талаар ултай баримт цуглуулах, улмаар уг мэдээллийг олон нийтэд хүргэх эрхтэй байсан гэж үзэж байна.

2. 2005 оны 9 дүгээр сарын 2-нд ирүүлсэн хариунд Дамирангийн Энхбат нь хоригдож байх хугацаандаа зохих эмчилгээг авч байсан гэж Засгийн газар мэдэгдэж байна. Өнгөрсөн хугацаанд хорихын эмнэлэгт 8 удаа мөн бусад 1, 2, 3-р эмнэлгүүдийн мэргэжлийн тасагт эмчлүүлж хууль, дүрмийн дагуу хандаж байсан гэжээ. Гэвч Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар Энхбатыг олон улсын эрх зүйг ноцтойгоор зөрчиж шийтгэсэн тул нэн даруй суллах шаардлагатай гэж үзэж байна. Нөгөө талаас эрүү шүүлтийг хийсэн этгээдүүдийн эсрэг шүүх ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй.

3. Чингэлтэй дүүргийн шүүх нь Лодойсамбуугийн Санжаасүрэнг 18 сараар хорих ялаар шийтгэсэн тул 0421 дүгээр жирийн дэглэмтэй хориход ялаа эдэлж байна хэмээн ЗГ мэдэгдэв. Хагас ялыг эдэлсний дараа 2005 оны наймдугаар сарын 9-нд Баянзүрх дүүргийн шүүхээс урьдчилан магадлангаар түүнийг сулласан байна. 9 сар ял эдлэхдээ хорихын төв эмнэлэгт 72 өдрийг өнгөрөөсөн байна. Зүрхний эмчилгээг 3 дугаар эмнэлэгт хийлгэсэн юм байна. Урьдчилан магадлангаар сулласан явдлыг Тусгай Илтгэгч сайшаагаад өмгөөлөгчийнх нь хувьд бүрэн цагаатгахыг хүсч байна.

4. Баатарын Мөнхбаяр нь 35 настай. 2005 оны 5 дугаар сарын 17-нд ойролцоогоор 11 цагийн орчимд хүний амийг санаатайгаар хөнөөсөн хэрэгт сэжиглэгдэн Ганц худгийн 0461 дүгээр урьдчилан хориход Баянзүрх дүүргийн шүүх, прокурорын зөвшөөрөлтэйгээр баривчилсан байна. Ганц худагт ирэх үеийн эрүүл мэндийн үзлэгээр ямар нэгэн гаж зүйл тэмдэглэгдээгүй.

5 дугаар сарын 20-ны 11 цаг 50 минутад мөрдөгч Борхүү Баатарын гэр рүү утасдаж хүүгээ ирж авахыг хүссэн байна. Авахаар ирэхэд Мөнхбаяр нь ихээр зодуулж цус нөжтэйгээ холилдсон байжээ. Тэр даруй шүүх эмнэлэгт хүргэгдэн зураг авч эрүү шүүлтийг баримтжуулсан байна.

Дэргэд нь орших эмнэлэгт тархины зураг авахуулахад тархи гэмтэлтэй нь тогтоогдож мэдрэлийн тасгийн тархи нугасны хэсэгт оройн 5 цагт хэвтсэн байна. Мөнхбаяр 5 дугаар сарын 29-нд эмнэлэгт нас барсан.

Тусгай Илтгэгч баримт материал, тархины гэрэл зурагтай танилцжээ. 6 дугаар сарын 7-нд Ганц худагт очих үеэр түүний дарга Сугаржав хамтран ажиллахаас татгалзсан юм.

Гэсэн хэдий ч Тусгай Илтгэгч хорихын бүртгэлтэй танилцаж чадсан бөгөөд Мөнхбаярын гэр бүлийнхэнтэй 6 дугаар сарын 9-нд уулзаж амжсан байна. Хангалттай нотлох баримтын хүрээнд шалгалт хийсний үр дүнд Тусгай Илтгэгч Мөнхбаярыг эрүүдэн шүүсээр (түүний мөрдөнд очихоос хэд хоногийн өмнө) амь насыг нь хөнөөсөн байна гэсэн дүгнэлт хийжээ. Иймд уг хэргийг шүүн буруутныг шийтгэх талаар авч хэрэгжүүлсэн мэдээллээ ирүүлэхийг шаардаж байна.

5. 2005 оны 9 дүгээр сарын 22-нд илгээсэн захидалдаа Зүүн Хараагийн 0461 дүгээр хорихын хорих ангийн ажилтанг баривчилж, эрүүгийн хэрэг үүсгэсэн гэж мэдэгдсэн.

6. 41 настай Батжаргалын Баярбат нь 2001 онд үйлдсэн хэд хэдэн хүн амины хэрэгт 30 жилийн ялаа Тахир соёотын 0405 дугаар гянданд одоо эдэлж байна. 0405 дугаар ангид шилжигдэн ирэхээс өмнө Ганц худгийн урьдчилан хорих газарт 3 жил хоригдсон бөгөөд эрүүдэн шүүсний улмаас гэм буруугаа хилсээр хүлээсэн гэж гомдоллосон. 3 жилийн турш гав дөнгөтэй байж тамхины цогоор түлүүлж, бусад хоригдогч нартаа дээрэлхүүлж байжээ. Идэж ууж чадахгүй байсан тул 56 кг хүртэл турсан гэнэ. 2005 оны 6 дугаар сарын 8-нд очиж ярилцах үедээ хөндлөнгийн эмчийг авч очиж шалгуулахад бугуй, шагайн тус газар мөн бүх биеийн эргэн тойронд шарх сорви болсон нь түүний мэдүүлэгтэй тохирч байна. Ихээхэн жин алдсан болох нь илт байв. Тусгай Илтгэгч эрүүдэн шүүсэн талаар мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэхийг шаардсан. Түүнээс гадна ял нь эрүүдэн шүүх замаар хилсээр гэм бурууг хүлээлгэсэн гэх нотолгоон дээр үндэслэсэн тул ЭШЭК-ийн 15 дугаар зүйлд харшилж байгаа тул дахин шүүхээр хэргийг авч үзэх эсвэл суллах шаардлагатай.

7. Засгийн газрын мэдэгдэлд түүнийг төв хорих эмнэлэгт эмчилгээнд хамруулсан гээд ялаа эдэлснээс хойш жин алдаагүй одоогоор 59 кг бөгөөд эрүүл мэндийн байдал хэвийн гэж байв. Түүний Дээд шүүх, УЕПГ-т гаргасан өргөдлийг зохих газар шилжүүлсэн гэжээ. Гэвч Тусгай Илтгэгчийн үзэж байгаагаар гэм буруутайг нотлохдоо тарчлаан зовоосон тул уг хэргийг дахин шүүх, эсвэл Баярбатыг суллаж нөхөн олговор өгөх гэж үзэж байна.

8. Жирийн дэглэмтэй 0405-р хориход хоригдож байгаа Ганбаатар нь 2003 онд анх ирэхэд жагсаалд оройтсон хэмээн толгой руугаа бороохойдуулах тохиолдол гарч байсан бөгөөд үүнийг гол төлөв Цэндрагчаа, Бат-Эрдэнэ нар үйлдэж байжээ. Нэг удаа торонд гавлуулан зодуулсны дараа шөнөжин гавтайгаа хонож байжээ. 2005 оны 6 дугаар сарын 7-нд Тусгай Илтгэгчтэй ярилцах үеэр хамгийн сүүлд 5 дугаар сарын 27-нд зодуулахдаа сандалтай гавлагдан бороохойдуулсан гэж байв. Хөндлөнгийн эмчийн шалгалтаар нүүр, толгойн тус газар хөхрөлт байсан тул түүний мэдүүлэг үнэн зөв болохыг нотолж байна. Ганбаатарын хэлж байгаагаар гомдол саналыг эс тоодог гэнэ. Ерөнхийдөө хоригдлуудыг хянагч нар зодох нь хэвийн үзэгдэл болжээ. Тэд шалгагчийг тоогоогүй, шоронгийн дүрэм зөрчсөн, ажил хийхдээ цонхоор гөлөрсөн зэрэг үл ялих шалтгаанаар зоддог гэсэн байна. Шалгагч нарын хоол хийгээд амт нь таалагдахгүй шалтгаанаар зодуулсан тохиолдол гарчээ. Хоригдлууд эмчид хэлдэггүй бөгөөд үүний шалтгаан нь эмч, шалгагч нарт хэлснээр улам их зодуулах болдог юм байна. Зүй бус харьцааны талаар Тусгай Илтгэгч мэдээлэл хүссэн боловч хариу ирээгүй байна.

9. Сэдэдийн Батаа 37 настай. 2005 оны 6 дугаар сарын 9-нд уулзахыг хүссэн боловч Зуунмод дахь цагдан хорих төвийн дарга Очирбат олгосон эрх мэдлийг хөсөрдүүлэн уулзуулаагүй билээ.

Цаазаар авах ялаа хүлээх зуур тамлагдан зовж, 24 цаг гав гинжтэй байгаа талаар баттай эх сурвалж мэдээлж байна. 2005 оны 7 дугаар сарын 22-нд Батаа Зуун модоос 0405 дугаар ангид хүргэгдсэний дараа нас барсан байна.

Ийнхүү тарчлаан Сэдэдийн Батаагийн амийг хөнөөсний дараа 2005 оны наймдугаар сарын 2-ны захидлаар ЗГ-ыг НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газартай хамтран ажиллаж эдгээр хэргүүдийг шалгаж үзэхийг уриалаад /бүх газарт шаардлагатай хүн материалыг шалгуулах/ 15 хоногийн дотор хариу мэдэгдэхийг шаардсан. Эхлээд Сэдэдийн Батаатай Зуунмод дахь хориход уулзуулаагүй дараахи нь түүнийг тарчлааж байгаад амийг нь хөнөөсөн нотлох баримт байгаа нь Тусгай Илтгэгч энэ талаар ихээхэн зовинож байгаагаа илэрхийлж байна.

10. ЗГ нь хэргийг УЕПГ шалгаж байна гээд тодорхой шийд гарахаар мэдэгдэнэ гэжээ.

ТЭМДЭГЛЭЛ



НҮ ХХ нь илүү дээд шлага, нөөцийг хөгжүүлж, улс орнуудад өмнөд зүгийг олон нийтийн хөгжлөөр замаар илүү сайн амьдралыг доголлон байгуулахад хичээлт туслах зорилго бүхий НҮ -ын дэлхий нийтийн хөгжлийн сэлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 262971, 320284

Цахим шуудан:

Цахим хуудас: <http://www.mn-nhrc.org>